



**МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАМЖ БОЛОН ЭРСДЭЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ**

ЭЦСИЙН ТАЙЛАН

**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАВХЫГ
ДЭМЖИХ ЗОРИЛГООР ХОВД, ЗАВХАН АЙМАГТ БАЙГАА
МАЛЧДЫН ОРОЛЦООТОЙ БАЙГУУЛЛАГУУДЫГ ҮНЭЛЭХ НЬ**

Гүйцэтгэгч:



БОДЛОГО СУДЛАЛЫН ТӨВ

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн,
Жамъяан гүний гудамж, 12 байр, 4В, Улаанбаатар 14240
Утас: 77119027

e-mail: cpr@cpr.mn

Web: www.cpr.mn

**2022 оны 10-р сар
Улаанбаатар хот**

Агуулга	
Хүснэгтийн жагсаалт.....	5
Зургийн жагсаалт.....	5
Товчилсон үг.....	5
Тайлангийн хураангуй	6
Report Summary	10
НЭГ. ЕРӨНХИЙ	14
2.1 Бэлчээр ашиглуулах гэрээ	19
2.2 Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээ	20
2.3 Худаг эзэмшүүлэх гэрээ	20
2.3.1 Гэрээний шинэчилсэн загвар боловсруулсан талаар	20
2.3.2 Худаг эзэмшүүлэх гэрээ байгуулсан талаар	22
2.4 Ойн санг эзэмшүүлэх гэрээ	23
2.4.1 Гэрээний шинэчилсэн загвар боловсруулсан талаар	23
ГУРАВ. НӨӨЦ АШИГЛАЛТЫН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ .	25
ДӨРӨВ. НАБ, НАГ-ИЙН ТАЛААРХ СУРГАМЖ, ТЭРГҮҮН ТУРШЛАГА	26
4.1 Сургамж	26
4.2 Тэргүүн туршлага	27
ТАВ. НАГ -НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, НАБ-ИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ	29
5.1 НАБ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх зөвлөмж	29
5.2 НАГ-ний хэрэгжилтийг хангах зөвлөмж	32
5.2.1 Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэг цэгт төвлөрүүлэн чанарын хянан баталгаа хийлгэж, боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах зөвлөмж	32
5.2.2 Экосистемийн үйлчилгээний төлбөрийг нэвтрүүлэх нь.....	37
5.2.3 Сумын холбогдох албан тушаалтны ажил, үүргийн хуваарийг тодорхой болгож, хоорондын уялдаа холбоог хангах замаар бэлчээр, хадлан, усны нөөцийн менежментийг сайжруулах зөвлөмж	42
5.2.4 Хурга махлуулж, борлуулах замаар бэлчээрийн ачаалал бууруулж, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг дээшлүүлэх зөвлөмж	43
5.2.5 Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх бэлчээр ашиглалтын гэрээний үүргийн хэрэгжилтийг хангахад ашиглах эдийн засгийн тооцоо, зөвлөмж	46
5.2.6 Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн сангийн агуулга, хоорондын уялдааг сайжруулах замаар нөөц ашиглалтын бүлгийг бэхжүүлэх, нөөц ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангах зөвлөмж	49
5.2.7 Малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээрийг халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох зөвлөмж	50
ХАВСРАЛТ	52

Хавсралт 1 Төслийн үр дүнгийн товч танилцуулга.....	52
Хавсралт 2а Нөөц ашиглагчдын бүлэг байгуулах	57
Хавсралт 2б Нөөц ашиглалтын гэрээ байгуулах	60
Хавсралт 2.1 Нөөц ашиглалтын бүлгийн гэрээний талаарх саналын хуудас	65
Хавсралт 2.2 Нөөц ашиглалтын гэрээний төсөл дээр орон нутгаас гарсан санал, түүнийг гэрээний төсөлд тусгасан нь	66
Хавсралт 2.3 Худаг эзэмшүүлэх шинэчилсэн гэрээний танилцуулга.....	69
Хавсралт 2.3.1 Ховд аймаг, НАГ-г шинэчлэн боловсруулахад орон нутгаас санал авсан оролцогчдын нэрс, албан тушаал.....	73
Хавсралт 2.3.2 Завхан аймаг, НАГ-г шинэчлэн боловсруулахад орон нутгаас санал авсан оролцогчдын нэрс, албан тушаал.....	77
Хавсралт 2.4. Нөөц ашиглалтын Шинэчилсэн гэрээний загварууд.....	78
Хавсралт 2.4 А Нөөц ашиглалтын шинэчилсэн гэрээ байгуулсан байдлыг нэг нэг сумын жишээн дээр.....	92
Хавсралт 2.4.1 Бэлчээр ашиглуулах гэрээ Үенч сумыг жишээн дээр.....	92
Хавсралт 2.4.2 Худаг эзэмшүүлэх гэрээ Эрдэнэбүрэн сумын жишээн дээр.....	96
Хавсралт 2.4.3 Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээ Дөргөн сум	102
Хавсралт 5.1 Ховд аймаг, НАБ байгуулсан БИНХ-ын тогтоол, Засаг даргын захирамж	105
Хавсралт 5.2 Завхан аймаг, НАБ байгуулсан БИНХ-ын тогтоол, Засаг даргын захирамж.....	147
Хавсралт 6.1А Ховд аймгийн Малчдын бүлгийн гишүүнчлэл, Бэлчээр	204
Хавсралт 6.1Б Ховд аймгийн Малчдын бүлгийн гишүүнчлэл, Худаг	208
Хавсралт 6.1В Ховд аймгийн Малчдын бүлгийн гишүүнчлэл, Хадлан.....	209
Хавсралт 6.1Г Ховд аймгийн худаг ашиглагчдын бүлгийн байршил.....	210
Хавсралт 6.2А Завхан аймгийн Малчдын бүлгийн гишүүнчлэл, Бэлчээр.....	211
Хавсралт 6.2Б Завхан аймгийн Малчдын бүлгийн гишүүнчлэл, Худаг	220
Хавсралт 6.2В Завхан аймгийн Малчдын бүлгийн гишүүнчлэл, Хадлан.....	222
Ховд, Завхан аймагт төслийн хүрээнд байгуулсан НАБ-ийн ахлагч нартай холбогдох утасны жагсаалт	223
Хавсралт 6.2Г Завхан аймгийн худаг ашиглагчдын бүлгийн байршил	225
Хавсралт 3.1А НАБ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, НАБ бүрээр, Завхан аймаг	226
Хавсралт 3.1Б НАБ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, НАБ бүрээр, Ховд аймаг.....	242
Хавсралт 5.2.1А Нэг цэг болон НАБ-уудын байршил. Завхан аймаг	253
Хавсралт 5.2.1Б Нэг цэг болон НАБ-уудын байршил. Ховд аймаг	254
Хавсралт 5.2.3 Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээр, хадлан, ус/худгийн нөөцийн менежментийн арга хэмжээг тусгах ажил үүргийн хуваарь, график	255
Хавсралт 5.2.5А Малчдын бүлгүүдийн малын тоог жилд 5 хувиар бууруулах 5 жилийн төлөвлөгөө. Ховд аймаг	266

Хавсралт 5.2.5Б Малчдын бүлгүүдийн малын тоог жилд 5 хувиар бууруулах 5 жилийн төлөвлөгөө. Завхан аймаг.....	267
Хавсралт 5.2.5В Мал борлуулалсны урамшуулалд олгох экосистемийн үйлчилгээний төлбөрийн тооцоо, Ховд аймаг	268
Хавсралт 5.2.5Г Мал борлуулалсны урамшуулалд олгох экосистемийн үйлчилгээний төлбөрийн тооцоо, Завхан аймаг.....	270
Хавсралт 5.2.5Д Малчдын бүлгүүдийн бэлчээрийн даац хэтрэлт болон дутуу хооллолтын хувь, Ховд аймаг	271
Хавсралт 5.2.5Е Малчдын бүлгүүдийн бэлчээрийн даац хэтрэлт болон дутуу хооллолтын хувь, Завхан аймаг	272
Хавсралт 5.2.6б Нэгдсэн мэдээллийн санг шинэчлэх шаардлага, санал.....	274
Хавсралт 5.2.6а Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт илгээсэн албан тоот	279

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 5.2.4.1 Хурга борлуулснаар мах үйлдвэрлэл, орлого нэмэгдэж, шаардагдах бэлчээрийн тэжээлтийн хэрэгцээ багасгах нь, 100 хонь тутам

Хүснэгт 5.2.4.2 500 хоньтой малчин өрхийн хонины махны орлогын харьцуулалт

Хүснэгт 5.2.5.4 Малын тоог цөөлөх, барих, өсгөх сүргийн эргэлтийн үед эр малын тооны өөрчлөлт

Хүснэгт 5.2.5.3 Сумын бэлчээрийн даац, ачаалал, хонин толгойгоор

Хүснэгт 5.2.5.2 Малын тоог өсгөн өрхийн орлогыг нэмэгдүүлэх тооцоо

Хүснэгт 5.2.5.1 Малчин өрхийн малын тоо буурсан ч орлого нэмэгдэх тооцоо

Зургийн жагсаалт

Зураг 1.1 Малчдын хамтын ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрийг сайжруулах загвар, үе шатаар

Зураг 5.2.4.1 Хонины амьдын жингийн өөрчлөлт, жилээр, кг

Товчилсон үг

АДАПТ	Хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж, эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох төсөл
АБОАЖГ	Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар
БАГ	Бэлчээр ашиглалтын гэрээ
БАХ	Бэлчээр ашиглагчдын хэсэг
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
БНХМН	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл
БСТ	Бодлого судлалын төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭТ	Мал эмнэлгийн тасаг
НАБ	Нөөц ашиглагчдын бүлэг
НАГ	Нөөц ашиглалтын гэрээ
СБАХ	Сумын бэлчээр ашиглалтын хэсэг
ТХХТ	Төр-хувийн хэвшлийн түншлэл
ТХХНИТ	Төр-хувийн хэвшил- нутгийн иргэдийн түншлэл
ХААТ	Хөдөө аж ахуйн тасаг
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Тайлангийн хураангуй

Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулснаас хойш 4.5 сарын дараа буюу 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэх хуваарийн дагуу энэхүү эцсийн тайланг бэлтгэж, хүргүүлж байна.

Гэрээний удирдамжийн дагуу эцсийн тайланд дараах асуудлуудыг тусгайлан тусгасан болно. Үүнд:

- Нөөц ашиглах гэрээний (НАГ) шинэчилсэн загварыг боловсруулж нэвтрүүлэх,
- Нөөцийн хэрэглэгчийн бүлгүүд (RUGs) тус бүрээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах,
- Шинээр байгуулагдсан НАБ-д дэмжлэг үзүүлэх болон НАГ-ний хэрэгжилтийг хангах талаар зөвлөмж гаргах

Түүнчлэн дээрх асуудлуудтай холбоотой, мөн төр, хувийн хэвшлийн түншлэл, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн байгууллагууд зэрэг асуудлаар гэрээт ажил гүйцэтгэх хугацаанд гарсан сургамж, тэргүүн туршлагыг тайланд тусгалаа.

Энэхүү тайланд дурдсан асуудлуудыг авч үзэхдээ өмнө нь хүргүүлсэн эхлэлийн болон явцын тайланд тусгагдсан асуудлуудтай давхцуулахгүй байх зарчмыг баримтлав. Иймд гэрээний хүрээнд хийгдсэн бүх ажилтай танилцана гэвэл өмнө нь ирүүлсэн бусад тайлангуудыг нягталж үзэх шаардлагатай юм.

Бэлчээр ашиглуулах шинэчилсэн гэрээ. Байгалийн бэлчээрийн бүтээмж буурч, төлөв байдал нь доройтож байгаа сөрөг өөрчлөлтийн үндсэн шалтгаан болох ачааллыг багасгах олон талт арга хэмжээг цогцоор тусгах замаар бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх боломжтой. НАГ-ний үндсэн зорилго, агуулгыг бүлгийн малын тоог гэрээгээр ашиглуулах бэлчээрийн даацад төлөвлөгөөтэйгөөр цөөлж нийцүүлэхэд малчдыг экосистемийн төлбөр зэрэг урамшууллаар дэмжих, талууд гэрээнд ухамсартай хандаж хүлээсэн үүргээ биелүүлэх, тулгамдсан асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэхэд гэрээг тогтсон хугацаанд дүгнэж байх шаардлага зэрэг зангилаа асуудлыг тусгах замаар бэлчээр ашиглуулах гэрээний шинэчилсэн загварыг боловсруулсан болно. Малчдын 87 бүлэгтэй бэлчээр ашиглалтын гэрээ байгуулахад энэхүү шинэчилсэн гэрээний загварыг ашигласан болно.

Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээ. Өмнө нь мөрдөгдөж байсан гэрээг шинэчлэхдээ Монгол улсын "Газрын тухай хууль" "Байгаль орчныг хамгаалах тухай хууль", "Байгалийн ургамлын тухай хууль", "Байгалийн ургамал ашигласны төлбөрийн ухай хууль", "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль", "Газрын төлбөрийн тухай хууль", Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол, өвс, техникийн ерөнхий шаардлага MNS 0592:2008 зэргийг үндэслэл болгон хадлангийн зориулалтаар олгох газрын эзэмшил, ашиглалт, хамгаалалт, хяналт, тээвэрлэлтийн үйл ажиллагааны хүрээнд НАБ, төрийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар боловсруулав. Хадлангийн газрын эзэмшлийн гэрээнд гэрээнд газрыг хүлээлцэхдээ акт үйлдэн хүлээлгэн өгөх, хэрэгжилтэд жил бүр хяналт тавих, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг хадлангийн газраа сайжруулахад зарцуулах, бэлтгэсэн хадланг эхний ээлжид нөхөрлөлийн гишүүн малчид, сумын малчдад орон нутгийн ханшаар олгох, сумын өвсний фондод заавал хувь нэмэр оруулах зэрэг заалтуудыг тусгайлан оруулав. Гэрээт ажлын хугацаанд хадлангийн бүлгийн 5 гэрээг байгуулсан байна

Худаг эзэмшүүлэх гэрээ. НАГ байгуулах түүний дотор малчдын бүлэгт худгийг гэрээгээр эзэмшүүлэх ажлыг гүйцэтгэх талаар тусгагдсан чиглэл, худгийн эзэмшил, ашиглалтын хүрээнд хуримтлагдсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлага зэргийг харгалзан "Худаг эзэмшүүлэх гэрээ"-ний шинэчилсэн хувилбарыг боловсруулав. Энэхүү шинэчилсэн хувилбарын урьд өмнө худгийн талаар хийгдэж байсан гэрээнүүдээс ялгагдах гол шинж чанар нь худгийн эзэнгүйдлийг арилгаж, хариуцлагатай болгох, ашиглалтын төлбөрийг шударгаар тогтоож,

хураах замаар худгийн арчилгаа, засвар үйлчилгээ, нөхөн сэргэх хөрөнгийн эх үүсвэрийг баталгаажуулах, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн харилцааг тодорхой бөгөөд хэрэгжүүлэх боломжтой болгосонд оршино. Шинэчилсэн загварын дагуу Ховд, Завхан аймгийн хэмжээнд нийт 20 бүлэгтэй эзэмшүүлэх гэрээ байгуулагдав.

Ойн санг эзэмшүүлэх гэрээ Ойн санг эзэмшүүлэх гэрээний загварыг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолын хавсралт “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам”-ыг үндэслэн шинэчлэн боловсруулав. Ойн санг эзэмших гэрээнд доорх заалтуудыг нэмж оруулав. Үүнд: Эзэмшлийн ойн санд түймэр, хөнөөлт шавж, өвчин зэрэг гамшгийн хор уршгийг арилгахад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, санхүүгийн туслалцаа үзүүлэх, эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх, Ойн нөхөрлөлийн дундын сан байгуулах. гэх мэт

Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журамд заасан Багийн дарга, тухайн багийг хариуцсан байгаль хамгаалагч нь нөхөрлөлөөс ирүүлсэн материалыг үндэслэн нөхөрлөлийн эзэмших ойн сангийн ойн талбайн хэмжээг сум дундын ойн ангитай хамтран /ойн зураг дээрх хэсэглэл, ялгарал/-р гарган тэмдэг даран баталгаажуулах, сумын засаг даргын түвшинд хийх ажлууд ихээхэн цаг хугацаа, мэргэжлийн байгууллагын оролцоо, санхүүжилт хэрэгтэй тул шинэ ойн нөхөрлөл байгуулах ажлыг төслийн богино хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй байв

Үйл ажиллагааны төлөвлөгөө. “АДАПТ” төсөлтэй ямар чиглэлээр хэрхэн хамтран ажиллах, ялангуяа уг төслөөс хүлээж буй дэмжих үйл ажиллагаа, холбогдох санхүүжилт, зөвлөгөө авах талаар нөөц ашиглалтын бүлгүүдээс тавьсан хүсэлтийг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэлбэрээр нэгтгэлээ. Бүлгийн ажиллах хүчний байдлаас гадна ашиглалтын гэрээ байгуулсан нөөцийн төрөл, бүтээмж (бэлчээрийн тэжээлийн нөөц, худгийн ашиглалт, хадлангийн ургац гэх мэт) ба малын тоо, тухайн нөөцийн хангамж/хүрэлцээний мэдээллийг төлөвлөгөөнд тусгав. Бэлчээрийн доройтлыг сааруулах, цаашилбал нөхөн сэргээх чиглэлээрх гэрээний зорилтыг хангахын тулд хонин толгойд шилжүүлснээр малын тоог жилд 5 хувь бууруулах, “АДАПТ” төслөөс гаргах дэмжлэгийн хэмжээ, нийт санхүүжилтийн тодорхой хэсэг, тодруулбал 10-30 хувьтай тэнцэх хөрөнгийг НАБ гаргах боломжтой зэрэг тооцоо, түүнчлэн төлөвлөгөө хэрэгжүүлэх эхний жил буюу 2023 онд бэлчээрийн ачааллыг бууруулах зориулалттай экосистемийн үйлчилгээний төлбөрийг туршихаар тусгав. НАБ-ийн хүсэж буй дэмжлэгийн хэмжээг орон нутгийн ба нийтлэг жишгийг харгалзан төгрөгөөр илэрхийлсэн болно.

НАБ-г бэхжүүлэх, НАГ-н хэрэгжилтийг хэрэгжилтийг хангах талаарх зөвлөмж

Гэрээт ажлын хүрээнд хийсэн үнэлгээ, судалгаа, орон нутгаас гарсан саналуудыг нэгтгэн НАБ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх, НАГ-ний хэрэгжилтийг хангах талаар дараах зөвлөмжүүдийг гаргаж байна. Үүнд:

- Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэг цэгт төвлөрүүлэн чанарын хянан баталгаа хийлгэж, боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах
- Экосистемийн үйлчилгээний төлбөрийг нэвтрүүлэх
- Сумын холбогдох албан тушаалтны ажил, үүргийн хуваарийг тодорхой болгож, хоорондын уялдаа холбоог хангах замаар бэлчээр, хадлан, усны нөөцийн менежментийг сайжруулах
- Хурга махлуулж, борлуулах замаар бэлчээрийн ачаалал бууруулж, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг дээшлүүлэх
- Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх бэлчээр ашиглалтын гэрээний үүргийн хэрэгжилтийг хангахад ашиглах эдийн засгийн тооцоо
- Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн сангийн агуулга, хоорондын уялдааг сайжруулах замаар нөөц ашиглалтын бүлгийг бэхжүүлэх, нөөц ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангах

Зөвлөмжийн товч агуулгыг доор оруулав.

НАБ-г бэхжүүлэх зөвлөмж

Нөөц ашиглалтын бүлгийн үйл ажиллагааг бэхжүүлэх зөвлөмжийн зорилго нь бүлгийн засаглал, хүний нөөц, ил тод байдал, эргэх холбоо, санхүүгийн чадавхыг сайжруулах, ажлаа төлөвлөдөг, тайлагнадаг горимд шилжих, малын тоо толгойг бууруулах замаар бэлчээрийн даац, ачааллыг хөнгөвчлөх, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах, малын хашаа, саравчийг засварлах, малын өвс, тэжээл, усны хангамжийг сайжруулах, мод, бут, сөөг тарьж ашиглах замаар тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд малчид, мал сүргийн дасан зохицох чадварыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэг цэгт төвлөрүүлэн чанарын хянан баталгаа хийлгэж, боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах зөвлөмж

Урамшууллын хөшүүрэг, механизм тогтоогүй учраас малаа хотноосоо мал, махны ченжүүдэд бага үнээр худалддаг тэрхүү байдлаас үүдэн малчид өртгийн сүлжээний хүрээнд хамтран ажилладаггүй гол шалтгаан байсаар ирсэн билээ. Борлуулах малаа малчид өөрсдөө төвлөрсөн нэг цэгт авчран хянан баталгаажуулалтад оруулан гарал үүслийн ба эрүүл мэндийн гэрчилгээ авдаг, баталгаа бүхий малыг түнш боловсруулагчид хэлцлийн үнээр худалддаг борлуулалтын шинэ тогтолцоог нэвтрүүлж төлөвшүүлэхэд малчдыг хөхүүлэн дэмжих зорилгын дор нэг цэгээр мал худалдан борлуулах зорилгоор нэг цэгийг байгуулах юм.

Экосистемийн үйлчилгээний төлбөрийг нэвтрүүлэх зөвлөмж

Экосистемийн үйлчилгээний төлбөр /ЭСҮТ/ гэдэг нь усны хагалбар, ой хамгаалахаас эхлээд нүүрс хүчлийн хийг шингээх, үзэсгэлэнт байгалийг хамгаалах зэрэг байгаль орчны үйлчилгээ үзүүлэх ашиг сонирхолтой төрийн зүгээс өөрийн ашиглаж байгаа газар дээр эдгээр үйлчилгээг үзүүлж байгаа этгээдэд олгож байгаа татаас, төлбөрийн тогтолцоо юм.

ЭСҮТ-г Монгол орны байгаль орчныг хамгаалах, малчдын амьжиргааг тогтвортой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг даван чадвартай болгоход хамгийн үр өгөөжтэй хэрэглэх арга зам нь байгальд ээлтэй аргаар буюу малын тоог бус ашиг шим, борлуулалтыг нэмэгдүүлэх замаар орлогоо өсгөж байгаа малчдад олгох урамшуулал гэж үзэн энэхүү зөвлөмжийг санал болгож байна.

Сумын холбогдох албан тушаалтны ажил, үүргийн хуваарийг тодорхой болгож, хоорондын уялдаа холбоог хангах замаар бэлчээр, хадлан, усны нөөцийн менежментийг сайжруулах зөвлөмж

Сумын түвшинд МАА-н үйлдвэрлэлд ашиглагддаг байгалийн үндсэн нөөц болсон бэлчээр, хадлан, ус/худгийн менежментийн нөхцөл байдлыг тодорхойлбол төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын эзэн, зохицуулалт тодорхойгүйгээс энэ ажил үндсэндээ урсгалаараа явж, тогтвортой ашиглалт, хамгаалалт орхигдож ирсэн байна. Байгалийн нөөцийн менежмент нь сумын ИТХ, Засаг дарга, газрын даамал, ХАА-н тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, БОУХБ, байгаль хамгаалагч, НАБ зэрэг олон талуудын идэвхтэй хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх бөгөөд гол хэрэгсэл нь сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө юм. Холбогдох хууль, журамд нийцсэн албан тушаалтны оролцоо, чиг үүргийг хэрэгжүүлэх үе шат, хугацааг харуулсан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах ажил үүргийн хуваарь, графикийн үлгэрчилсэн загварыг төслийн сумдад хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Хурга махлуулж, борлуулах замаар бэлчээрийн ачаалал бууруулж, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг дээшлүүлэх зөвлөмж

Жилээс жилд мал сүргийн тоо өсөөд байгаагийн нэг бодит шалтгаан нь дутмаг тэжээллэгтэй байгаагаас үүдэн мал тухайн насныхаа жинд хүрэхгүй болж, өсвөр насны буюу төлөг,

борлонгийн борлуулалт байхгүй болж нас гүйцсэн буюу 4 нас хүрч байж борлуулах жинд хүрч байгаагаас бэлчээрт байх малын тоо олшрох гол хүчин зүйл болж байна.

Малчдын ашиг орлогыг бууруулахгүйгээр малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх дөт зам нь хонийг эрт төллүүлэн, төллөсөн эх малыг тэжээж жилбэжүүлэн, сүү шимээр дамжуулан хургыг махлуулан эдийн засгийн эргэлтэд оруулах явдал бөгөөд энэ талаарх тодорхой зөвлөмжийг санал болгож байна.

Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх бэлчээр ашиглалтын гэрээний үүргийн хэрэгжилтийг хангахад ашиглах эдийн засгийн тооцоо

Малын тоогоор хөөцөлдсөн малчдын сэтгэлгээг хөрөнгө, орлогоо өсгөх гэсэн эдийн засгийн сонирхлоор нь дамжуулж өөрчлөхөөс өөр гарц байхгүй юм. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх нь өөрсдөд нь ямар ашигтай болохыг эдийн засгийн бодит тооцоон дээр үндэслэн малчдад ойлгуулж чадвал малчид малынхаа тоог цөөлөх алхмыг зоригтой хийж, бэлчээр ашиглалтын гэрээний үүргээ биелүүлдэг болохыг туршлага харуулсан тул энэхүү тооцоог ашиглахыг зөвлөж байна.

Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн сангийн агуулга, хоорондын уялдааг сайжруулах замаар нөөц ашиглалтын бүлгийг бэхжүүлэх, нөөц ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангах зөвлөмж

Байгалийн нөөц ашиглалтын талаарх мэдээллийг өөр өөр байгууллага тусдаа бүртгэдэг явдал нь мэдээллийн нэгдмэл байдлыг хангахгүйгээр тогтохгүй байгалийн нөөцийн менежментийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Иймд төлөвлөлт, шийдвэр гаргалт, үнэлгээ, тайланг нэгдсэн цахим системд байршуулах, сумдын ЗДТГ болон ИТХ-ын үйл ажиллагаа, захирамж, шийдвэр, тогтоол тэдгээрийн хэрэгжилтийг мэдээлж байдаг цахим системийг одоо байгаа (татварын, мал эмнэлгийн, газрын, ус цаг уурын, статистикийн) системүүд дээр суурилж хөгжүүлснээр сумын хэмжээнд хоорондоо уялдаа холбоо байхгүй, салангид байдлаар ашиглагдаж буй мэдээллийн тогтолцоог нэгтгэсэн байдлаар ашиглах боломж бүрдэх юм. Ийм тогтолцооны саналын хувилбарыг санал болгож байна.

НАБ-ийн гэрээт бэлчээрийг халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох зөвлөмж
Завхан, Ховд аймгийн бүх суманд АДАПТ төслийн хүрээнд шинээр байгуулагдсан малчдын бүлгүүдээс сонгон гэрээт бэлчээрийн хэмжээнд нь малын халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох нь малын мах, түүхий эдийг нь зах зээлд үнэ хүргэж борлуулах, малын тоог бууруулан малчдын орлогыг нэмэгдүүлэх, бэлчээрийн даац, ачааллыг хөнгөвчлөх, малынхаа эрүүл мэндийн төлөө малчид, малын эмч нарын оролцоог улам нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой арга хэмжээ болно.

Report Summary

This is a final report which was prepared and submitted according to the schedule to be delivered by October 15, 4.5 months after the signing of the consultancy service contract.

In accordance with the contract guidelines, the final report specifically addressed the following issues:

- Develop and introduce a revised model of resource use agreement (RUA),
- Develop an action plan by each of the resource user groups (RUGs),
- Making recommendations on ways to support the newly established RUGs and to implement the RUAs.

In addition, the report outlines the lessons learned and potential best practices related to the above issues, as well as issues like public-private-partnership (PPT) and livestock producers' organizations.

In addressing the above-mentioned issues in this report, the principle to avoid any overlaps with the content of the previously submitted inception and progress reports was applied. Therefore, in order to get more details about all the work undertaken within the framework of the contract, it is appropriate to reconnoiter the other reports previously submitted.

The enforcement of **pastureland RUAs** and their effectiveness can be improved by comprehensively incorporating key measures towards the reduction of overgrazing and other negative burdens on pastures. The main conceptual goals and content of the agreement is to support herders with incentives such as payments for ecosystem services to encourage them towards reducing the herd size. The RUA highlights the importance of being the parties be conscientious and dutiful in fulfilling their obligations under the agreement, and the need to evaluate the agreements on a regular basis to capture and solve the accumulated problems promptly. This updated agreement was introduced for 87 herder groups in project 2 aimags.

To revise the existing **hay land possession agreement**, all the relevant legislations such as the Law on Land, the Law on Environmental Protection, the Law on Natural Plants, the Law on Plant Usage Fees, the Law on the reinvestment of natural resource usage fees toward environmental protection and restoration of natural resources the Law on Land Use Payment, and the Government Resolution No. 28 of 2003, and relevant issues of the General requirements for hay and technical requirements MNS 0592:2008 were explored as the legal environment. It was developed to regulate the relationships between the partnerships and the government organizations regarding the possession, use, protection, control of the land allocated for the purpose of haymaking as well as transportation of hay. The new entries of the revised hay land possession agreement include the requirement to hand over the hay land quality characteristics when initially contracted, annual monitoring of the agreement enforcement, regulations to use the revenues from natural plant usage fee back for improving the hay land, the requirement to supply hay first of all to member herders and the soum herders at the local prices, as well the requirement to contribute to the soum emergency fodder fund. This updated agreement was introduced for 5 herder groups in project 2 aimags.

An updated version of the **well possession agreement** was developed, taking into account the objectives of the establishment of RUGs, including the instructions for contracting the well for possession by the herder group, and the need to solve the problems accumulated in the possession and use of the well. The main features of this updated version that are different from the previous agreements for wells include ensuring the ownership mentality and accountability, the source of funds for the care, maintenance and rehabilitation of wells by determining and collecting use fees fairly, and clear relationships between owners, owners and users. As per date, the revised model has been signed by a total of 20 well possessors' groups in the Khovd and Zavkhan aimags.

The Contract for the possession of **forest reserves**. The model of the contract for possession of forest reserves was updated based on the annex to the Resolution No. 227 of 2009 of the Government of

Mongolia "Procedures for the possession of forest reserves under the contract". The existing contract for the possession of the forest reserve was amended with the following issues, including mobilization of citizens, economic entities and organizations and providing financial supports for the eradication of the consequences caused to forest reserves possessed, by disasters such as fires, harmful insects, and diseases, fuelwood cutting by the possessors permitted in the forest management plan and certificate, use of forest by-resources, sale of surplus fuelwoods and forest by-resources, settle the payment for the use of timber and firewood within date specified in the contract and establishment of a revolving fund by forest partnerships, etc.

In accordance with the rule for the contracting of the forest reserve for possession, the Governor of the bagh and the ranger in charge of baghs, based on the materials submitted by the partnership, together with the intersoum forest department, determine the size of the area within the forest reserve that will be possessed by the partnership and officially confirm by sealing, as well as the actions to be taken require at the soum Governor level require more time for processing, and direct involvement of professional organizations, and appropriate funding. Due to these , it was not possible to complete the work of establishing new forest partnerships in the short period of time of implementation of the Consultancy service.

According to the schedule, **an action plan** for the support of newly established RUGs into better adaptation to the climate change and mitigation of common risks as a part of their common livestock production practices. Intentions and ideas expressed/suggested by newly established RUGs on how to cooperate with the ADAPT project, especially supports with funding and technological support and advices expected from the project, have been compiled in the form of an action plan. In addition to the workforce status of the group, the type and productivity of contracted resources (pasture forage resources, well utilization, hay land yield, etc.) and the adjustment of livestock number to the carrying capacity of pastures, availability and use of those resources are included in the plan. The plan provides calculations such as annual reduction of herd size by 5 percent in terms of sheep units so as to diminish the pasture degradation and to meet the goals to properly use and rehabilitate the contracted pastures under the RUA. As the RUGs express, they are pleased to make contribution equal to certain portion, more specifically 10-30 percent of the total financing. The plan considers piloting an incentive mechanism in 2023, the first year of the action of the plan, for the payments for ecosystem services in the form of livestock sales bonuses to reduce grazing pressures. The amount of support requested by RUGs is expressed in MNT, taking into account local and common market prices.

Recommendations on implementation of RUA and strengthening the RUGs

The following recommendations are made to strengthen the activities of the RUGs and ensure the implementation of the RUAs by summarizing the assessments and local suggestions made within the framework of the assignment. They include:

- Strengthening the activities of RUGs
- Single point for livestock and livestock product quality examination, certification and sales
- Payment for ecosystem services
- Improving the management of pastures, hay and water resources by clarifying the schedule of work and duties of the relevant local officials and ensuring coordination between them
- Fattening and selling lambs, thus reducing grazing pressures, increasing meat production, and improving the herders' livelihoods
- Economic calculations to be used to ensure the implementation of the obligations of the pasture use contract to match the number of animals to the carrying capacity of the pasture
- Strengthening the RUGs and improving the enforcement of RUAs by enhancing the content and coordination of the natural resource use databases
- Establishing disease-free status for pastures under agreement with herder groups

A short description of recommendations is provided below.

Strengthening the activities of RUGs

This aims at the strengthening of the core activities of RUGs by improving the group's governance, human resources, transparency, accountability, and financial capacity in order to facilitate the shifts to an approach that integrates the planning and reporting upon the activities, to initiate measures towards herd size minimizing, to decrease grazing and other burdens on pastures and to reduce greenhouse gas emissions. The proposed activities cover Improving livestock health and productivity, maintenance of livestock infrastructures such housing and fences, improving the feed supply and water to livestock, planting trees, bushes, and shrubs, and improving the adaptability of herders and livestock to climate change by producing value added products.

Single point for livestock and livestock product quality examination, certification and sales

Due to the fact that there is no incentive mechanisms, herders sell their livestock and raw materials at low prices to changers at their camp sites, which has been the main reason why herders do not cooperate within the value chain. A single point will be established for the purpose of buying and selling livestock and raw materials at one point, with the aim to introduce a new procurement system in which herders bring their animals to be sold to a centralized point for examination and certification, obtain origin and health certificates, and sell guaranteed products to partner processors under partnership agreements.

Recommendations for introducing payments for ecosystem services

Payment for ecosystem service (PES) is a system of subsidies and payments provided by the government to those who provide these services on the land they use, from the protection of watersheds and forests to the absorption of carbon dioxide and the protection of beautiful nature. It is proposed that the most effective way to use the PES to protect the environment in Mongolia and make the livelihood of herders sustainable and able to cope with the negative consequences of climate change is to provide incentives to herders who increase their income in an environmentally friendly way, not by increasing the number of animals, but by increasing profits and sales.

Improving the management of pastures, hay and water resources by clarifying the schedule of work and duties of the relevant local officials and ensuring coordination between them

The management of pastures, hay, and water/wells, which are the main natural resources used in livestock production, is undertaken without clear responsibility mechanisms and poorly coordinated across involved agencies and officials, which contributes to inefficient use and protection. Natural resource management should be implemented through the active cooperation of many parties, such as the soum council, the governor, land officers, experts in charge of pastures of the soum agricultural unit, environmental inspectors, rangers, and RUGs and the main tool is the annual soum land management plan. It is recommended to implement a model task schedule and calendar of activities to be included in the annual soum land management planning, which shows the clear labor division, tasks, and time for the participation of officials in accordance with the relevant laws and regulations.

Fattening and selling lambs, thus reducing grazing pressures, increasing meat production, and improving the herders' livelihoods

One of the real reasons why the number of herds is increasing year by year is that due to lack of nutrition, the animals do not reach the slaughter weight at earlier ages, and the sale of young animals is not possible. The shortest way to reduce the number of animals without reducing the herders' income is to calve the sheep early, feed the ewes for a year and fatten the lambs through milking, and specific recommendations are offered in this regard.

Economic calculations to be used to ensure the implementation of the obligations of the pasture use contract to match the number of animals to the carrying capacity of the pasture There is no other way to change the mentality of herders, who are driven by the number of animals, through their economic interests to increase their wealth and income. It is recommended to use this calculation because experience has shown that if the herders can understand how beneficial it is for them to reduce the number of animals in line with the carrying capacity of the pastures, based on actual economic calculations, the herders will take steps to reduce the number of animals boldly and fulfill their obligations under the pasture use contract.

Strengthening the RUGs and improving the enforcement of RUAs by enhancing the content and coordination of the natural resource use databases

The fact that different organizations record information about natural resource use separately has a negative impact on the planning, implementation, and monitoring of natural resource management, which is unstable without ensuring the integrity of the information. Therefore, the existing electronic database systems (tax, veterinary, land, hydrometeorological, statistical) that inform the implementation of planning, decision-making, evaluation, and reports, actions, orders, decisions, and resolutions of the soum khural and the Governor's office need to be developed and converted into an integrated electronic system. This will enable the use of integrated information system by changing the existing system in which separate sectoral systems are not connected to each other. A version of such a system is proposed.

Establishing disease-free status for pastures under agreement with herder groups

In all soums of Zavkhan and Hovd aimags, within the framework of the ADAPT project, a sample of newly established herders' groups should be selected for certifying their contracted pastures as free of infectious diseases. This will enable to sell meat and raw materials at higher prices, to increase the income of herders. It will be an important measure to ease the pasture pressures and increase the participation of herders and veterinarians for the health of their animals.

НЭГ. ЕРӨНХИЙ

Энэхүү эцсийн тайланг гэрээнд гарын үсэг зурснаас хойш 4.5 сарын дараа буюу 10-р сарын 15-ны дотор багтаан тушаах хуваарийн дагуу бэлтгэн хүргүүлж байна.

Гэрээний удирдамжид заасны дагуу эцсийн тайланд дараах асуудлыг онцгойлон тусгав. Үүнд:

- Нөөц ашиглалтын гэрээний шинэчилсэн загварыг боловсруулж, нэвтрүүлэх
- Нөөц ашиглалтын бүлгээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах
- Шинээр байгуулсан нөөц ашиглалтын бүлэг, нөөц ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангах талаар зөвлөмж гаргах

Түүнчлэн гэрээт ажлын хугацаанд дээрх асуудалтай холбогдон гарсан сургамж, тэргүүн туршлага болон төр, хувийн хэвшлийн түншлэл /public-private-partnership, PPT/, малчдын үйлдвэрлэлийн байгууллагын асуудлыг тусгав. Төслийн үр дүнгийн товч танилцуулгыг Хавсралт 1-г үзүүлэв.

Энэхүү тайланд дээр дурдсан асуудлуудыг хөндөхдөө урьд хүргүүлсэн эхлэлийн болон явцын тайлангуудад дэлгэрэнгүй тусгасан асуудлуудтай давхцуулахгүй байх зарчмыг баримтлав. Иймд гэрээт ажлын хүрээнд хийгдсэн бүх ажилтай танилцана гэвэл энэхүү тайлангаас гадна урьд тушаасан бусад тайлангуудын агуулгыг харах шаардлагатайг дурдвал зохино.

Тайлангийн холбогдох бүлгүүдэд бусад асуудлыг дэлгэрэнгүй тусгасан тул энэхүү хэсэгт төр, хувийн хэвшлийн түншлэл /public-private-partnership, PPT/, малчдын үйлдвэрлэлийн байгууллага /herders' producer organization, НПО/-ын асуудлыг авч үзэв.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмын талаар.

Төр, хувийн хэвшлийн түншлэл /ТХХТ/ нь төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын урт хугацаанд тогтвортой хамтран ажиллах загвар бөгөөд энэхүү хамтын ажиллагаа нь гэрээ, санамж бичиг зэрэг албан бичиг баримтаар баталгаажсан бол илүү гэж үздэг.

Хамтран ажиллах үндэслэл нь хамтран ажилласнаар ТХХТ-ийн хүрээнд тавьсан зорилгоо хэрэгжүүлэхэд тус тусдаа ажилласнаас илүү үр дүнтэй байдаг оршдог байна. Өөрөөр хэлбэл оролцогч талууд харилцан бие биеэ дэмжиж, дутуугаа нөхөх зарчмаар ажилладаг байна.

ТХХТ-н давуу тал нь дараах зүйлд оршдог. Үүнд:

- Хувийн хэвшилтэй хамтран ажилласнаар төр бусад тохиолдолд ашиглах боломжгүй технологи, мэдлэг, арга барилыг ашиглах боломжтой болдог
- Хувийн хэвшилтэй хамтран ажилласнаар төслийн тогтвортой байдал, үр ашиг нэмэгддэг
- Хөгжиж буй орнууд олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг түлхүү олгодог
- Хувийн хэвшилд итгэх олон нийтийн итгэлийг сэргээж, нэр хүнд нь дээшилдэг
- Хувийн хэвшлийнхэн хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хүрэн дахь шинэ мэдлэг, туршлагыг хуваалцах боломжтой болдог байна

Төр-хувийн хэвшил- нутгийн иргэдийн түншлэл (PPCPs буюу ТХХНИТ) нь төр-хувийн хэвшлийн түншлэлийн шинэлэг хэлбэр бөгөөд хувийн хэвшлийн зүгээс зөвхөн ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэхэд анхаарах бус орон нутаг, нутгийн иргэдийн хөгжилд анхаарлаа хандуулах шаардлагаас үүдэн гарсан байна. ТХХНИТ-н нөхцөлд нутгийн иргэд, төр, захиргааны байгууллага аливаа төсөлд төлөвлөхөөс нь эхлээд хэрэгжүүлэх, мониторинг хийх бүх шатанд оролцож, орон нутгийн “өмчлөл”, оролцоо, хүртэх өгөөжийг нэмэгдүүлдэг байна. ТХХНИТ-н зарчмыг нэвтрүүлснээр аливаа төсөл, санаачилгыг хэрэгжүүлэхэд:

- Хувийн хэвшил нь үйлдвэрлэгчид, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн тэнцвэртэй оролцоог хангаж, урт хугацааны тогтвортой байдлыг хангах замаар,
- Төр нь нэмэлт хөрөнгө оруулалт татаж, оролцогчдын сонирхол, “өмчлөлийг” хангаснаар

- Орон нутгийн иргэд /community/ нь шинэ мэдлэг, ур чадвар, технологи эзэмшсэнээр тус тус ашиг хүртдэг байна.

Дээрх үзэл баримтлал, зарчмыг үндэслэн ТХХНИТ-н зарчмыг дараах асуудлуудын хүрээнд тусгалаа. Үүнд:

1. Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэг цэгт төвлөрүүлэн чанарын хянан баталгаа хийлгэж, боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах зөвлөмжид хувийн хэвшлийг төлөөлүүлэн боловсруулах үйлдвэр, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, нутгийн захиргааг төлөөлүүлэн сумын хөдөө аж ахуйн тасаг, мал эмнэлгийн тасаг, нутгийн иргэдийг төлөөлүүлэн малчдыг оролцуулснаар:
 - a. Бүтээгдэхүүнийх нь үнэлэмжийг нэмэгдүүлж, тээврийн зардлыг хэмнэх замаар малчдын орлогоо нэмэгдүүлэх сонирхлыг хангах
 - b. Чанарын баталгаатай түүхий эдийг ченжээр дамжуулалгүй зардал чирэгдэл багатай худалдан авснаар эцсийн бүтээгдэхүүний чанар, үнийг өсгөн урт хугацаанд тогтвортой өндөр ашиг олох хувийн хэвшлийн сонирхлыг хангах
 - c. Түүхий эдийн чанарыг нүдээр үзэж, шаардлагын түвшинд баталгаажуулснаар хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанарын стандартыг хангуулах төрийн сонирхлыг хангах боломжийг нэмэгдүүлэх юм
2. Экосистемийн үйлчилгээний төлбөр /ЭСҮТ/-г мал борлуулсны урамшуулал хэлбэрээр олгож орон нутгийн захиргаа, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, иргэд малчдын оролцоо, сонирхлыг хангах замаар малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх замаар мал аж ахуйг тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох орон нутгийн чадавхыг дээшлүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах нийтлэг зорилтыг хангахад ашиглах
3. Хурга махлуулж борлуулах ажлын хүрээнд мах боловсруулах үйлдвэр, хэрэглэгчид, тэжээл үйлдвэрлэгчид, мах үйлдвэрлэгч малчид болон хүнсний аюулгүй байдал, чанарын стандартыг хариуцсан төрийн байгууллагын сонирхлыг хослуулан хэрэгжүүлэх
4. Аймаг, сумын мал эмнэлгийн байгууллага, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малчдын оролцоотойгоор бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан малчдын бүлэг, нөхөрлөлийн гэрээт бэлчээрийг халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох зөвлөмжийг хэрэгжүүлснээр нэг талаас малчдын бүтээгдэхүүний үнэлэмж, орлогыг нэмэгдүүлэх, экспортын гарцыг сайжруулах, нөгөө талаас эрүүл хүнс хэрэглэх хэрэглэгчдийн болон нийтийн эрх ашгийг хангах зорилтыг цогцоор нь шийдэх

Малчдын үйлдвэрлэлийн байгууллагын талаар

Манай орны бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд МАА-н үйлдвэрлэлийн үндсэн нэгж нь малчин өрх, хот айл юм. Өөрөөр хэлбэл МАА-н үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болсон малыг өмчлөгч нь малчин өрх бөгөөд малыг өмчлөх, борлуулах, хүнсэнд хэрэглэх зэргээр захиран зарцуулах шийдвэр гаргагч нь өрх юм.

Малын хариулга, маллагаа, бэлчээр, ус ашиглалт, тэжээл, мал эмнэлэг гэх мэт орц, үйлчилгээ худалдан авах зэрэг үйлдвэрлэлийн хүрээний зарим чухал асуудлуудыг мал нь цугтаа хотолж, бэлчдэг хот айлын хүрээнд шийдвэрлэж байна. Иймд малчдын үйлдвэрлэлийн байгууллага, түүнийг бэхжүүлэх гэдэг ойлголт нь малчин өрх, хот айлын зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэгдэх бөгөөд өөр ямар нэгэн байгууллагын талаар ярих боломж хязгаарлагдмал юм. Малчдын бүлэг, нөхөрлөл нь бэлчээр, ус зэрэг байгалийн нөөцийг ашиглах хүрээнд албан бусаар хамтран ажиллах хүрээнд бий болдог бөгөөд цаашид бэхжүүлж, албан гэрээ хийсэн нөхцөлд бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглаж, хамгаалах чиг үүрэг бүхий хариуцлагатай нэгж болоод явах бүрэн боломжтой, гэхдээ МАА-н үйлдвэрлэлийн нэгж биш юм.

Харин өртгийн сүлжээнд үйлдвэрлэлийн дараагийн шат болох бүтээгдэхүүнийг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, анхан шатны тордолт, боловсруулалт хийх, борлуулах шатанд зохион байгуулалтын үндсэн нэгж нь олонх оронд үйлчилгээний хоршоо байна. Манай оронд өртгийн сүлжээний дээрх чиг үүргүүдийг хоршоогоор гүйцэтгүүлэх зорилт дэвшүүлж, хоршоог дэмжих талаар олон арга олон тооны бодлого, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн ч шаардлагын түвшинд хүртэл хөгжиж, “ченжийг” орлох хэмжээнд хүрч чадахгүй байна. ХХААХҮЯ-ны Хяналт, үнэлгээний газраас 2020 онд явуулсан үнэлгээгээр хоршоодын олонх нь хоршооны тухай хууль болон холбогдох зарчмын дагуу байгуулагдаагүй болох нь тогтоогджээ. Хоршоод нь гишүүдийн өмчлөлийн байгууллага бус харин цөөн хувь хүний мэдлийн байгууллага болсон байна.

Төслийн хүрээнд малчдын бүлэг, нөхөрлөл, үйлчилгээний хоршоог цогцоор нь хөгжүүлэх доорх загварыг туршин хэрэгжүүлэх боломжтой юм.



Зураг 1.1 Малчдын хамтын ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрийг сайжруулах загвар, үе шатаар

Малчдын хамтын ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрийг сайжруулах цогц ажил нь дараах үе шатаас бүрдэнэ. Үүнд:

- Өөрсдөд нь ямар ашигтайг ойлгуулах замаар сайн дураар оролцох боломжийг олгохын төсөлд хамрагдаж байгаа сумын бүх малчин өрхийг нүүр тулсан сургалтад хамруулахаас үйл ажиллагаа эхэлнэ.
- Дараагийн шатанд, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хил заагийг тогтоон даацыг тодорхойлж, бүртгэсний үндсэн дээр сонгогдсон малчдын бүлэгтэй сумын Засаг дарга бэлчээр ашиглалтын гэрээ байгуулна. Гэрээ нь ашиглах бэлчээрийн хил заагийг албан ёсоор хүлээн зөвшөөрч хил заагийн хүрээнд бэлчээрийн даац, талхагдлыг тооцсон бодитой мэдээллийг гаргаж, түүнийг бууруулах хариуцлагын хөшүүргийг нэвтрүүлэх замаар нийтийн өмчийн эмгэнэлийг арилгахад чиглэж байгаа юм. Бүлгийн гэрээ байхгүй, ашиглалтын хил зааг тодорхойгүй буюу бэлчээрийг нийтээр дундаа ашиглаж байгаа одоогийн нөхцөлд энэ нь ямар ч боломжгүй юм.
- Дараагийн шат нь аль болох олон мал аж ахуйн эргэлтэд оруулан борлуулах замаар малынхаа тоог бэлчээрийн даацад нийцүүлэх, малчдын мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд

чиглэнэ. Энэ хүрээнд албан бус ченжүүдээр дамжуулан борлуулж байгаа нөхцөлд малчдын тухайд хэлэлцэх, зөвшилцөх, нэгдсэн шийдэлд хүрэх чадавх сул байдаг дутагдлыг шийдвэрлэх зорилгоор албан ёсны хуулийн этгээдийн эрхтэй байгууллага шаардагдана. Үүнийг эхний ээлжид нэг аймагт нэг төрийн бус байгууллага /ТББ/ буюу хоршоо байгуулах замаар хялбар шийдэх боломжтой. Туршилтын хүрээнд чанартай бүтээгдэхүүнээ үнэд хүргэхийн тулд төрийн бус байгууллага, хоршоогоор дамжуулан боловсруулагч нартай шууд гэрээ байгуулан борлуулах ажлыг зохион байгуулна. Энэ үе шатны ажлыг тайлангийн 5.2.1-д дурдсан “Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэг цэгт төвлөрүүлэн чанарын хянан баталгаа хийлгэж, боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах зөвлөмж”-д тусгасан үйл ажиллагааны хүрээнд цогцоор нь хэрэгжүүлэх боломжтой.

Санал болгож буй загвар нь малчид/үйлдвэрлэгчид, боловсруулагчид/худалдан авагчид болон орон нутгийн засаг захиргаа зэрэг гол оролцогч талуудад аль алинд нь ашигтай “хожигч-хожигч” шийдлийг санал болгож, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг тогтвортой зохион байгуулах чадвартай малчдын байгууллагыг бий болгох боломжтой юм. Төрийн бус байгууллагын хувилбарыг үйлчилгээний жинхэнэ хоршоог байгуулах эрх зүйн орчин бүрдэх хүртэл шилжилтийн үе шат хэмээн үзэж болно.

ХОЁР. НӨӨЦ АШИГЛАЛТЫН ГЭРЭЭНИЙ ШИНЭЧИЛСЭН ЗАГВАР БОЛОВСРУУЛСАН НЬ.

“АДАПТ” төслийн хүрээнд явуулсан Завхан, Ховд аймгийн 41 сумын бэлчээр, хадлан, ус, ойн нөөцийг ашигладаг, хамгаалдаг малчдын бүлэг, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл /БНХМН/, хоршоо, ТББ, ойн нөхөрлөл, худаг, хадлангийн талбай ашигладаг бүлэг зэрэг малчдын байгууллагын засаглал, үйл ажиллагаа, нөөц ашиглалтын гэрээний агуулга, хэрэгжилтийг үнэлэх хэрийн судалгаагаар хэд хэдэн доголдолтой болон нэмж тусгах асуудал тогтоогдсоныг бэлчээр ашиглуулах гэрээг шинэчлэхэд үндэслэсэн болно. Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ) ба малчдын бүлгийн засаглал, үйл ажиллагаа, бэлчээр ашиглалтын гэрээний боловсруулалт, хэрэгжилт, хяналт үнэлгээний одоогийн байдалд тулгуурлан гэрээтэй холбоотой дүгнэлтийг дараах дүгнэлт хийлээ.

1. Бэлчээрийг хамтын зохион байгуулалтаар ашиглах анхан шатны нэгж болох НАБ байгуулах замаар бэлчээрийн хамтын менежментийг бодит үйл ажиллагааны хэмжээнд хэрэгжүүлэх боломжийг ашиглахад сумын зүгээс анхаардаггүй, тодорхой арга хэмжээ авалгүй явж ирсэн,

2. Гэрээний үндсэн зорилго – малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх үүрэг хэрэгжээгүй, малын тооны хойноос хөөцөлдөх хандлага хүчтэй байгаа

3. Гэрээг заасан хугацаанд нь хянах, үнэлэх ажил хийгддэггүй, өөрөөр хэлбэл сумын хэмжээний дотоод хяналт туйлын сул,

4. Мөрдөгдөж байгаа болон шинээр батлагдсан хууль тогтоомж, журмын заалтыг бэлчээр ашиглуулах гэрээнд суулгаж өгөөгүй,

5. БАХ зэрэг томсгосон хэмжээнд гэрээ байгуулагдаад 5 жил гаруй хугацаа өнгөрсөн боловч дүгнэсэн, үр нөлөөг нь тодорхойлсон ямар нэг арга хэмжээ сумын хэмжээнд аваагүй,

6. Бэлчээр ашиглах явцад гарсан зөрчил, маргаан, зүй бус үйлдлийг таслан зогсоох, хохирлыг барагдуулах талаар сумын хэмжээнд авах арга хэмжээг гэрээнд заагаагүй,

7. Бэлчээрийн даац хэтэрсэн гэх тооцоо, мэдээлэл гарсаар байхад малын тоог хязгаарлах, цөөлөхөд экосистемийн үйлчилгээний төлбөр зэрэг нөлөө бүхий механизмыг ашиглах санаачилга гараагүй,

8. Бэлчээрийн даац хэтрэх, нэн ялангуяа талхагдлын улмаас хүлэмжийн хий шингээх чадвар буурах, малын тооны хэт өссөнөөс хийн дэгдэлт нэмэгдэх зэрэг уур амьсгалын өөрчлөлтийг эрчимжүүлж буй хүчин зүйлсийн сөрөг нөлөөг малчдад сурталчлах, мэдлэгжүүлэх ажил хийгддэггүй,

9. Малчдын бүлэг, хэсгийн-ийн үйл ажиллагаа, ялангуяа засаглалын анхан шатны арга хэмжээ тогтмолжоогүй, үр нөлөө муутай.

2020 онд гарсан мэдээллээр Ховд аймгийн газар нутгийн 52 хувь буюу 2654576 га буюу 34.9 хувь нь улсын тусгай хамгаалалтад, 725765.1 га буюу 9.5 хувь нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагт тус тус багтаж байгаа бөгөөд 2026 онд 56 хувьд хүргэх зорилготой ажиллаж байгаа. Түүнчлэн KFW, TNC зэрэг байгаль хамгаалах олон улсын байгууллагууд сүүлийн үед нутгийн иргэдэд түшиглэсэн нэгжийг нөхөрлөл хэлбэрээр байгуулах, байгаль хамгаалах үйл ажиллагааг хамтын менежментэд шилжүүлэх талаар идэвхтэй ажиллаж байна.

Энэ байдлыг харгалзан шинээр байгуулагдсан малчдын бүлэг цаашдаа байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл болж өөрчлөгдөн байгуулагдах, үйл ажиллагаа өргөжүүлэх боломжийг дэмжих үүднээс газрын даамал, БОХУБ зэрэг сумын зарим албан тушаалтныг гэрээтэй холбоотой төрийн үйлчилгээнд хариуцлагатай, мэргэжлийн өндөр мэдрэмжтэй оролцуулах талаарх Газрын тухай болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хамаарах заалтыг гэрээнд нэмж тусгалаа.

Нөөц ашиглагчдын бүлэг байгуулах тухай танилцуулгыг Хавсралт 2а-т үзүүлэв.

Өмнөх бэлчээр ашиглалтын гэрээг Өмчлөгчид хамааруулан бэлчээр ашиглуулах гэж өөрчлөн нэрлэж, улсын өмчийн бэлчээрийн газрыг малчдын бүлгээс болзол, гэрээтэй ашиглаж байгаа гэсэн агуулгыг суулгаж өглөө. Өмчлөгч буюу сумын Засаг даргыг төлөөлж газрын даамал гэрээнд гарын үсэг зурах заалтыг Газрын тухай хуулийн 23.4.2, 23.4.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 47 дугаар тогтоолд үндэслэн оруулсан болно.

Гэрээ байгуулах, дүгнэх, сунгах, цуцлах асуудал өмнөх гэрээнд тодорхой тусгагдаагүй байсныг өөрчлөн тусдаа заалт болгож оруулав. Ингэснээр гэрээг жил бүр дүгнэж, талуудын үүргийн биелэлтийг харгалзан сунгах, цуцлах асуудлыг тухай бүр шийдвэрлэхгүй байгаа үйл ажиллагааны хийдэл арилах боломж бүрдэнэ гэж үзлээ. Гэрээний хэрэгжилт, үүргийн биелэлттэй холбоотой зөрчил, хохирлын талаар албан ёсны дүгнэлт гаргуулах, хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, арилгуулах асуудлыг тухайн суманд эрх бүхий этгээд болох БОХУБ-д хариуцуулахаар тусгаж, нөөц ашиглах болон байгаль хамгаалах бүлгийн үйл ажиллагаанд хяналт тавих боломж бүрдэнэ.

Гэрээг бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, ургац тогтоох цэгийг гэрээт бэлчээрт шинээр байгуулахыг газрын даамал хариуцах, малчдын бүлгийн үйл ажиллагааны цогц төлөвлөгөөнд тусгах нөөцийн ашиглалт, эзэмшилт ба бусад арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд Ашиглагчийн зүгээс ашиглаж болох санхүүжилтийн шинэ эх үүсвэр – Малын тоо толгойн албан татварын тухай, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг тодруулж орууллаа. Бэлчээрийн даацад нийцүүлэх, ачааллыг багасгах зорилгоор мал борлуулахад экосистемийн төлбөр хэлбэрээр урамшуулал олгох арга хэмжээг сумын захиргаанаас хэрэгжүүлэхээр тусгав.

Гэрээнд Ашиглагчийг төлөөлж бүлгийн гишүүн өөрхийн тэргүүнээс гадна гэр бүлийн гишүүн (эхнэр) гарын үсэг зурах, байгалийн нөөцийн менежмент, ашиглалтын асуудлаар шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд жендерийн тэгш байдлыг хангах нь зүйтэй гэж үзлээ. Нөөц ашиглалтын шинэчилсэн гэрээ байгуулах тухай танилцуулгыг Хавсралт 2б-т үзүүлэв.

Бэлчээрийн ургац тогтоох, даац тооцох, малын тоог гэрээт бэлчээрийн даацад нийцүүлэх тооцоо үйлдэх, гэрээний хэрэгжилтийг дүгнэх зэрэг арга хэмжээг “Малын бэлчээрийн ургац тодорхойлох нийтлэг журам”-ын дагуу авч хэрэгжүүлнэ. Гэрээт бэлчээрийн ургацыг тухайн жилийнхээр авах нь зарим тохиолдолд даац хангалттай, эсхүл даац байхгүй гэсэн ташаа үнэлгээ гардаг явдлыг өөрчлөх, үүний тулд ургацыг сүүлийн 5 жилийн дундажаар тооцох, гэрээт бэлчээрийн хил заагийн дотор ургац тогтоох болон төлөв байдлыг үнэлгээний цэг байгуулах, энэ

арга хэмжээг Засаг даргын захирамжид тусгай заалт болгож тусгаснаас гадна бэлчээрийн даацын тооцоонд өвсөн тэжээлт зэрлэг хөхтөн амьтдыг оруулж тооцож байхыг гэрээнд заалаа.

Гэрээг шинэчлэн боловсруулахдаа АДАПТ төсөл хэрэгжүүлэх нэгж, Ховд, Завхан аймгийн ХААГ, БОАЖГ, ГХБХБГ, УЦУОЦГ, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ХААТ-гийн мэргэжилтнүүд, газрын даамал, багийн засаг дарга нар, гэрээ байгуулсан малчдын бүлгийн ахлагч гишүүдэд нэг бүрчлэн танилцуулж саналыг авч гэрээнд тусган боловсруулав. Гэрээний төслийн талаар орон нутгийн оролцогчдоос авсан санал асуулгын хуудсыг Хавсралт 2.1-д үзүүлэв.

Завхан аймагт болсон малчдын зөвлөгөөнд оролцсон нийт оролцогчдод бэлчээр ашиглуулах, худаг эзэмшүүлэх, хадлангийн газар эзэмшүүлэх гэрээг байгууллага, сум бүрд тарааж саналыг авч боломжит саналуудыг гэрээнд тусгасан болно. Санал асуулгаар гарсан саналуудыг Хавсралт 2.2-д үзүүлэв.

Гэрээг дагалдуулан НАБ-үүдэд зориулан бэлчээр ус ашиглалтын журам, худаг ашиглалтын журам, хадлангийн бүлэг нөхөрлөлийн дүрэм зэргийг дагалдуулан боловсруулав. НАГ-г шинэчлэн боловсруулах талаарх санал асуулгад хамрагдсан албан тушаалтан, малчдын нэрсийг Хавсралт 2.3-д, байгуулсан шинэчилсэн гэрээг нөөц ашиглалтын төрөл бүрээр нэг нэг гэрээг аймаг тус бүрээр Хавсралт 2.4-д үзүүлэв.

2.1 Бэлчээр ашиглуулах гэрээ

Шинээр батлагдсан хууль, нийтээр мөрдөх аргачлал, “АДАПТ” төслийн зорилго, БСТ-өөс гүйцэтгэж буй зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт малчдын бүлэгт өвөл, хаврын бэлчээр гэрээгээр ашиглуулах ажлыг гүйцэтгэх талаар тусгагдсан чиглэл зэргийг харгалзан өмнө нь “Бэлчээр ашиглалтын гэрээ” нэрээр боловсруулсан загварт дараах нэмэлт өөрчлөлт орууллаа. Үүнд:

1. Бэлчээр ашиглуулах гэрээ хэмээн энэ арга хэмжээг Өмчлөгчийн шийдвэрээр хэрэгжүүлж байгаа гэсэн агуулгаар өөрчлөн нэрлэх,

2. НАБ, түүнчлэн бэлчээр ашиглуулах гэрээний хүрээнд газар ашиглагчийн эрх үүрэг, цаашид бүлгээ байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл болгон өөрчлөн байгуулж үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж, нөхцөлтэй холбоотой Газрын тухай болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хамаарах заалтыг нэмж тусгах,

3. Малчдын бүлгийн үйл ажиллагааны цогц төлөвлөгөөнд тусгах нөөцийн ашиглалт, эзэмшилт ба бусад арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд Ашиглагчийн зүгээс ашиглаж болох санхүүжилтийн шинэ эх үүсвэр – Малын тоо толгойн албан татварын тухай, Төсвийн тухай хуулийн заалтыг тусгах,

4. Бэлчээрийн ургац тогтоох, даац тооцох, малын тоог гэрээт бэлчээрийн даацад нийцүүлэх тооцоо үйлдэх зэрэг арга хэмжээг “Малын бэлчээрийн ургац тодорхойлох нийтлэг журам”-ын дагуу авч хэрэгжүүлэх,

5. Төрийн албаны зөвлөлийн -д тусгагдсан “Газрын даамлын ажлын байрны тодорхойлолтын 3-д заасны дагуу бэлчээр ашиглуулах гэрээнд Өмчлөгчийг газрын даамал төлөөлөх, ингэснээр гэрээт бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, төлөв байдалд албан тушаалын ба мэргэжлийн хүрээнд хяналт тавих, үнэлгээ хийх ажлыг шууд хариуцах,

6. Бэлчээр ашиглуулах гэрээг урт хугацаагаар буюу 15 жилийн хугацаатай байгуулах,

7. Гэрээт бэлчээрийн хил заагийн дотор ургац тогтоох болон төлөв байдлыг үнэлгээний 2-оос доошгүй цэг байгуулах, энэ арга хэмжээг Засаг даргын захирамжид тусгай заалт болгож тусгах.

8. Ган зуд зэрэг байгалийн эрсдэл тохиолдсон үед гэрээлсэн бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй бусдын малыг оруулах

Энэхүү шинэчилсэн гэрээний загварыг ашиглан бэлчээр ашиглалтын гэрээг малчдын бүлэгт байгуулсан бөгөөд эдгээр бүлгийн ашиглаж буй бэлчээрийн талбай, ургац, бэлчээрийн даацын мэдээллийг Хавсралт 5.2.5Д болон 5.2.5Е -д үзүүлэв.

2.2 Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээ

Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэхдээ Монгол улсын "Газрын тухай хууль" "Байгаль орчныг хамгаалах тухай хууль", "Байгалийн ургамлын тухай хууль", "Байгалийн ургамал ашигласны төлбөрийн ухай хууль", "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль", "Газрын төлбөрийн тухай хууль", Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол, өвс, техникийн ерөнхий шаардлага MNS 0592:2008, өвс тээвэрлэлтийн ерөнхий шаардлага №1NS 5647:2006-г тус тус үндэслэл болгон хадлангийн зориулалтаар олгох газрын эзэмшил, ашиглалт, хамгаалалт, хяналт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг нөхөрлөл, төрийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар боловсруулав.

Хадлангийн газрын эзэмшлийн гэрээнд гэрээ байгуулахдаа газрыг хүлээлцэхдээ акт үйлдэн хүлээлгэн өгөх, хэрэгжилтэд жил бүр хяналт тавих, хадлангийн газраа тухайн жил бүрэн ашиглах боломжгүй бол бусдад гэрээгээр ашиглуулах, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг хадлангийн газраа сайжруулахад зарцуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх зэрэг заалтууд нэмэлтээр орсон болно.

2.3 Худаг эзэмшүүлэх гэрээ

2.3.1 Гэрээний шинэчилсэн загвар боловсруулсан талаар

"АДАПТ" төслийн зорилго, БСТ-өөс гүйцэтгэж буй зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт НАГ байгуулах түүний дотор малчдын бүлэгт худгийг гэрээгээр эзэмшүүлэх ажлыг гүйцэтгэх талаар тусгагдсан чиглэл, худгийн эзэмшил, ашиглалтын хүрээнд хуримтлагдсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шаардлага зэргийг харгалзан "Худаг эзэмшүүлэх гэрээ"-ний шинэчилсэн хувилбарыг боловсруулав.

Энэхүү шинэчилсэн хувилбарын урьд өмнө худгийн талаар хийгдэж байсан гэрээнүүдээс ялгагдах гол шинж чанар нь худгийн эзэнгүйдлийг арилгаж, хариуцлагатай болгох, ашиглалтын төлбөрийг шударгаар тогтоож, хураах замаар худгийн арчилгаа, засвар үйлчилгээ, нөхөн сэргэх хөрөнгийн эх үүсвэрийг баталгаажуулах, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн харилцааг тодорхой бөгөөд хэрэгжүүлэх боломжтой болгосонд оршино. Эдгээр гол ялгааг доор багцлан харуулав. Үүнд:

Худгийн усны төлбөр болон үйлчилгээний хөлс

1. Худгийн үйлчилгээний хөлс нь худгаас ус гаргах тоног төхөөрөмжийг ажиллуулах болон засварлах урсгал зардал, худгийн тоног төхөөрөмж болон худгийн барилгад их засвар хийх, сайжруулах зардал /элэгдлийн сан/, худаг хариуцагчийн цалин, худгийн усыг бохирдол, хөлдөлтөөс хамгаалах зардал, худгийн орчны газрыг талхагдал, бохирдлоос сэргийлэх арга хэмжээний зардлаас бүрдэнэ.
2. Худгийн үйлчилгээний хөлсийг ус хэрэглэгчид хариуцна.
3. Худгийн ашиглалтын норм, нормативыг мөрдүүлэх;
4. Гэрээний хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих ажлыг багийн засаг дарга, байгаль хамгаалагчийн оролцоотойгоор зохион байгуулах
5. Хэрэгжилтийн үнэлгээгээр тогтоогдсон зөрчлийг арилгах асуудлыг БОХУБ-д хариуцуулж гүйцэтгүүлэх

6. Худгийн үйлчилгээний хөлсний талаар санал боловсруулахад эзэмшигчид шаардлагатай мэргэжлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах
7. Худаг эзэмшигчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэх

Эзэмшигчийн эрх, үүрэг

1. Гишүүн бус өрх ус хэрэглэсэн тохиолдолд үйлчилгээний хөлс авах
2. Худгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах
3. Худагт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр нэхэмжлэх
4. Худгийн ашиглалт, засвар үйлчилгээг үйлчилгээний хөлсөөр хийх
5. Худгийн орчмын газар, байгаль орчны хууль тогтоомжийн дагуу хамгаалах, бохирдол, талхагдлаас сэргийлэх арга хэмжээ авах
6. Эзэмшигчийн хариуцлагагүйгээс худагт аливаа хохирол учирсан, орчмын газар талхагдсан тохиолдолд өөрийн зардлаар нөхөн сэргээх арга хэмжээ авах
7. Байгаль орчинд болон бусдын эзэмшил, ашиглалтын газарт хохирол учруулсан аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх
8. Худгийн ойр орчим 200 метрт шинээр хашаа, саравч барихгүй байх;
9. Худгийн ашиглалтын норм, нормативыг дагаж мөрдөх;
10. Худгийн их засвар, шинэчлэлтийг хийх элэгдлийн сан байгуулах;
11. Худгаас малаа услах, унд ахуйн ус хэрэглэх хуваарь гаргаж мөрдүүлэх
12. Худгийг ажиллуулах хариуцагчийг томилох, түүнд үйлчилгээний хөлсийг хураах, худаг ажиллуулахтай холбоотой зардлыг дундын сангаас авах эрх олгох
13. Худгийн үйлчилгээний хөлсийг энэхүү гэрээний 7.2-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд хангалттай хэмжээнд тогтоож, зөвшилцөн батлуулахаар Засаг даргад мэдүүлэх
14. Худгийн үйлчилгээний хөлсийг гишүүн өрхүүдийн малын болон ундны усны хэрэглээтэй харгалзуулан ногдуулж, хураах
15. Хураасан үйлчилгээний хөлсийг худаг эзэмшигч малчдын бүлэг, нөхөрлөлийн дундын сангийн дансанд байршуулан энэхүү гэрээний 7.2-д заасан арга хэмжээнд зарцуулах
16. Төрийн албаны зөвлөлийн -д тусгагдсан “Газрын даамлын ажлын байрны тодорхойлолтын 3-д заасны дагуу бэлчээр ашиглуулах гэрээнд Өмчлөгчийг газрын даамал төлөөлөх, ингэснээр гэрээт бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, төлөв байдалд албан тушаалын ба мэргэжлийн хүрээнд хяналт тавих, үнэлгээ хийх ажлыг шууд хариуцах,
17. Худаг эзэмшүүлэх гэрээг 5 жилийн хугацаатай байгуулах

Хариуцлагын талаар нэмэлт хуулийн заалтуудыг оруулж өгөв. Үүнд:

Зөрчлийн тухай хуулийн:

- 1.3 дахь зүйл заалт- Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
- 1.4 дэх зүйл заалт- Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй;
- 1.5 дах зүйл заалт - Усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 3.дах зүйл заалт - Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 8.дах зүйл заалт - Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрүүгийн хуулийн:

24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах

- 1.дэх заалт -Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хориглох зүйл

Монгол улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалын А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм” -д заасны дагуу худгийн эрүүл ахуйн хориглолтын бүсийг 50 метр, хязгаарлалтын бүсийг 200 метрээр тус тус тогтоосон байна.

1.1. А. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

1.1.1.Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;

1.1.2.Ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах;

1.1.3.Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;

1.1.4.Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;

1.1.5.Судалгаа шинжилгээ, унд ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;

1.1.6.Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;

1.1.7.Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;

1.1.8.Машин техник угаах;

1.1.9.Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;

1.1.10.Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;

1.1.11.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох;

Б. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөхөөс гадна дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

1.1.12.Гаднын хүн орох;

1.1.13.Авто тээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах;

1.1.14.Мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих;

2.3.2 Худаг эзэмшүүлэх гэрээ байгуулсан талаар

Малчдын бүлэгт худаг эзэмшүүлэх гэрээтэй холбоотой арга хэмжээг доор дурдсанаар зохион байгуулав. Үүнд:

- Малчдын бүлгээс хүргүүлсэн хүсэлтийг хэлэлцэн дэмжсэн тухай харьяа багийн ИНХ-ын тогтоолыг сумын Засаг даргад багийн Засаг даргаар уламжлуулан хүргүүлэх, ингэснээр худаг эзэмшүүлэх гэрээний талаар ажиллагаа, арга хэмжээний талаар багийн Засаг дарга нар хангалттай мэдлэг, мэдээлэлтэй болгох,

- Хүсэлт гаргасан малчдад худгийг гэрээгээр эзэмшүүлэх захирамжийн төслийг ХААТ-ын бэлчээр хариуцсан мэргэжилтэн хариуцан газрын даамалтай хамтран боловсруулах,
- Засаг даргын захирамж гарснаар дараах арга хэмжээг зохих хууль тогтоомж, журмын хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх,
 - Худаг эзэмшүүлэх гэрээ байгуулах болон дүгнэхэд албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийнх нь дагуу Хөдөө аж ахуйн тасаг (ХААТ)-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, газрын даамлыг ажиллуулах,
 - Худаг эзэмшүүлэх гэрээг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан дүгнэх,
 - Худаг эзэмшүүлэх гэрээний биелэлт, үүргийн гүйцэтгэлийг ХААТ-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, газрын даамалтай хамтран нэгтгэсэн тайланг Засаг даргад хүргүүлнэ.
- Худаг эзэмшигчийн гэрээнд тусгагдсан эрх үүрэгтэй холбоотой зөрчил, буруутай үйл ажиллагааг БОХУБ-аар хянуулж арилгуулах,
- Гэрээ дүгнэсэн болон Талуудаас цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар эзэмшигчид бичгээр мэдээлэх,
- Гэрээний төслийг малчдын бүлэгт урьдчилан танилцуулах, санал авах,
- Малчдын бүлэгт танилцуулсан төслийг Засаг даргад танилцуулж хянуулах,
- Засаг даргаас хянасан захирамжийг хоёр хувь үйлдэх,
- Эзэмшигч бүлгийн ахлагч, гишүүдийг байлцуулах гэрээнд Талууд гарын үсэг зурж баталгаажуулж, албажуулах, гэрээний эх хувийг Талуудад хадгалуулах болно.

Худаг эзэмшүүлэх гэрээ байгуулахтай холбогдсон хоёр шат /багийн Иргэдийн нийтийн хурлын хуралдааны тогтоол ба Засаг даргын захирамж/ шийдвэр гаргуулж, гэрээг албан ёсоор баталгаажууллаа.

Дээрх дэг жаягийн дагуу худаг эзэмших байгуулсан НАБ-н гишүүдийн нэрсийг Хавсралт 6.1Б, 6.2Б, худгийн байршлыг Хавсралт 6.1Г, 6.2Г-д тус тус харуулав.

Худаг эзэмшүүлэх шинэчилсэн гэрээний танилцуулгыг Хавсралт 2.3-т үзүүлэв.

2.4 Ойн санг эзэмшүүлэх гэрээ

2.4.1 Гэрээний шинэчилсэн загвар боловсруулсан талаар

Ойн санг эзэмшүүлэх гэрээний загварыг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолын хавсралт “ОЙН САНГ ГЭРЭЭГЭЭР ЭЗЭМШҮҮЛЭХ ЖУРАМ”-ыг үндэслэн ойн санг эзэмшүүлэх гэрээг шинэчлэн боловсруулав. Журамд зааснаар ойн нөхөрлөл шинээр байгуулан ойн санг гэрээгээр эзэмшихэд дараах ажлуудыг хийж гүйцэтгэдэг. Үүнд:

Нэг. Нөхөрлөлийн түвшинд

1. Нөхөрлөл байгуулах хүсэлтэй иргэд хоорондоо уулзан ярилцаж нөхөрлөлийн талаар болон хэрэгжүүлэх ажлын талаар ойлголттой болсон байх
2. Нөхөрлөл байгуулах хүсэлтэй иргэд хамтран хуралдаж дарга, удирдах зөвлөлөө сонгосон байх
3. Нөхөрлөлийн дотоод дүрэм, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар ярилцаж баталсан байх
4. Нөхөрлөлийн гишүүд хоорондоо хамтран ажиллах гэрээ байгуулсан байх /нөхөрлөлийн гишүүн иргэн 18 нас хүсэн байна. /
5. Нөхөрлөлийн гишүүдийн нэрс
6. Ойн санг гэрээгээр эзэмшин хамгаалах талаар хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөө
7. Эзэмших хүсэлт гаргаж буй ойн санд хамаарах газрын нэрс, тэдгээрийн хилийг харуулсан тойм зураг зэргийг гарган Багийн Иргэдийн Нийтийн Хуралд танилцуулан хэлэлцүүлж шийдвэр гаргуулна.

Хоёр. Сумын ИТХ-ын тогтоол гаргуулахад бүрдүүлэх баримт бичиг

2.1. Нөхөрлөлийн ахлагч багийн Иргэд нийтийн хурлын санал, хилийн цэсийн тойм зураг, гишүүдийн иргэний үнэмлэхийн хуулбар, эзэмших ойн санд хамаарах газрын нэрийг хилийн дагуу нутагладаг гишүүн өрхүүдтэй зөвшилцөн гарын үсэг зуруулж баталгаажуулан баг хариуцсан байгаль хамгаалагчид хүргүүлнэ.

Гурав. Багийн дарга, байгаль хамгаалагчийн түвшинд

3.1. Багийн дарга, тухайн багийг хариуцсан байгаль хамгаалагч нь нөхөрлөлөөс ирүүлсэн материалыг үндэслэн нөхөрлөлийн эзэмших ойн сангийн ойн талбайн хэмжээг сум дундын ойн ангитай хамтран /ойн зураг дээрх хэсэглэл, ялгарал/-р гарган тэмдэг даран баталгаажуулж, сумын байгаль орчны тасагт танилцуулан сумын ИТХ-д хүргүүлж сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар ойн санг гэрээгээр эзэмших тухай шийдвэр гаргуулах

Дөрөв. Сумын ИТХ-ын түвшинд

4.1. Ойн санг гэрээгээр эзэмшүүлэхийг дэмжсэн багийн ИНХ-ын санал
4.2. Ойн сангийн талбайн хэмжээ, хэсэглэлийн дугаар
4.3. ойн нөхөрлөл байгуулан хамтран ажиллах тухай гэрээ, гишүүдийн бичиг баримтын бүрдэл
4.4. Нөхөрлөлийн чадамж, БОТХБ-ын тасгийн дүгнэлт зэргийг харгалзан үзэж ойн санг гэрээгээр эзэмшүүлэх шийдвэр гарна.
Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх шийдвэрт нөхөрлөлийн эзэмших ойн сангийн хэмжээ, хамаарах хэсэглэл, газрын нэрийг тодорхой заасан байх ёстой.

Тав . Сумын Засаг даргын түвшинд

5.1. Мөн сумын ИТХ-аас ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшүүлэхээр тогтоол гарсан ойн нөхөрлөлүүдийг бүртгэн авч зохион байгуулалтын /ойн сангийн нөөц, төлөв байдлыг тогтоолгох/ ажилд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийлгүүлэх ажлыг зохион байгуулна.
5.2. Ой зохион байгуулалтын ажлын материал дээр үндэслэн шинжлэх ухааны үндэстэй ойн менежментийн төлөвлөгөөг ойн анги буюу эрх бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, аймгийн БОАЖГ-аар батлуулах үүргийг ойн санг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөлд өгнө.
5.3 БОАЖГ-аар батлагдсан ойн менежмент төлөвлөгөө дээр үндэслэн сумын Засаг дарга нөхөрлөлтэй тухайн жилд хэрэгжүүлэх ажлын гэрээ байгуулж, ойн санг гэрээгээр эзэмших гэрчилгээ олгоно.

Ойн санг эзэмших гэрээнд доорх заалтуудыг нэмж оруулав. Үүнд:

- 3.1 Эзэмшлийн ойн санд түймэр, хөнөөлт шавж, өвчин зэрэг гамшгийн хор уршгийг арилгахад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, санхүүгийн туслалцаа үзүүлэх,
- 4.9 Эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах,
- 4.10. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх,
- 4.11. Ойн нөхөрлөлийн дундын сан байгуулах.

Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журамд заасан ажлуудаас 1.6, 3.1-т заасан ажлууд, сумын засаг даргын түвшинд хийх ажлууд ихээхэн цаг хугацаа, мэргэжлийн байгууллагын оролцоо, санхүүжилт хэрэгтэй тул шинэ ойн нөхөрлөл байгуулах ажлыг төслийн богино хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй байв.

НАБ-ийн судалгаагаар урьд байгуулагдсан ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалтай, гэрээгээр зөвхөн хамгаалах үүрэг хүлээдэг тул өөрийн эзэмшлийн ойгоос орлого

олдоггүй, харин хамгаалах зардал гаргадгаас болж орон нутгийн иргэдээс шинээр ойн нөхөрлөл байгуулах санал гараагүй болно.

Сум орон нутгийн захиргаа, ИТХ ч гэсэн өмнө байгуулсан ойн нөхөрлөлүүд үйл ажиллагаа явуулдаггүй, жил бүр гэрээгээ дүгнүүлэх ажлыг хийдэггүйгээс шалтгаалан ойн нөхөрлөл байгуулах санал гараагүй байна.

Гэрээт ажлын хүрээнд шинэчлэн боловсруулсан нөөц ашиглалтын гэрээний Word хувилбарыг Хавсралт 2.4–д нөөц ашиглалтын төрөл бүрээр үзүүлэв.

ГУРАВ. НӨӨЦ АШИГЛАЛТЫН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Малчдын бүлэг, нөхөрлөл /БНХМН/ нь харьяа сумын Засаг даргатай нөөц ашиглалтын гэрээ байгуулсан, цаашид албан ёсоор үйл ажиллагаа явуулах анхан шатны нэгж болж зохион байгуулагдсан болно. Тэдгээр бүлэг, нөхөрлөлийг байгуулах, түүнчлэн иргэдийн төлөөлөгчдийн зохих шатны хурлаар байгалийн нөөц ашиглах хүсэлтээ хэлэлцүүлэх явцад АДАПТ төсөлтэй ямар чиглэлээр хэрхэн хамтран ажиллах, төслөөс хүлээж буй санхүүжилт ба технологийн дэмжлэг, зөвлөгөө авахаар өөрсдийнх нь тавьсан хүсэлтийг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэлбэрээр нэгтгэлээ. Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад ашигласан мэдээллийг БСТ-ийн зөвлөхүүд орон нутагт ажиллах явцдаа цуглуулсан буюу НАБ-ийн хурал, түүнчлэн багийн иргэдийн нийтийн хурлын үеэр иргэдийн өгсөн зөвлөгөө, сумын статистик мэдээ, НАГ-д хавсаргасан тооцоо, зураглал, бусад эх сурвалжийг ашигласан болно.

Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа НАБ бүрийн хүний нөөцийн ба эдийн засгийн, түүнчлэн ашиглаж буй нөөцийн чадавхыг мал аж ахуйд ажиллаж байгаа хөдөлмөрийн чадавхтай гишүүн, гэрээ байгуулсан нөөцийн төрөл ба бүтээмж (бэлчээрийн тэжээлийн нөөц, худгийн ундарга, ундны ба малын усаар хангах боломж, хадлангийн ургац гэх мэт) ба малын тооны нийц, тухайн нөөцийн хангамж/хүрэлцээ, хэрэглээний байдал зэрэг үзүүлэлтийг тооцож тусгалаа.

НАГ-ийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг бууруулах чиглэлээр НАБ-ээс хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төслөөс хүлээж буй дэмжлэг, түүнд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг энэхүү төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаа бүрээр мөнгөн дүнгээр оруулаа. Тухайлсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргаж хамтрах талаар НАБ-үүдтэй нээлттэй хэлэлцсэн бөгөөд шаардагдах нийт хөрөнгө, түүний хэмжээ, ач холбогдлоос хамааруулан “АДАПТ” төслөөс гаргах дэмжлэгийн тодорхой хэсгийг НАБ-ээс гаргах боломжтой гэснийг 10-30 хувь дээр урьдчилан тогтоолоо.

НАГ байгуулсан үндсэн зорилго бол бэлчээр хэт талхлагдсан бэлчээр нутагт байгаа малчин өрхийг нөөц ашиглалтын жижиг нэгж хэлбэрээр зохион байгуулалтад оруулж дэмжих замаар бэлчээрийн доройтлыг сааруулах, цаашилбал нөхөн сэргээх явдал мөний тул хонин толгойд шилжүүлснээр малын тоог жилд 5 хувь бууруулах, үүнийг дэмжих үүднээс үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлэх эхний жил буюу 2023 онд бэлчээрийн ачааллыг бууруулсны экосистемийн төлбөр хэлбэрээр мал борлуулсны урамшууллыг туршихаар тусгав.

Төлөвлөсөн үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд төслөөс хүлээж буй дэмжлэгийг зарцуулах оныг уг үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэх оноор, зарим үйл ажиллагааны үргэлжлэх хугацаагаар нь зааж өглөө. Энэхүү төлөвлөгөөнд НАБ бүрээс нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж санал болгосон үйл ажиллагааг тусгасан бөгөөд төлөвлөсөн үйл ажиллагааных нь талаар газар дээр нь зөвшилцөх, санал солилцох явцад өөрчлөгдөх, мөн төслийн зүгээс хүлээж авах, хэрэгжүүлэх боломжоос хамаарч өөр үйл ажиллагаа төлөвлөж тусгах шаардлага гарч болох талаар орон нутгийнханд тодорхой тайлбарлаж ойлголт өгсөн болно.

НАБ-ийн гишүүдтэй ярилцах, тэдний саналыг сонсох явцад зарим нь аль болох олон үйл ажиллагаа тусгуулахыг чармайх явдал нэлээд ажиглагдсан бөгөөд хэрэгжүүлэгч ба дэмжигчийн аль алинд нь дарамт бага учруулах үүднээс цөөн тооны арга хэмжээ оруулж энэхүү чухал төслөөс нэн хэрэгцээт дэмжлэгийг цаг алдалгүй авах, зорилго нэгтэйгээр ажиллаж ашиг хүртэгчдэд өгөөжтэй үр дүнд хүрэх талаас нь цэгцтэй хандахыг эрмэлзсэн болно.

НАБ-ийн үйл ажиллагааны нэгтгэлийг Хавсралт 3.1А-д Завхан аймгийн бүлэг бүрээр, Хавсралт 3.1Б-д Ховд аймгийн бүлэг бүрээр тусгав.

ДӨРӨВ. НАБ, НАГ-ИЙН ТАЛААРХ СУРГАМЖ, ТЭРГҮҮН ТУРШЛАГА

Завхан, Ховд аймгийн бүх суманд явуулсан хээрийн судалгааны ажлын үр дүнд гарсан НАБ, НАГ-ийн талаарх сургамж, тэргүүн туршлагыг доорх 2 жижиг гарчгийн хүрээнд нэгтгэн оруулав. Сургамж нь цаашид төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад гаргахгүй урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарах, тэргүүн туршлагыг ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор авч хэрэгжүүлэх боломжтой санаануудыг оруулсан болно.

4.1 Сургамж

А.НАБ-ийн үйл ажиллагаанд гарч байгаа сургамжууд

НАБ-ийн үйл ажиллагаанд дараах сургамжууд гарч байна. Үүнд:

- НАБ-ийн үйл ажиллагааг удирдан авч явах мэдлэг, боловсролтой малчид цөөн байх
- НАБ-үүд засаглал, хүний нөөц, санхүү, ил тод, гишүүдийн оролцоо, гишүүд хурлаа тогтмол хийх, ажлаа төлөвлөх, тайлагнах байдлын хувьд бүрэн бэхжээгүй байх
- НАБ-үүдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэг бүхий ХААТ-ийн бүлэг, хоршоо хариуцсан хүн хангалтгүй ажиллах
- Суманд шинээр байгуулагдаж байгаа НАБ-н үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүргийг хариуцсан ХААТ-ийн мэргэжилтний ажил үүргийн хуваарьт энэ талын ажлыг нарийн тусгаж өгдөггүй байх, ажил үүрэг давхардах, заримдаа орхигдох тал гардаг байх
- Сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдэд томилолт унаа зардал байхгүй, шаардлагатай тоног төхөөрөмж байхгүй, гишүүдийн оролцоо хангалтгүй, заримдаа мэдлэг мэргэжил дутах зэрэг шалтгаанаас хамааран НАБ-ийн үйл ажиллагаа сулхан явагдах
- НАБ-н ихэнх нь үйл ажиллагаа нь алдаг оног явах, заримдаа түр зогсонги байдалд ордог байх
- НАБ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлд дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрт хамрагдаж чадахгүй байх
- Ойн нөхөрлөлийн ахлагч, гишүүд малчид байдаг учраас малынхаа бэлчээрийг дагаад зарим улиралд эзэмшлийн ойн сангаа орхиж эзгүйрэх
- БНХМН, ойн нөхөрлөлийн ахлагч, гишүүд хууль бус үйлдэлд арга хэмжээ авах эрх байхгүй
- БНХМН, ойн сангаа байнга эргэж тойрох унаа байхгүй, дурангаас эхлээд бусад техник хэрэгсэл байхгүй
- Ойн сангаа хамгаалах идэвхтэн байгаль хамгаалагчийн үнэмлэх байхгүй
- Хэрэг, зөрчил илрүүлснээс занал хийлэлд байнга өртөх
- Биеэ хамгаалах хувийн хамгаалалтын багаж хэрэгсэл байхгүй
- Мод огтлох ажлыг тусгай зөвшөөрөл бүхий ХХК-ууд хийдэг учир нөхөрлөл зөвхөн ойн санг хамгаалах үүрэгтэй ажилладаг нь учир дутагдалтай байх
- Ойн цэвэрлэх, дагалт баялгийг зохистой бэлтгэн ашиглах замаар ойг хамгаалах сан байгуулж чадахгүй байх

- Хадлангийн бүлгийн хувьд хадлангийн талбайгаа хашиж хамгаалах санхүү дутагдалтай байх
- Хадлангийн ургацыг нэмэгдүүлэх усалгааны систем дутагдалтай, хадуу, тармуур бүхий цогц тоноглолтой трактор байхгүй

Б.НАГ-ний үйл ажиллагаанд гарч байгаа сургамжууд

НАГ-ний үйл ажиллагаанд үед дараах сургамжууд гарч байна. Үүнд:

- НАБ-үүд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан малын тоогоо бууруулан бэлчээрийн даацад тохируулах үүргээ огт биелүүлэхгүй байх
- Малын тоогоо бууруулан бэлчээрийн даацад тохируулах үүргээ биелүүлэх тал дээр сумын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнууд анхааран ажилладаггүй байх
- Бэлчээр ашиглалт, худаг эзэмшлийн гэрээний хэрэгжилтийг сумын ЗДТГ-аас жил бүр огт дүгнэдэггүй учир гэрээний хэрэгжилт урсгалаараа явдаг байх
- Бэлчээр ашиглалтын гэрээг дүгнэх ажил сумын газрын даамлын ажил үүргийн хуваарьт ордог боловч огт хэрэгжүүлдэггүй байх
- Төслийн хүрээнд эко системийн төлбөрийн дэмжлэг үзүүлсэн үед малчид малынхаа тоог бууруулах ажлыг сайн хэрэгжүүлдэг мөртөө төсөл дуусангуут энэ асуудал зогсдог тал байнга гарах
- Бэлчээр ашиглалт, худаг эзэмшлийн гэрээний хугацаа дууссан үед гэрээгээ яаж сунгуулах талаар НАБ-ийн гишүүн малчдын мэдлэг дутмаг байх
- НАБ-ийн гэрээт бэлчээрийг гаднаас өөр бүлгийн, өөр сумын отрын мал орж ирээд идчихдэг учир гэрээний үүргээ биелүүлэхэд хүндрэл гарах
- Гэрээт газрын байгалийн баялгийг хууль бус үйлдэл, гаднын нөлөө гэмт үйлдлээс хамгаалахад санхүү дутмаг байдал гол саад болдог бол түүний дараа мэдлэг чадвар сул, орон нутгийн удирдлагын дэмжлэг сул нь голлон нөлөөлдөг байх
- Худаг эзэмшлийн гэрээн дээр мал услах төлбөр бага байдаг учир худаг засварлах эргэлтийн сан байгуулж чаддаггүй байх
- Малын тоо толгой хэт өссөнөөс нэг худагт ноогдох малын тоо хэт олон болж худгийн ачааллыг ихэсгэдэг байх

4.2 Тэргүүн туршлага

4.2.1 Бэлчээр ашиглалтын малчдын бүлэг

“Ensure” төслийн хүрээнд Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл суманд 303 өрхийг хамруулан нийт 48 малчдын бүлэг зохион байгуулалтад орсон байна. 2019 оноос хэрэгжсэн энэхүү төсөл нь малын тооноос – чанарт шилжих талаар малчдын сэтгэлгээг өөрчлөх сургалтуудыг байнга хийсний үр дүнд 2019 оноос 2021 оны хооронд малын тоогоо бууруулсан байна. Тодруулбал: Их-Уул сумын 177 малчин өрхүүдийн малын тоон нийт дүнгээр 28.8 хувиар бууурсан эерэг үр дүн үзүүлжээ. 2019 онд 85744.1 хонин толгой байснаас 2021 оны жилийн эцэст 61018.1 хонин толгой мал болж буурчээ.

Энэхүү үр дүнгийн гол нөлөөлсөн хүчин зүйл нь экосистемийн үйлчилгээний нөхөн төлбөр байсан явдал юм. Тухайн малчин өрх малаа борлуулахад нь дэмжлэг үзүүлж нэг хонин толгой бүрт нь урамшуулал мөнгө өгсөн учраас малчдын урам зориг нэмэгдэж малаа зах зээлд их борлуулсан байна.

Малчдын бүлгийн давуу тал нь

- Санаа нийлсэн малчид эвлэлдэн нэгдэж, зорилгынхоо төлөө тууштай явах
- Бэлчээр нутгаа эв санаан дор хамгаалан ашиглах
- Малын чанар үүлдэр угсааг сайжруулан хамтран ажиллах

- Байгалийн баялгаа хамгаалах, зохистой ашиглах

4.2.2 Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл

2017 оноос эхлэн олон улсын байгууллагын (TNC) төслийн хүрээнд Ховд аймгийн Дарви суманд нөхөрлөлүүд байгуулагдсан байна. Энэхүү төслийн үр дүнд малчид байгалиа зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх зэрэг байгальд ээлтэй хандлагыг бий болгосноос гадна хөрөнгө оруулалтаар бодитой ажлуудыг хийж, аялал жуулчлалын чиглэлээр бааз байгуулж, зарим газруудад булгийн эхийг хашиж хамгаалж байна.

Нөхөрлөлийн тогтвортой байдал нь хэд хэдэн зүйлээс хамаарч байна. Тухайлбал хамтын ажиллагаа сайн эсэх, удирдан чиглүүлэх ахлагчийн үр нөлөө, мэдлэг чадвар, дундын сан бүрдүүлэлт, хөрөнгө, санхүүгийн хөшүүрэг зэрэг нь чухал нөлөө үзүүлж байна.

БНХМН нь сумын ИТХ-д жил бүр тайлангаа тавьж үнэлэлт дүгнэлт гаргуулж, дараа онд ажиллахаа баталгаажуулдаг.

Тогтвортой ажиллаж байгаа нөхөрлөл - Сутайн баялаг мөрөн


“Сутайн баялаг мөрөн” нөхөрлөлийн ахлагч Ч.Баярмаатай ярьсан ярилцлагаас ...

Манай нөхөрлөл нь 2012 онд байгуулагдсан 30 малчин өрхийн 150 гишүүдээс бүрддэг. Удирдах болон хяналтын зөвлөлтэй. БНХМН-нь жил бүр төлөвлөгөөгөө баталдаг. Бэлчээр, байгаль хамгаалах чиглэлээр голлон үйл ажиллагаа явуулдаг. Идэвхтэн байгаль хамгаалагч 5 байна. 1 нөхөрлөл дунджаар 55 мянган га талбайг хариуцаж ажилдаг. Бэлчээрийн даац хэтэрч байгаатай холбогдуулан жил бүр малын тоогоо бууруулж байгаа. Өрх бүр нийт малынхаа 20 хувийг борлуулж олсон мөнгөнийхөө тодорхой хувийг малын үүлдэр угсаа сайжруулах, байгаль хамгаалах сандаа хуримтлал хийх зэрэг цаашдын хамтын ажиллагаандаа зарцуулдаг.

Өрх бүр жилд 100,000 төгрөгийг дундын сандаа бүрдүүлж явдаг. Дундын сангаа зарцуулах журамтай, журмынхаа дагуу зарцуулдаг. Мөнгөний зарцуулалтыг хяналтын зөвлөл хянаж, удирдах зөвлөл нь баталж явдаг. Сангийн мөнгөөр 4 булгийн эхийг хахисан, био технологийн аргаар малдаа өвс хужир тавьсан зэрэг тухайн үеийн шаардлагатай ажлуудад зарцуулдаг.

Идэвхтэй ажиллаж байгаа гээд сумын зүгээс төсөвт мөнгө суулгадаг. Өнгөрсөн жил 30 сая төгрөг суулгаснаас идэвхтэн байгаль хамгаалагч нарт 10 сая, мод үржүүлгийн ажилд 20 сая тус тус зарцуулсан. Цаашидаа байгалийн сэргэн ургалтыг дэмжих үүднээс 50 хүртэлх га талбайг нөхөрлөлийн хүчээр хамгаалахаар төлөвлөгөөндөө оруулсан. Аймгийн ААН байгууллага, сум, нөхөрлөл хамтран 3 талт гэрээгээр ойжуулах ажлыг гүйцэтгэдэг. Сумын хэмжээний 8 нөхөрлөл нийлж нөхөрлөлийн холбоо байгуулсан. Нөхөрлөлүүдийн дунд олон нийтийн арга хэмжээ байнга зохион байгуулдаг.

Манай нөхөрлөлүүдийн давуу тал: Үзэсгэлэн худалдаануудад оролцож байнга тэргүүлдэг. Ж: цайны өв соёл, мөсний наадам, цагаан идээний худалдаа зэрэг



БНХМН-ийг дэмжсэн сумын ИТХ-ын тогтоол, шийдвэр, нөхөрлөлийн хариуцан хамгаалах талбайн зураг



Улсын бүртгэлд бүртгэгдсэн гэрчилгээ, БНХМН олгосон нөхөрлөлийн гэрчилгээ

Түүнчлэн энэхүү тайлангийн 5-р хэсэгт орсон зөвлөмжийн дийлэнх нь Бодлого судлалын төвөөс урьд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн туршсан загвар, туршилт дээр суурилсан тул тэргүүн туршлага гэж үзэх бүрэн боломжтой юм.

ТАВ. НАГ -НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, НАБ-ИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААРХ ЗӨВЛӨМЖ

5.1 НАБ-ийн үйл ажиллагааг бэхжүүлэх зөвлөмж

Адапт төслийн хүрээнд Завхан, Ховд аймагт 87 бэлчээрийн, 20 худгийн, 5 хадлангийн нийт 112 малчдын бүлгийг зохион байгуулж, цаашид Адапт төсөлтэй хамтран ажиллах бэлтгэлийг ханган ажиллав. Үүнээс сумын засаг даргын захирамжийн дагуу гэрээ байгуулсан нь 105, тухайн малчид нь эвлэлдэн нэгдэж бүлэг байгуулсан боловч сумын засаг даргын захирамж гараагүйгээс бэлчээр ашиглалтын гэрээ байгуулагдаагүй 7 бүлэг байна.

Малчдын бүлэг дээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго нь бүлгийн гишүүн өрхийн малын тоо толгойг бууруулах замаар бэлчээрийн даац, ачааллыг хөнгөвчлөх, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах, малын хашаа, саравчийг засварлах, малын тэжээлийн ургамал тарьж ашиглах замаар тэжээлийн хангамжийг нэмэгдүүлж уур амьсгалын өөрчлөлтөд малчид, мал сүргийн дасан зохицох чадварыг дээшлүүлэх, худаг усны ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, хадлангийн талбайг хашиж хамгаалах, бордох, услах замаар ургацыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Эдгээр бүлгийн үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлд доорх зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

1.Бэлчээрийн бүлгийн хувьд: А. Бүлгийн бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах талаар.

Бүлгийн 5 жилийн цогц үйл ажиллагааны төлөвлөгөөг бүлгийн үйл ажиллагаанд тулгамдаад байгаа ажлуудыг багтаан оруулан боловсруулан бүлгийн хамт олны хурлаар хэлэлцэж баталж хэрэгжүүлэх ажилдаа орж ажиллах нь зохимжтой.

Бүлгийн 5 жилийн цогц үйл ажиллагааны төлөвлөгөөнд жил бүр тодотгол хийж тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталж хэрэгжүүлнэ.

Бүлгийн дотоод дүрмийг бүлгийн хамт олны хурлаар улам нарийсган хэлэлцэж удирдлага, ахлагч, гишүүдийн хүлээх үүргийг улам тодорхой болгон баталж мөрдөн ажилладаг болно. Ялангуяа бүлгийн дотоод дүрэмд заасан ахлагчийн манлайллыг сайжруулах, гишүүдийн ажлын жигд оролцоог хангах үүргийг биелүүлэх тал дээр илүү анхааран ажиллана. Аливаа ажлын үр дүнгийн ашгийг гишүүдэд оролцооны зарчмаар хуваарилдаг тогтолцоонд шилжүүлнэ.

Бүлгийн тулгамдсан асуудал бүрийг заавал бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг тогтолцоонд шилжүүлж, бүлгийн гишүүдийн хамтын үйл ажиллагааны /оюуны, хүн хүчний, санхүүгийн/ давуу талыг харуулж ажиллах боломж бий.

Бүлэг Адапт төслийн хүрээнд хамтран ажилласан тохиолдолд бүлгийн дундын сан байгуулж зарцуулах, ашиглах журмаа шинэчлэн баталж мөрдөн ажиллана. Зарим үед дундын сангаасаа төслийн оролцоот хувь мөнгийг гаргах асуудлыг бүлгээрээ хэлэлцээд шийдвэрлэж байх боломж байна.

Б.Бүлгийн бэлчээрийн менежментийг сайжруулах талаар. Бэлчээрийн менежментийн асуудлаар тухайн бүлгийн гэрээлсэн бэлчээрийн хүрээнд даацыг тодорхойлж бэлчээрийн даац хэтэрсэнд тохиолдолд Адапт төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр экологийн үйлчилгээний төлбөр олгож илүүдэл малын тоог бүлгийн хэмжээнд жил бүр 5-аас доошгүй хувиар бууруулах зорилт тавьж ажиллах боломжийг бүрдүүлэх нь зохимжтой. Бүлгийн гишүүд борлуулах малаа хамтран мал борлуулах нэг цэгийн үйлчилгээнд хүргэх тээврийн зардлаа өөрсдөө хариуцна.

Цаашид бүлгийн гэрээт бэлчээрийн даацыг жил бүр тодорхойлон бүлгийн хэмжээнд борлуулах малын тоог төрөл, тоогоор гаргаж малынхаа тоог бэлчээрийн даацад ойртуулах, бэлчээрийн ачааллыг хөнгөвчлөх ажил дээр анхааран ажиллах нь зүйтэй. .

Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малын хөлөөс бүрэн чөлөөлж, зун, намрын бэлчээрийг ойрын сэлгэлтэд хамруулах, боломж гаргавал бүлгийн нөөц бэлчээртэй болох асуудлыг шийдвэрлэх тал дээр анхааран ажиллана. Шаардлагатай гэж үзвэл, өвөлжөө, хаваржааны дэргэд бүлгийн гишүүн өрхүүд 1-2 га бэлчээр хашиж нөөцлөх ажлыг туршилтын журмаар хийнэ. Хэрэв үр дүнтэй байвал бүлгийн гишүүн бүх өрхүүдийн түвшинд нэвтрүүлэх ажлыг баг, сумын захиргаатай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй.

В.Бүлгийн малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах талаар. Бүлгийн мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах үүднээс жил бүрийн төлөвлөгөөг тарилга, туулгалтад малаа бүрэн хамруулахыг ажлыг зохион байгуулах нь зүйтэй. Бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд малын шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг зэрэг гоц халдварт, зооноз өвчнөөс эрүүл нутгийг тогтоож малын мах, бусад түүхий эдээ зах зээлд арай өндөр үнээр тасралтгүй борлуулах боломж нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

Бүлгийн борлуулсан мал бүрдээ малын эрүүл мэнд, гарал үүслийн гэрчилгээ авч Мал эмнэлгийн нэгдсэн систем /МЭНС/ мэдээллийн сүлжээнд цаг тухайд мэдээллээ оруулж баталгаажуулалт хийнэ.

Бүлгийн малын шилжилт хөдөлгөөнд бүлгийн гишүүн бүхэн хяналт тавьдаг тогтолцоонд шилжих боломжтой.

Нэг малаас ашиглах ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор хонь, ямаа, үхрийн чанарыг сайжруулах ажлыг бүлгийн хурлаараа хэлэлцэж шийдвэрлээд нутгийн шилмэл омгийн хээлтүүлэгч, хээлтэгч авах ажлыг бүлгийн түвшинд зохион байгуулж хэрэгжүүлэх нь илүү үр дүн гаргана.

Г.Бүлгийн МАА-н эрсдэлийн менежментийг сайжруулах талаар: Малын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлж мал сүргийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг дээшлүүлэхээр бүлгийн түвшинд 1-2 га талбайд ногоон тэжээл тарьж ашиглах туршилтын ажлыг зохион байгуулна. Бүлгийн гишүүн өрх бүр мал сүргийн тодорхой хувийг 11-06-р сар хүртэл тэжээх өвс, тэжээлийн нөөцтэй болох ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх шаардлага байна.

Малын хашаа саравч, хороо, төлийн пүнзийг засварлахад аль бодохоор мод ашиглахгүй байх, модыг орлох бусад материалыг ашиглаж хийхийг бүлгийн гишүүдэд ойлгуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Д.Бүлгийн байгалийн бусад нөөцийг хамгаалах талаар.Нэг тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд жимс, жимсгэнэт мод, бут, сөөг тарих, ойн зурвас байгуулах ажлыг санаачлан хийж эхэлнэ.

Биологийн олон янз байдлыг зохистой ашиглах, хамгаалах үүднээс бүлгийн гэрээт бэлчээрт байгаа ойн сан, ан амьтад, эмийн болон ашигт, ховор, нэн ховор ургамлуудыг хамгаалах, бүлгийн эхийг хашиж хамгаалах ажлуудыг хамтын хүчээр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарах шаардлага байна. Шаардлагатай гэсэн тохиолдолд ойн сан, зарим ан амьтныг эзэмшлийн гэрээгээр хамгаалах арга хэмжээ авмаар байна.

Байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн бүлгийн хэмжээнд аялал жуулчлал хөгжүүлэх ажилд анхааран ажиллана. Гэрээт бэлчээрт байгаа дээр үеийн булш, мал, амьтны сүг зураг бүхий хад чулуу зэрэг археологи, палеонтологийн судалгааны ач холбогдол бүхий эд зүйлсийг хамгаалалтад авч ажиллах санаачилгууд бүлгийн гишүүд гаргаад байна.

Бүлгийн түвшинд 1-2 гишүүнийг идэвхтэн байгаль хамгаалагчийг сургалтад суулган үнэмлэхтэй болгон бүлгийн гэрээт бэлчээрт байгаа байгалийн нөөцийг хамгаалахад ашиглана. Бүлгийн идэвхтэн байгаль хамгаалагчийг мотоцикль унаа, дуран зэрэг мэргэжлийн багаж хэрэгслээр хангах ажлыг дэмжин ажиллах шаардлага байна. Шаардлагатай гэж үзвэл, хувийн бие хамгаалалтын багаж хэрэгслэтэй болгох ажлыг хиймээр байна.

Бүлгийн гишүүн өрх бүр өвөлжөө, хаваржаан дээрээ 00, муу усны нүх, хогийн цэгтэй болох ажлыг хэрэгжүүлэх нэн зохимжтой.

Малчдын бүлгийг цаашид ойн сан хамгаалах, ан амьтан хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг болбол БНХМН, ойн нөхөрлөлийн зохион байгуулалтад ахиулан оруулж ойн сан, ан амьтан эзэмших гэрээнүүдийг шинэчлэн байгуулах шаардлага гарна.

Е.Бүлгийн хэмжээнд өртөг шингээсэн буюу брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар. Бүлгийн брэнд бүтээгдэхүүн гаргах талаар анхааран ажиллана. Бүлгийн түвшинд цагаан идээ /ааруул, сүүн хурууд, эзгий, шар ба цагаан тос, бяслаг, өрөм, зөөхий, тараг, аарц г.м/ боловсруулах, монгол архи савлаж борлуулах зэргээр нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн гаргах талаар төслийн дэмжлэгийг авч ажиллавал илүү үр дүн гарч болно.

МАН-н бус орлого нэмэгдүүлэх чиглэлд бүлгийн гишүүдийн ур чадварт түшиглэсэн төмс, хүнсний ногоо тарих, дархан, мужаан, оёдлын цех ажиллуулах, блок хийх, арьс шир элдэх, сур элдэх, суран эдлэл, дээс, уяа, татлагын дээс томох, гэрийн бүслүүр, чагтаг, эргүүлэг, эсгий урлал хийх зэрэг ажлуудаас сонгон хийж гүйцэтгэхийг дэмжин ажиллах нь зүйтэй.

Сум, аймгийн төвд бүлгийн сүү, цагаан идээ, мах байнга борлуулах цэг, лангуутай болж орлогоо нэмэгдүүлэх ажлыг бүлэг дотроо зохион байгуулж, хүн хүчээ зөв зохицуулах шаардлага байна.

Бүлгийн гишүүн өрхүүд ямааны ноолуураа микрон, өнгөөр ангилж зах зээлд үнэтэй борлуулах ажлыг туршилтын журмаар төсөлтэй хамтран хэрэгжүүлэх боломж байна.

Ё.Бүлгийн гишүүдийн чадварыг сайжруулах, тэргүүн туршлага нэвтрүүлэх талаар.Бүлгийн ахлагч, гишүүдийг сургалт, сурталчилгаанд байнга хамруулан мэдлэг, чадварыг сайжруулах шаардлага байна.

Бүлгийн сүү, цагаан идээ, бусад брэнд бүтээгдэхүүнийг үзэсгэлэн худалдаанд байнга оролцуулан борлуулалт хийх, брэнд бүтээгдэхүүнийг зах зээлд сурталчлах ажлыг тогтмолжуулах ажлыг дэмжин ажиллах шаардлага байна.

Бусад бүлгийн ажлын шинэлэг санаа, тэргүүн туршлагыг байнга судлан авч хэрэглэж болох шинэлэг санаа, туршлагыг ажилдаа нэвтрүүлэн ажиллаж үр дүн гаргахад анхааран ажиллана.

2.Худаг ашиглагчдын бүлгийн хүрээнд: Худаг ашиглагчдын бүлгийн хүрээнд худгийн мотор, насосоо шинэчлэх, ус нөөцөлдөг сав, шаардлагатай үед онгоцоо томруулах, 2 онгоцтой болгох, өвлийн улиралд худаг эзэмшигч орж дулаацах жижиг байр барьж ашиглуулах, худаг орчмын хог, хаягдлыг ашиглагч гишүүдийн хүчээр тогтмол цэвэрлэх, зарим эвдэрсэн худгийг засварлах, мал усалдаг үнэ тарифыг шинэчлэх, худаг засварын эргэлтийн сан байгуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэх эрэлт шаардлага нэлээд их байна.

3.Хадлангийн бүлгийн хүрээнд: Хадлангийн талбайг усалгааны системтэй болгох, хадлангийн хадуур, тармуур зэрэг цогц тоног төхөөрөмж бүхий трактортой болгох, хадлангийн талбайгаа бууцаар бордох, хашиж хамгаалах, хуучин хашаагаа засварлан сэлбэх зэрэг ажлуудыг дэмжин ажилламаар байна.

5.2 НАГ-ний хэрэгжилтийг хангах зөвлөмж

5.2.1 Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэг цэгт төвлөрүүлэн чанарын хянан баталгаа хийлгэж, боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах зөвлөмж

Урамшууллын хөшүүрэг механизм тогтоогүй учраас мал, түүхий эдээ хотноосоо ченжүүдэд хямд үнээр худалддаг, хамтран ажиллаж чаддаггүй нь малчдын өртгийн сүлжээний хүрэн дахь гол дутагдал байсаар ирсэн билээ.

Борлуулах мал, түүхий эдээ малчид төвлөрсөн нэг цэгт авчран хянан баталгаажуулалтад оруулан гарал үүслийн ба эрүүл мэндийн гэрчилгээ авдаг, баталгаа бүхий мал, түүхий эдийг түнш боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах шинэлэг тогтолцоог нэвтрүүлж төлөвшүүлэх нь нэг цэгийн гол зорилго юм. Үүний үр дүнд малчид бүтээгдэхүүнийх нь үнэлэмжийг нэмэгдэж, тээврийн зардлаа хэмнэж, орлогоо нэмэгдүүлэх боломжтой болох бол боловсруулах үйлдвэр чанарын баталгаатай түүхий эдийг ченжээр дамжуулалгүй зардал чирэгдэл багатай худалдан авснаар эцсийн бүтээгдэхүүний чанар, үнээ өсгөн урт хугацаанд тогтвортой өндөр ашиг олох боломжтой болж, харин төрийн хувьд түүхий эдийн чанарыг нүдээр үзэж, шаардлагын түвшинд баталгаажуулснаар хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанарын стандартыг хангуулах зорилтоо хангах юм.

Нэг цэгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд эхний ээлжид дараах хоёр арга хэмжээг авна. Үүнд:

1. Төсөлтэй түншлэн хамтран ажиллах боловсруулах үйлдвэр сонгох
2. Мал, түүхий эд цуглуулах, чанарын үнэлгээ, гэрчилгээ олгох, мал борлуулалтыг зохион байгуулах малчдын байгууллага байгуулах

Түнш боловсруулах үйлдвэр сонгохдоо дараах арга хэмжээ авна. Үүнд:

- Тухайн бүс нутагт төсөлтэй хамтран ажиллахыг сонирхох боломж бүхий боловсруулах үйлдвэрүүдийн жагсаалт гаргах
- Төсөлтэй хамтрах сонирхолтой эсэхийг судлахын тулд цахим шуудангаар болон утсаар компани бүртэй холбоо барьж харилцах
- Сонирхож байгаагаа илэрхийлсэн боловсруулагчидтай биечлэн уулзах, утсаар ярих замаар төслийн тухай, боловсруулагчид оролцох арга хэлбэр, төслөөс тэдний хүртэж болох өгөөж ашиг /айлаар тойрч явах, эсвэл ямар нэг магадлагаагүй мал ченжүүдээс авахын оронд нэг цэг дээр хянан баталгаа хийсэн малыг бөөнөөр худалдан авах/-ийн талаар тайлбарлах
- Монголын махны өртгийн сүлжээний жишиг байдлаар үйлдвэрлэгч/малчид болон боловсруулах компанийн хоорондын харилцан ашигтай, тогтвортой түншлэлийг дэмжих төслийн үйл ажиллагаанд тулгуурлан төсөлтэй хамтран ажиллахаа илэрхийлсэн компанийг сонгох.

Малчдын байгууллагын хувьд хуулийн этгээдийн ямар хэлбэртэй байх талаар төсөлд хамрагдсан бүх малчдын уулзалт зохион байгуулж, боломжит хувилбаруудын давуу ба дутагдалтай талыг тайлбарлаж өгөх замаар зохистой хэлбэрийг сонгож шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлнэ. Ингэхдээ үүсгэн байгуулахад ажиллагаа багатай, татвар төлдөггүй, тайлан гаргах гэх мэт бичиг цаасны ажил бага шаарддаг, хамтын шийдвэр гаргах, гишүүдийнхээ оролцоо боломж илүү зэрэг үндэслэлээр ТББ-ыг хоршоо, компани гэсэн нөгөө хоёр хэлбэрээс илүүд үзэж сонгох хандалга байгааг харгалзаж үзнэ.

МАН-н өртгийн сүлжээнд доор нэр бүхий тоглогчид оролцоно. Үүнд:

- Мал, мах, бусад түүхий эд худалдан авах компани
- Сумын захиргаа /ХАА-н ба Мал эмнэлгийн тасаг/ - хувийн малын эмч нартай хамтран малын чанарыг хянан баталгаажуулах ажлыг зохион байгуулах үйлчилгээ үзүүлэх гол байгууллага
- Малчдын байгууллага нь мал борлуулах ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар хангах, мал худалдан авах, төлбөр барагдуулахад малчин бүртэй харьцах хүндрэлтэй ажлыг хөнгөвчлөх хүсэлтийнх нь дагуу боловсруулах компанитай харьцдаг байгууллага юм.
- Төсөлд хамрагдсан болон боловсруулах компанийн хүсэлтийн дагуу мал борлуулах ажилд оролцох бусад малчид

Нэг цэгийн үйл ажиллагааг тодорхой, ойлгомжтой болгох үүднээс үйл ажиллагааны журмыг сумын холбогдох албан хаагчид, малчид, хувийн салбарын төлөөлөлтэй хамтран боловсруулна /Үлгэрчилсэн загварыг Хавсралт 1-д үзүүлэв.

Дээрх журмын сонгогдсон мал худалдан авах компани сумын захиргаатай хамтран мал худалдан авах хуваарь, малд тавигдах шаардлагын талаарх мэдээллийг малчдад утсаар хүргэнэ. Үүнд мал хүлээн авах газрын нэр, амьдын жингийн 1 кг-ийн үнэ зэргийг төсөлд хамрагдсан малчдад утсаар мэдээлж, сумын төвийн зарын самбарууд, захиргааны зарлалын самбар, сумын Facebook хуудсанд зарлал мэдээлэл тавьж, сумын нийт малчдад мал худалдан авах зарыг хүргэнэ.

Нэг цэгийн үйл ажиллагаа хэрэгжиж, малчид, боловсруулах үйлдвэрийн аль алинд ашигтай байж болох талаар туршилтууд хийгдэн болно. Тухайлбал Архангай аймгийн Өлзийт суманд Эрдэнэт мах маркет ХХК малчдын байгуулсан ТББ-тай урьдчилан гэрээ байгуулж нэг цэгээр борлуулсны үр дүнд малчид хонио тухайн үеийн сумын зах зээлийн үнээс 10 хувийн илүү үнээр борлуулсны дээр сумаас Эрдэнэт хот хүртэлх тээврийн зардлыг компани, малчдын байгууллага 50/50 хувиар хувааж гаргасан нь тээврийн зардлын хэмнэлтээс хонь дутам 5000 төгрөгийн нэмэлт орлого олсон байна.

Үхэр худалдан борлуулж буй нэг цэгийн үйл ажиллагааг фото зургаар үзүүлэв.



Нэг цэгийн мал авах хашааг түрээслэн авч засаж, жингээ байрлуулж байгаа нь



Борлуулах үхрээ авчирч ээлжээ хүлээж байгаа малчид



Үхэр пүүлж байгаа нь



Мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн малын эмч худалдан авсан малд үзлэг хийж байгаа нь



Үзлэг шинжилгээнд оруулсан малыг ачиж байгаа нь

Нэг цэгийн үйл ажиллагааг зохион байгуулахад 83.2 сая төгрөгийн төсөв шаардагдах бөгөөд үүнд мэргэжлийн зөвлөх багийн ажлын хөлс 24 сая, томилолт, унаанд 44 сая, малчдад олгох мал борлуулалтын урамшуулалд 5 сая төгрөг, нэг цэгийн хашаа барих/засварлахад 6 сая, мал угаа, ариутгах шүршүүр, шахуургын хамт 1.6 сая, малыг том оврын машинд ачих хөлсөнд 1.6 сая, орон нутгийн МЭТ, ХААТ-н ажилтнуудын мал, түүхий эдийн хяналт, хянан баталгаа хийхэд гарах нэмэлт зардалд 1 сая төгрөг болж байна. Нэг цэгийн үйл ажиллагааг эхний ээлжид аймаг бүрд сонгож авсан цөөн сумдад загвар байдлаар хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Ховд, Завхан аймагт нэг цэгийн үйл ажиллагааг зохион байгуулах тохиромжтой сумдын байршлыг Хавсралт 5.2.1А, 5.2.1Б- д тус тус харуулав.

Хавсралт 1 Сумын малын чанарыг хянаж, баталгаажуулах нэг цэгээр худалдан борлуулах үйл ажиллагааны жишиг журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1Төслийн хүрээнд сумын Засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээний дагуу малчдын бүлэг, малчин өрхөөс малыг зөвхөн маханд борлуулахад энэхүү түр журмыг мөрдөнө.

1.2Энэхүү журмыг мөрдөхөд Малын генетик нөөцийн тухай болон Малын эрүүл мэндийн тухай хууль, тэдгээртэй холбогдон гарсан хүчинтэй дүрэм, журам, бусад зохицуулалтыг баримтална.

1.3Борлуулах малын чанарыг баталгаажуулах ажлыг төвлөрсөн журмаар малын чанарыг хянан баталгаажуулах цэг /цаашид баталгаажуулах цэг гэх/-т зохион байгуулна.

1.4Борлуулах малын нэгдсэн бүртгэлд хамрагдсан байдал, гарал үүсэл, ашиг шим, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг сумын ЗДТГ-ын ХАА-н тасаг /төрийн хяналт-үйлчилгээний байгууллага/ болон Мал эмнэлгийн тасаг /мэргэжлийн байгууллага/-аас хамтран гүйцэтгэнэ.

1.5Баталгаажуулах цэгээр дамжуулан борлуулсан малын тоог бэлчээр ашиглалтын гэрээний малын тоог цөөлөх үүргийн биелэлтийн үндсэн үзүүлэлтэд тооцно.

1.6Баталгаажуулах цэгээр хувь хүн, ченжүүд, орон нутгийн хэрэглээнд зориулж мал худалдах, борлуулах ажиллагаа явуулахгүй.

1.7Малын нэгдсэн бүртгэл болон малын эрүүл мэндийн бүртгэлд хамрагдаагүй малыг хянан баталгаажуулах үзлэг шинжилгээнд оруулахгүй, баталгаажуулалт олгохгүй.

1.8Цэгт ирсэн малд хэрэглэсэн эмийн хүлээх хугацаа дууссан эсэхийг өрхийн малын эрүүл мэндийн дэвтэр, мал эмнэлгийн тасгийн бүртгэлд үндэслэн тогтооно. Энэ хугацаа дуусаагүй малыг үзлэг, баталгаажуулалтад оруулахгүй, шууд буцаана.

Хоёр. Малын чанарыг хянан баталгаажуулах цэг, түүний ажиллагаа

2.1 Баталгаажуулах цэгийг тэргүүн ээлжид төсөлд хамрагдсан малчдын бүлэг, малчин өрхөд үйлчлэх зориулалтаар ашиглана.

2.2 Баталгаажуулах цэгийг сумын төвийн орчимд байршуулж/байгуулж, төвлөрсөн үйлчилгээний зарчмаар ажиллуулна.

2.3 Баталгаажуулах цэгийг сумын ХАА-н тасгийн мэдэлд ажиллуулж тогтвортой ажиллагааг хангах үүргийг хариуцуулна.

2.4 Баталгаажуулах цэгийн үйл ажиллагаатай холбогдуулан сумын ХАА-н тасаг ба сумын мал эмнэлгийн тасгаас дараах үүрэг, үйл ажиллагааг хариуцаж ажиллана.

2.4.1 Хамтран гүйцэтгэх үйл ажиллагаа

- Цэгт ирсэн малыг төрлөөр нь ялгаж хүйсээр нь /шаардлагатай бол насаар/ ангилан нэг бүрчлэн тоолно.

- Цэгт ирсэн малд хэрэглэсэн эмийн хүлээх хугацаа дууссан эсэхийг мал магадлах

- Борлуулах малын тарга хүчийг үзлэгээр эсвэл бөөнөөр пүүлэх /амьдын жингээр/ аргаар тогтооно. Аль аргыг хэрэглэхийг малын эзэн ба худалдан авагч зөвшилцөн тохиролцох ба эс тохиролцвол ХАА-н тасгаас санал гаргаж шийдвэрлэж болно.

- Тарга хүчээр нь малыг дундаас дээш, дунд, дундаас доош гэж ангилах ба аль ангилалд орсон ямар төрлийн малыг пүүлэхийг малын эзэн ба худалдан авагчтай зөвшилцөн тохиролцоно.

- Малд үзлэг хийх, тарга хүч тогтоох, пүүлэх ажиллагаанд өөрийн төлөөллийг байлцуулах эсэхийг худалдан авах компанитай зөвшилцөж шийдвэрлэнэ.

2.4.2 Сумын ХАА-н тасгийн хариуцах үүрэг, үйл ажиллагаа:

- Баталгаажуулах цэгт мал пүүлэх, шүдлэх, хэмжих, амьдын үзлэг хийхэд шаардагдах багаж төхөөрөмж, лавлах материал, бусад бэлтгэлийг тухай бүр хангах

- Мал худалдан авах компанитай хугацаа болон борлуулах малын тоо, төрлийн талаар урьдчилан тохиролцож шаардлагатай тохиолдолд малчдад мэдээлэх
- Баталгаажуулах цэгийн ажиллах хуваарь /сар өдрөөр/ болон цэгт малаа авчрах бүлэг, малчин өрхийн жагсаалтыг гаргаж зар хүргэх
- Баталгаажуулах цэгт мал борлуулах зарласан өдөр тасгийн мэргэжилтнийг өөрийн биеэр саадгүй ажиллуулах
- Борлуулахаар тэнцсэн болон үнэ тохирч худалдах малыг тус тасаг дахь малын гарал үүсэл, ашиг шим, үүлдэрлэг байдлын бүртгэлтэй заавал тулгах
- Малын эрүүл мэндийн гэрчилгээ авсан нөхцөлд малын гарал үүслийн баталгааг олгоно.
- ХАА-н тасгийн дарга гарын үсэг, тэмдгээр баталгаажуулсан гэрчилгээ олгосноор малын чанарыг хянан баталгаажуулсанд тооцно.

2.4.3 Мал худалдан авах компанийн оролцоо, дэмжлэг

- Ямар нас, хүйсийн болон тарга хүч /амьдын жин, эсхүл гулуузны жин/-ний шаардлага хангасан малыг хэдийд /сар, боломжтой бол өдрөөр/ авахаа сумын ХАА-н тасагт урьдчилан бичгээр юм уу цахим шуудангаар мэдэгдэж, сумын зүгээс шаардагдах бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх
- Малын чанарыг хянан баталгаажуулах цэгийн ажиллах календарчилсан хуваарийн дагуу тээврийн хэрэгслээ бэлэн байлгах
- Мал худалдан авсан төлбөрийг газар дээр нь бэлнээр болон бэлэн бусаар хийх бэлтгэлтэй байх
- Боломжтой бол цэг дээр мал худалдан авалт хариуцсан, эсвэл мэргэжлийн төлөөллөө байлцуулах
- Малын зах зээлийн үнээс 5-10 хувь илүү үнээр газар дээр нь худалдан авах урьдчилсан ам тохиролцоог сумын Засаг даргатай албан ёсоор баталгаажуулах

2.4.4 Сумын мал эмнэлгийн тасгийн хариуцах үүрэг, үйл ажиллагаа

- Баталгаажуулах цэгт амьдын үзлэг хийхэд шаардагдах багаж төхөөрөмж, бусад бэлтгэлийг тухай бүр хангах
- Баталгаажуулах цэгт мал борлуулах зарласан өдөр тасгийн мэргэжилтнийг өөрийн биеэр саадгүй ажиллуулах
- Борлуулахаар тэнцсэн болон үнэ тохирч худалдах мал тасаг дахь малын эрүүл мэндийн бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг заавал тулгах

2.5 Малыг үржилд бөөнөөр худалдах, худалдан авах, солилцоход зөвхөн баталгаажуулах цэгийн байгууламжийг ашиглаж болно. Гэхдээ энэ нь цэгийн үндсэн зориулалт, үйл ажиллагаанд хамаарахгүй

2.6 Баталгаажуулах цэгээр бүх төрлийн малыг нас, хүйс харгалзахгүй борлуулна.

2.7 Хэрэв худалдан авах этгээд /мах боловсруулах, мал нядлах үйлдвэр гэх мэт/-ийн тусгай шалгуур, шаардлагын дагуу төрөлжүүлсэн /тухайн жилийн төл, өсвөр мал, эсвэл нэг хүйсийн мал гэх мэт/ байдлаар хянан баталгаажуулах ажлыг зохион байгуулж болно.

Гурав. Малын чанарыг хянан баталгаажуулах

3.1 Доор дурдсан гаднын шинж, хэмжиж тодорхойлдог нийтлэг үзүүлэлт, мэргэжлийн үзлэг, ажиглалтаар тогтоох үйлдлийг Малын чанарын хянан баталгаажуулах гэнэ. Үүнд:

3.1.1 Баталгаажуулах цэгт ирсэн малыг амьдын жингээр авах бол сүүлийн 12 цагийн дотор усалгүй, гэжээлгүй, өлөн байлгах ёстой. Энэ тухай мал авчирсан хүнээс лавлагаа авах, мөн үзлэг хийх замаар шалгаж, тавигдах шаардлагыг нарийн мөрдөнө.

3.1.2 Амьдын үзлэг. Малыг пүүлэх, шүдлэх, эрүүл мэндийн үзлэг хийхээс өмнө ажиглах, тэмтрэх, шалгах зэрэг механик аргаар физиологийн ба биеийн гаднах байдлыг тогтоох

- Ил шарх, гүн сорви
- Галбирын ба биеийн үзэгдэх хэсгийн гэмтэл – сохор, шүдгүй, доголтон

- Нас – шүдлэх болон бүртгэлээр тогтоох,
- Хээлтэй эсэх – зөвхөн бодын хээлтэгчийг дээр тэмтрэх, дарах аргаар хээлтэй эсэхийг шалгах,
- Хөхүүл эсэх – дэлэн, хөхийг ажиглах, тэмтрэх, хөхийг шувтрах,
- Засаатай, асман, төмсөг татуу/буугаагүй – хуц, ухна, бодын хээлтүүлэгчийг үзлэгт нарийн хамруулах.

3.2 Малын чанар, эрүүл мэндийн үзлэг, баталгаажуулалт

- Амьдын жин – пүүлэх ба биеийн хэмжээгээр тооцоолох,
- Биеийн хэмжээг тодорхойлох – адууны мундааны өндөр гэх мэт,

Дөрөв. Баталгаажуулах цэгийн ажиллах хугацаа

4.1 Баталгаажуулах цэгийн ажиллах хугацааг төслийн хүрээнд мал борлуулалтын улирал, худалдан авагч компанийн санал зэргийг харгалзан тогтооно.

4.2 Борлуулах малд үзлэг, шинжилгээ хийх, чанарыг баталгаажуулах ажлыг жил бүрийн 6 дугаар сарын 15-с оройтуулалгүй эхлүүлж, 11 дүгээр сарын дундуур тасалбар болгох.

Тав Баталгаажуулах цэгийн үйл ажиллагааны тайлагналт

5.1 Баталгаажуулах цэгт тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг сумын ХАА-н тасаг, Мал эмнэлгийн тасаг хамтран нэгтгэн гаргаж жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж сумын Засаг даргад ирүүлнэ.

5.2 Баталгаажуулах цэгээр борлуулсан малын тоо, олгосон урамшуулал, борлуулалтын нийт орлогын тооцоог малчдын бүлэг, малчин өрх тус бүртэй нэг бүрчлэн хийж, цэгийн үйл ажиллагааны тайланд тусгана.

5.2.2 Экосистемийн үйлчилгээний төлбөрийг нэвтрүүлэх нь

Экосистемийн үйлчилгээний төлбөр /ЭСҮТ/ гэдэг нь усны хагалбар, ой хамгаалахаас эхлээд нүүрс хүчлийн хийг шингээх, үзэсгэлэнт байгалийг хамгаалах зэрэг байгаль орчны үйлчилгээ үзүүлэх ашиг сонирхолтой /тухайн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэгтэй ч гэж болно/ байгууллагын зүгээс өөрийн ашиглаж байгаа газар дээр эдгээр үйлчилгээг үзүүлж байгаа этгээдэд олгож байгаа татаас, төлбөрийн тогтолцоо юм¹.

ЭСҮТ-г Монгол орны байгаль орчныг хамгаалах, малчдын амьжиргааг тогтвортой бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг даван чадвартай болгоход хамгийн үр өгөөжтэй хэрэглэх шаардлага тулгараад байна. Энэ үүднээс Бодлого судлалын төвөөс урьд нь хэд хэдэн төслийн хүрээнд туршсан ажлын үр дүнг үндэслэн дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

- Байгальд ээлтэй аргаар буюу малын тоог бус ашиг шим, борлуулалтыг нэмэгдүүлэх замаар орлогоо өсгөж байгаа малчдад урамшуулал олгох зарчмыг төслийн сумдад нэвтрүүлэх
- ЭСҮТ бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан малчдад мал борлуулалтын урамшуулал хэлбэрээр олгох, ингэхдээ хэрэгцээлсэн /зах зээлд маханд борлуулсан болон хүнсэнд хэрэглэсэн малын нийлбэр/ малын 1 хонин толгой дутам 750 төгрөг буюу оны эхний малын тоогоор тооцсоноор хонин толгой дутам 300 төгрөг олгох (2022 онд төсөлд хамрагдаж, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан малчдын бүлгийн гишүүн малчдад олгох мал борлуулсны урамшууллын тооцоог сум бүрээр Хавсралт 5.2.5В, Г -д харуулав)
- Мал борлуулсны урамшууллыг эхний жилд төслөөс гаргаж, түүний ач холбогдол, үр өгөөжийг малчид болон орон нутгийн захиргаанд бодитой ойлгуулах, холбогдох чадавхжуулах сургалтыг сумдын ИТХ, Засаг даргын тамгын газар болон малчдад хийх.

¹ ДДБХС (WWF), 2021

Харин 2 дахь жилээс эхлэн малын тоо толгойн албан татварын орлогоос олгож, тогтвортой байдлыг нь хангах.

- ЭСҮТ-г малын тоо толгойн албан татварт тусгаж хэрэгжүүлэхийн давуу тал:
 - Байгаль орчныг хамгаалах, бэлчээрийн менежментэд хөрөнгө зарах Төсвийн хуультай нийцсэн
 - Байгаль хамгаалахад орон нутагт тулгарч буй гол бэрхшээл болсон санхүүгийн дутагдлыг шийдэх боломжтой
 - Биологийн олон янз байдалд учирч байгаа гол аюул бэлчээрийн доройтлыг бууруулна
 - Хүлэмжийн хийг бууруулна, малын тарга хүч ашиг шим, малчдын орлого, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх гээд олон эерэг үр дагавартай

Мал борлуулсны урамшууллыг төслөөс олгох журам

1. Мал борлуулсны урамшууллын санхүүжилтийг төслөөс хүлээж авч, малчдад шилжүүлэх хуулийн этгээдийг малчдын төрийн бус байгууллагын хэлбэрээр аймагт байгуулах
2. Урамшуулал олгох малын тоо, төрлийг **Хүснэгт 1**-д заасан хүснэгтийн дагуу бөглөж, жил бүрийн 8-12 сарын хугацаанд сар бүр төсөлд ирүүлэх /Малчдын ТББ хариуцах/. Үүнд дараах бичиг баримтыг хавсаргах:
 - а. Өнгөрсөн хугацаанд борлуулсан малын бодит болон хонин толгойн дүнгийн нэгтгэл /**Хүснэгт 2**/
 - б. Борлуулсан малыг батлах мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн лавлагааны /эх хувь, аль эсвэл түүний сканердсан, олшруулсан фото хувь/.
3. Ирүүлсэн бичиг баримтыг үндэслэн төслөөс санхүүжилтийг ТББ-н дансанд шилжүүлэх
4. Ирсэн санхүүжилтийг малчдын дансанд шилжүүлэх
5. Санхүүжилтийн зарцуулалтын тайланг малчдын ТББ сар бүр төсөлд ил тод тайлагнах
6. ЭСҮТ олгосноор малын тоо буурсан үр дүнг жилийн эцсийн мал тооллогын дүнг үндэслэн малчдын ТББ төсөлд тайлагнах

Хүснэгт 1 Бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж, төсөлд хамрагдсан малчдын урамшуулал олгох малын тоо, төрөл

№	Малчдын бүлгийн нэр	Борлуулах малын тоо					Дүн, хонин толгойгоор
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							
9							
10							
11							
12							
	Дүн						

Малын төрлийг хонин толгойд шилжүүлэхдээ хонь 1, ямаа 0.9, адуу 7, үхэр 6, тэмээ 5 гэсэн бэлчээрийн тэжээлийн хэрэгцээнд үндэслэсэн албан ёсны итгэлцүүрийг ашиглана.

Хүснэгт 2 Мал борлуулсны урамшууллын нэгтгэл

№	Малчин өрхийн нэр	Борлуулсан малын тоо						Олгосон урамшуулал, мянган төгрөг
		тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Дүн, хонин толгойгоор	
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								
9								
10								
11								
12								
	Дүн							

Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн албан ёсны лавлагааны жишээ

6/15/2021

<https://vet.certificate.mn/megs/675530>



МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ

МЭГ дугаар: Meg675530

Гэрчилгээ гаргасан: Мэнд сүрэгтэн

Баталсан: Завхан, Тосонцэнгэл
сумын мал эмнэлгийн тасаг.

Зориулалт: Хүнсэнд

Хүчинтэй хугацаа: 2021/06/11 - 2021/06/18

Үүсгэсэн огноо: 2021-06-11 11:30

Баталсан огноо: 2021-06-11 11:32

Малын мэдээлэл

№	Төрөл	Нас	Хүйс	Дугаар
1	Хонь	4	Эр	s-35557420
2	Хонь	4	Эр	s-35557421
3	Хонь	4	Эр	s-35557422
4	Хонь	4	Эр	s-35557423
5	Хонь	4	Эр	s-35557424
6	Хонь	4	Эр	s-35557425
7	Хонь	4	Эр	s-35557426
8	Хонь	4	Эр	s-35557427
9	Хонь	4	Эр	s-35557428
10	Хонь	4	Эр	s-35557429
11	Хонь	4	Эр	s-35557430
12	Хонь	4	Эр	s-35557431
13	Хонь	4	Эр	s-35557432
14	Хонь	4	Эр	s-35557433
15	Хонь	4	Эр	s-35557434
16	Хонь	4	Эр	s-35557435
17	Хонь	4	Эр	s-35557436
18	Хонь	4	Эр	s-35557437
19	Хонь	4	Эр	s-35557438
20	Хонь	4	Эр	s-35557439
21	Хонь	4	Эр	s-35557440
22	Хонь	4	Эр	s-35557441
23	Хонь	4	Эр	s-35557442
24	Хонь	4	Эр	s-35557443
25	Хонь	4	Эр	s-35557444
26	Хонь	4	Эр	s-35557445
27	Хонь	4	Эр	s-35557446
28	Хонь	4	Эр	s-35557447
29	Хонь	4	Эр	s-35557448
30	Хонь	4	Эр	s-35557449
31	Хонь	4	Эр	s-35557450
32	Хонь	4	Эр	s-35557451
33	Хонь	4	Эр	s-35557452
34	Хонь	4	Эр	s-35557453
35	Хонь	4	Эр	s-35557454
36	Хонь	4	Эр	s-35557455
37	Хонь	4	Эр	s-35557456
38	Хонь	4	Эр	s-35557457
39	Хонь	4	Эр	s-35557458

<https://vet.certificate.mn/megs/675530>

1/2

40	Хонь	4	Эр	s-35557459
41	Ямаа	5	Эр	s-35557460
42	Ямаа	5	Эр	s-35557461
43	Ямаа	5	Эр	s-35557462
44	Ямаа	5	Эр	s-35557463
45	Ямаа	5	Эр	s-35557464
46	Ямаа	5	Эр	s-35557465
47	Ямаа	5	Эр	s-35557466
48	Ямаа	5	Эр	s-35557467
49	Ямаа	5	Эр	s-35557468
50	Ямаа	5	Эр	s-35557469
51	Ямаа	5	Эр	s-35557470
52	Ямаа	5	Эр	s-35557471
53	Ямаа	5	Эр	s-35557472
54	Ямаа	5	Эр	s-35557473
55	Ямаа	5	Эр	s-35557474
56	Ямаа	5	Эр	s-35557475
57	Ямаа	5	Эр	s-35557476
58	Ямаа	5	Эр	s-35557477
59	Ямаа	5	Эр	s-35557478
60	Ямаа	5	Эр	s-35557479

Хаанаас:

Нэр: НАРАНБА

Хаяг: Завхан, Тосонцэнгэл , 6-р баг, Идэр

Утас:

Хаашаа:

Нэр: эмээлт захад

Хаяг: Улаанбаатар, Сонгинохайрхан , 32-р хороо

Утас: -

Бэлчээрийн төлөв байдал:

Тодорхойгүй

Хариуцагчийн мэдээлэл:

Нэр: Лхамсүрэн

Утас: 99459999

Тээврийн хэрэгсэл: 7091УНЦ

Тайлбар:

Санамж: Энэхүү МЭГ нь амьтан болон амьтны гаралтай бүтээгдэхүүнийг өвчингүй бус нутгаас гаралтай, шаардлагатай вакцинд хамрагдсан, тухайн үед эрүүл байгаа, хүнсэнд хэрэглэх бол эмийн үлдэгдэлгүй гэдгийг баталгаажуулна. Лавлагаа мэдээллийг МЭГ-ын мэдээллийн нэгдсэн сан www.vet.certificate.mn сайтаас шууд авах боломжтой. Ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд 51261601 дугаараар холбогдон тайлбар мэдээлэл авч болно.

5.2.3 Сумын холбогдох албан тушаалтны ажил, үүргийн хуваарийг тодорхой болгож, хоорондын уялдаа холбоог хангах замаар бэлчээр, хадлан, усны нөөцийн менежментийг сайжруулах зөвлөмж

Үндэслэл

Сумын түвшинд МАА-н үйлдвэрлэлд ашиглагддаг байгалийн үндсэн нөөц болсон бэлчээр, хадлан, ус/худгийн менежментийн нөхцөл байдлыг тодорхойлбол төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих ажлын эзэн, зохицуулалт тодорхойгүйгээс энэ ажил үндсэндээ урсгалаараа явж, тогтвортой ашиглалт, хамгаалалт орхигдож ирсэн байна.

Эрх зүйн зохицуулалт

Хууль эрх зүйн үүднээс авч үзвэл Монгол Улсын үндсэн хуулийн 6 дугаар бүлгийн 6.1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэж заасан байдаг. Энэхүү заалтаас байгалийн нөөц, баялаг төрийн хамгаалалтад байх ёстой гэсэн үндсэн нөхцөлийг тодорхойлж байгаа бөгөөд төр бүх шатны байгууллагаараа дамжуулан энэхүү нөхцөлийг хангаж ажиллах шаардлагатай юм.

Үндсэн хуульд заасан байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах үйл ажиллагааг эрх зүйн хувьд зохицуулж, үйлчилж байгаа дараагийн шатны хууль нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль юм. Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчин-ыг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино гэж тодорхойлсон байдаг байна.

Мөн газрын тухай хуулиар газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахаар заасан байна. Өөрөөр хэлбэл тус хуулиар газрын ашиглалт, хамгаалалттай холбоотой харилцааг зохицуулж байгаа юм. Газрын тухай хуульд “газар” гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг гэж тодорхойлсон байна. Энэ тодорхойлолтоос үзвэл газар гэдэг ойлголтод байгалийн бүх нөөц багтаж байгаа нь тодорхой байна.

Мөн холбогдох хууль тогтоомжид Газар зохион байгуулалт нь газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавх, нөөцийг нэмэгдүүлэх, газар зүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий цогцолбор арга хэмжээ мөн гэж тодорхойлсон байдаг.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөө нь сум, дүүргийн газар нутгийн хэмжээнд хэчнээн хэмжээний газрыг хаана, ямар зориулалтаар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах нөөц боломжийг тодорхойлсны үндсэн дээр хэрхэн зохистой өмчлөл, эзэмшил, ашиглалтыг буй болгох болон газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тооцоо, дүгнэлт, зураг төслийн аргаар тодорхойлсон баримт бичиг байхаар тусгажээ. Мөн баримтлах зарчмын тухайд сумын тухайн жилийн төлөвлөгөөгөөр авч явуулж байгаа арга хэмжээ нь газрын үржил шимийг байнга дээшлүүлэхэд, газрыг хамгаалахад, унаган төрхөөр нь хадгалахад чиглэсэн, тухайн нутаг дэвсгэрт газрын харилцааг зохицуулахад төлөвлөлтийн аргаар дэмжлэг үзүүлж байхыг тодорхойлж өгсөн байдаг.

Зорилго

Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгалийн нөөц ашиглалт, хамгаалалтыг төлөвлөх, хяналт тавих орон нутгийн чадавхыг бэхжүүлэх замаар байгалийн нөөцийн менежментийн тогтвортой байдлыг хангах нь энэ ажлын гол зорилт юм. Энэхүү зорилтыг дараах цогц араг хэмжээгээр дамжуулан хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

- Сумын тухай жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд байгалийн нөөц ашиглалтыг иж бүрэн тусгасан эсэхийг сумын засаг дарга, ГХБХБГ хянаж, сумын ИТХ баталдаг, хэрэгжилтэд хяналт тавьдаг тогтолцоог хэвшүүлэх
- Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд байгалийн нөөц ашиглалтын чиглэлээр туссан ажлыг хэрэгжүүлэх санхүүжилтийг сумын төсөвт заавал суулгаж төлөвлөгөөнд туссан ажил бүрийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх
- Сумын ЗДТГ-ын газрын даамал, ХААТ-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, БОУХБ нарын төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд /хариуцах ажил үүргийн хуваарьт/ ХААТ-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн хариуцах талаар ажил үүргийн нарийн талаар давхардалгүй, хариуцлагыг нарийвчлан заагласан хуваарь гаргах
- Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний байгалийн нөөц ашиглалтын чиглэлээр сумын удирдлага, мэргэжилтнүүд, малчид, мал бүхий иргэд, НАБ-ийг байгалийн нөөц ашиглалт, хамгаалалтын чиглэлээр сургалт явуулан чадавхжуулах

Дээрх зорилт, арга хэмжээг сумын ИТХ, Засаг дарга, газрын даамал, ХАА-н тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, БОУХБ, байгаль хамгаалагч, НАБ зэрэг олон талуудын идэвхтэй хамтын ажиллагаагаар хэрэгжүүлэх бөгөөд гол хэрэгсэл нь сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө юм.

Дээрх зорилт, араг хэмжээг тогтвортой хэрэгжүүлэх шаардлагыг хангасан бөгөөд холбогдох хууль, журамд нийцсэн албан тушаалтны оролцоо, чиг үүргийг хэрэгжүүлэх үе шат, хугацааг харуулсан сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах ажил үүргийн хуваарь, графикийн үлгэрчилсэн загварыг төслийн сумдад хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Санал болгож байгаа ажил, үүргийн хуваарийг Хавсралт 5.2.3-д харуулав.

5.2.4 Хурга махлуулж, борлуулах замаар бэлчээрийн ачаалал бууруулж, мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг дээшлүүлэх зөвлөмж

Малын тоо толгой огцом өссөн явдал бэлчээрийн даац хэтрэх гол шалтгаан болж байна. Тайлангийн 2.1-д дурдсанчлан бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан малчдын бүлгийн бэлчээрийн даац олон дахин хэтэрч, мал дутуу хооллон давжаарч ашиг шим нь буурч, үүнийг дагаад малчдын амьжиргаа тогтворгүй болж, уур амьсгалын өөрчлөлтөд улам бүр эмзэг болж байна.

Жилээс жилд мал сүргийн тоо өсөөд байгаагийн нэг бодит шалтгаан нь дутмаг тэжээллэгтэй байгаагаас үүдэн мал тухайн насныхаа жинд хүрэхгүй болж, өсвөр насны буюу төлөг, борлонгийн борлуулалт байхгүй болж нас гүйцсэн буюу 4 нас хүрч байж борлуулах жинд хүрч байгаагаас бэлчээрт байх малын тоо олшрох гол хүчин зүйл болж байна.

Малчдын ашиг орлогыг бууруулахгүйгээр малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх дөт зам нь хонийг эрт төллүүлэн, төллөсөн эх малыг тэжээж жилбэжүүлэн, сүү шимээр дамжуулан хургыг махлуулан эдийн засгийн эргэлтэд оруулах явдал юм.

Ингэснээр малыг бэлчээрт заавал 3-4 жил барих шаардлагагүй болж, бэлчээрээ олон малаас чөлөөлж хамгаалах боломжтой болох юм /Зураг 5.2.4.1 /.

Зураг 5.2.4.1 Хонины амьдын жингийн өөрчлөлт, жилээр, кг



Хурга махлуулж, борлуулах нь мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх загвар болох нь

Хурга борлуулах тооцоог хонин сүргийн эргэлтийг үндэслэн 4 хувилбараар гаргав. Үүнд малын тоог жилд дунджаар 10% өсгөж байгаа сүүлийн жилүүдийн нөхцөл /А хувилбар/-г малын тоог өсгөхгүйгээр барьж, эр хургыг түлхүү борлуулах 3 хувилбар /Б-Г хувилбар/-тай харьцуулав.

Хурга борлуулах боломж нь сүрэгт эзлэх эх малын хувийн жингээс шууд хамааралтай байдаг тул эх малын хувийн жин одоогийн 45% орчим байгаа нөхцөлд эр хурганы 6%, охин хурганы 3%-г л борлуулах боломжтой бол эх малын хувийн жинг өсгөх дутам борлуулах боломжтой хурганы тоо, үүнийг дагаад мах үйлдвэрлэл эрс нэмэгдэж байна /Хүснэгт 5.2.4.1 /

5.2.4.1 Хурга борлуулснаар мах үйлдвэрлэл, орлого нэмэгдэж, шаардагдах бэлчээрийн тэжээлтийн хэрэгцээ багасгах нь, 100 хонь тутам

	Сүрэгт хээлгэгчийн эзлэх хувь	Хурга борлуулах хувь	Мах үйлдвэрлэл, кг	Шаардагдах бэлчээрийн тэжээлийн хэрэгцээ			Махны орлого, сая төгрөг	Малчдын махны орлогын өсөлт	
				Нийт тэжээл, цн	Нийт талбай, га	100 кг мах үйлдвэрлэхэд шаардагдах бэлчээр, га		Хувиар	Сая төгрөгөөр
А	45%	Үгүй	526	607	289	55	3.58	-	-
Б	45%	Эр 6%, Охин 3%	709	584	278	39	4.82	34.7%	1.24
В	60%	Эр 72%, Охин 5%	884	602	287	32	6.01	68.0%	2.43
Г	70%	Эр 95%, Охин 16%	1001	614	293	29	6.81	90.3%	3.23

Тайлбар: А - одоогийн нөхцөл, малаа жилд 10% өсгөнө, хурга борлуулахгүй, Б - малаа өсгөхгүй, тогтмол хэмжээнд барьж, хурга борлуулна, В - малаа өсгөхгүй, тогтмол хэмжээнд барьж, хурга борлуулна. Малчдын борлуулж буй махны 1 кг-н үнийг 2019-2021 оны 3 жилийн улсын дундаж 6800 төгрөг, бэлчээрийн ургацыг 2016-2020 оны 5 жилийн улсын дундаж ургац 2.1 цн, махлуулсан эр хурганы намрын амьдын жинг дунджаар 42.5 кг (нийт махлуулсан эр хурганы 50% нь 45 кг, 50% нь 40 кг хүрэх тооцоо), нядалгааны гарцыг 43%-р тус тус тооцов.

А-с Г-д шилжих дутам мах үйлдвэрлэл нэмэгдэж, шаардагдах бэлчээр багасан бүтээмж, орлого нэмэгдэж байна. Тухайлбал ижил 100 кг махыг Г хувилбараар 29 га бэлчээрт үйлдвэрлэж байгаа нь одоогийн нөхцөл болох А хувилбарын 55 га-аас 26 га-аар бага буюу бэлчээрийн хэрэгцээг 47% бууруулж байна.

Хамгийн гол нь малчдын мах үйлдвэрлэлээс олох орлого 100 хонь дутам одоогийнхоос 1.2-3.2 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

Хургыг борлуулах замаар МАА-н үндэс болсон бэлчээрээ хамгаалж, малчдын амьжиргааг урт хугацаанд тогтвортой дээшлүүлэх боломжтой юм. Үүнийг хургыг махлуулах туршилтын ажлын эдийн засгийн тооцооноос харж болно.

Хургыг намар 45 кг амьдын жинд хүргэх зорилгоор:

- Махны чиглэлийн Баяд хуцыг хээлтүүлэгчээр ашиглах
- Төллөсөн эр хургатай эх хонийг хоногт 250 грамм сайн чанарын хүчит тэжээлээр 45 хоногийн хугацаанд нэмэгдлээр тэжээж, эхийг жилбэжүүлэхийн зэрэгцээ бэлчээрт явах зайг багасгах замаар дагасан хурганы явдлыг багасгаж махлуулах
- Хургыг 7-р сарын сүүлчээр хургыг эхээс нь ялгаж тусад нь суурь зохион байгуулж сайн бэлчээрт оторлох ажлыг гүйцэтгэнэ
- Тэжээлийн зардалд 100 хонь тутамд тооцож 1.1 сая төгрөг, хурганы маллагааны хөлсөнд сарын 0.3 сая төгрөг, гурван Баяд хуц худалдан авахад 0.9 сая төгрөг нийт гарсан зардал 2.3 сая төгрөгийн зардал гарна.

Хургыг махлуулж борлуулснаар мах үйлдвэрлэлээс малчдын олох нэмэгдэл орлого сүрэгт эзлэх эх малын хувийн жин 70% байхад 3.23 сая төгрөг болж байгаа билээ. Дээрх нэмэгдэл орлогоос хурганы мах үйлдвэрлэхэд гарах зардал 2.3 сая төгрөгийг хасвал малчид 100 хонь дутам 0.9 сая төгрөгийн цэвэр орлого буюу ашиг олохоор байна. Хурганы мах үйлдвэрлэлийн орлого, ашгийн тооцоог 500 хоньтой малчин өрхийн жишээн дээр харьцуулан гаргав.

Хүснэгт 5.2.4.2 500 хоньтой малчин өрхийн хонины махны орлогын харьцуулалт

Үзүүлэлт	Одоогийн нөхцөлд	Эх малын хувийн жинг 70% хүргэж хурга борлуулснаар
Малын тоо, толгойгоор	500	500
Үйлдвэрлэх мах, тонн	2.63	5.0
1 кг махны үнэ, төгрөг	6800	6800
Махны нийт орлого, сая төгрөг	17.9	34.0
Хурга махлуулах зардал, сая төгрөг	-	11.5
Бусад шууд зардал*	5.3	5.3
Нийт зардал	5.3	16.8
Цэвэр орлого	12.6	17.2

*Үүнд тэжээл, мал эмнэлэг, тээвэр, шатахуун, хариулгын хөлс багтсан бөгөөд хоёр дахь эх үүсвэрийн судалгааны материалыг ашиглав. Харин малчин өрхийн амьжиргааны зардал ороогүй болно.

Хурганы мах үйлдвэрлэхийн давуу тал нь бэлчээрийн ачааллыг бууруулж, махны нийлүүлэлт, малчдын орлогыг нэмэгдүүлэхээр хязгаарлагдахгүй юм. Хурганы мах нь холестерин бага тул зүх судасны өвчлөл өндөр Монгол орны хүн амын эрүүл мэндэд ихээхэн ач холбогдолтой юм. Хурганы махны эрүүл мэндийн давуу давуу тал:

- Зүрх судасны өвчний нэг шалтгаан болсон холестерин 100 грамм хурганы маханд 96 мг байдаг нь нас гүйцсэн хонины махнаас 13 мг-р бага

- Өөхөн судлын хэмжээ бага, өөхний 64% нь эрүүл мэндэд хоргүй ханаагүй өөх байдаг
- Өндөр чанартай уураг, В аминдэм, цайр, төмөр зэрэг эрдсээр баялаг
- Хүний биед нэн чухал 8 төрлийн амин хүчлийг хамгийн зөв харьцаатайгаар агуулдаг
- Хүний бие организм бий болгож чаддаггүй нийлмэл линолиний хүчлийг агуулдаг нь хоргүйжүүлэх (anti-oxidant), дархлааг сайжруулах үйлчилгээтэй байдаг байна.

Эрүүл мэндийн давуу талын улмаас хөгжингүй орнуудын зах зээл дээр нас гүйцсэн хонины махнаас хурганы мах гуравны нэгээр илүү үнэтэй байдаг тул махны экспортын орлогыг нэмэгдүүлэх боломжтой.

Дээрх бодит судалгаа, тооцоог үндэслэн төсөл хэрэгжиж байгаа сумдад аль эсвэл аймаг бүрээс тодорхой сумдыг сонгон хурга махлуулж, борлуулах ажлыг ажлыг туршин нэвтрүүлэхийг зөвлөж байна.

Хургыг махлуулж, борлуулах ажлын төсөв нь нэг суманд 100 хургаар тооцвол 18 сая төгрөг болох бөгөөд үүнд хурга махлуулах тэжээл, хуц худалдан авах, хариулгын хөлс зэрэг шууд зардалд 2.3 сая төгрөг, загварыг малчид, орон нутгийн захиргаанд ойлгуулж, чадавхжуулах, хурганы махыг худалдан авагчийг олж, борлуулахад дэмжлэг үзүүлэх мэргэжлийн зөвлөх багийн ажлын хөлс, унаа, томиллогод 15 сая төгрөг, хургыг борлуулах сурталчилгааны зардалд 0.7 сая төгрөг орно.

5.2.5 Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх бэлчээр ашиглалтын гэрээний үүргийн хэрэгжилтийг хангахад ашиглах эдийн засгийн тооцоо, зөвлөмж

Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх үндэслэл

- Малаа аж ахуйн эргэлтэд оруулсан, бэлчээрийн даацад тохирсон байгаль орчинд ээлтэй, эрүүл, тарга тэвээрэг сайтай малтай, МАА-н орлого нь тогтмол өссөн, хөдөлмөрийн ачаалал тохирсон эрсдэлгүй бэлчээрийн мал аж ахуй эрхлэх
- Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүртээмжтэй, ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих...
- Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, даац багтаамжийг тохируулах

Малчид яагаад малын толгойн тоогоор хөөцөлддөг вэ, тэд буруутай юу?

Нөхцөл байдалдаа тохируулан хамгийн хямд аргаар хөрөнгө, орлогоо нэмэгдүүлэх гэж өрсөлдөн уралдах нь зах зээлийн эдийн засгийн зарчим юм. Малчинд үйлчилж байгаа сонирхлын өнөөгийн механизм дараах зүйлд оршиж байна. Үүнд:

- Бэлчээр, түүн дээр байгаа ус, хужир мараа гээд аливаа нөөцийг үнэ төлбөргүй ашигладгийн зэрэгцээ даацыг нь хэтрүүлж талхалсан ч ямар ч хариуцлага хүлээдэггүй нийтээр дундаа ашигладаг тогтолцоо
- Малын тоог бэлчээрийн даацад тохируулахад урамшуулах хөшүүрэг байхгүй
- Мал, бүтээгдэхүүний чанарыг хөхүүлсэн эдийн засгийн урамшууллын, нэн ялангуяа үнийн урамшууллын тогтолцоо байхгүй
- Мал, бүтээгдэхүүний чанарын хяналт, стандартын тогтолцоо ажиллахгүй байна

Ийм нөхцөлд малынхаа тоог өсгөх нь хөрөнгө, орлогоо өсгөх хамгийн амар арга гэдгийг өнөөдрийн эрх зүй зохицуулалтын орчин, сонирхлын механизм малчдад тулган хүлээлгэсэн байна, малаа өсгөсөнд малчныг буруутгах аргагүй байх нь.

Эдийн засгийн сонирхлыг эдийн засгийн сонирхлын хөшүүргээр л шийдэж чадна

Малын тоогоор хөөцөлдсөн малчдын сэтгэлгээг хөрөнгө, орлогоо өсгөх гэсэн эдийн засгийн сонирхлоор нь дамжуулж өөрчлөхөөс өөр гарц байхгүй юм. Өөрөөр хэлбэл малын тоог

бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх нь өөрсдөд нь ямар ашигтай болохыг эдийн засгийн бодит тооцоон дээр үндэслэн малчдад ойлгуулж чадвал малчид малынхаа тоог цөөлөх алхмыг зоригтой хийж, бэлчээр ашиглалтын гэрээний үүргээ биелүүлдэг болохыг Бодлого судлалын төвөөс хэрэгжүүлсэн туршилтууд харуулсан юм.

Эдийн засгийн тооцоог хийхдээ таван төрлийн малын сүргийн эргэлтийн загвар, малын ашиг шим, бүтээгдэхүүн борлуулах сүүлийн 3 жилийн дундаж үнэ зэрэг бодит үзүүлэлтийг ашиглан малчдын олох нийт болон мөнгөн орлогыг малаа өсгөх одоогийн хувилбарыг малаа аажим буюу хонин толгойн дүнгээр жилд 5% бууруулах хувилбартай харьцуулан гаргана. Энэхүү эдийн засгийн тооцоог дундаж малчин өрхийн жишээн дээр болон сумыг дүнгээр гаргаж малчдад явуулах нүүр тулсан сургалтад ашиглах бөгөөд үүний үр дүнд сумын малчдын 10-15% хувь нь малаа цөөлөх хувилбарыг шууд дэмжиж төсөлд хамрагддаг болохыг туршлага харуулсан болно.

Эдийн засгийн тооцоог Завхан аймгийн Тосонцэнгэл сумын жишээн дээр дор харуулав.

Хүснэгт 5.2.5.1 Малчин өрхийн малын тоо буурсан ч орлого нэмэгдэх тооцоо

Үзүүлэлт	Суурь	I жил	II жил	III жил	IV жил	V жил
Сумын мал, мянган толгой	186305	176990	168140	159733	151747	144159
Сумын мал, мянган хонин толгой	410915	390369	370851	352308	334693	317958
Малчин өрхийн нийт орлого ¹ мянган төгрөг	8557	12877	12988	13094	13195	13130
Өрхийн дотооддоо хэрэглэсэн бүтээгдэхүүн, мянган төгрөг	3565	3565	3565	3565	3565	3565
Малчин өрхийн мөнгөн орлого, мянган төгрөг	4992	9312	9423	9529	9630	9565
Мал цөөлснөөр хадгаламж, хөрөнгө оруулалтын эх үүсвэр бүрдүүлэх боломж, мянган төгрөг	0	1668	1631	1594	1558	1523
I хонин толгойд ногдох мөнгөн орлого, мянган төгрөг	15.2	32.2	33.6	35.8	38.1	39.8

Эх сурвалж: БСТ-н тооцоо

Малаа өнөөгийн байдлаар өсгөсөн тохиолдолд малчин өрхийн орлого хэрхэн өсөж байгааг Хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5.2.5.2 Малын тоог өсгөн өрхийн орлогыг нэмэгдүүлэх тооцоо

Үзүүлэлт	Суурь	I жил	II жил	III жил	IV жил	V жил
Сумын мал, мян тол	186305	197483	209332	221892	235206	249318
Сумын мал, мян хонин тол	410915	435570	461704	489407	518771	549897
Малчин өрхийн нийт орлого, мянган төгрөг	8557	8557	8793	9031	9269	9509
Өрхийн дотооддоо хэрэглэсэн бүтээгдэхүүн, мянган төгрөг	3565	3565	3565	3565	3565	3565
Малчин өрхийн мөнгөн орлого, мян. төгрөг	4992	4992	5228	5466	5705	5944
Малын тооны бууралтад ногдох орлого, мян. төгрөг	0	0	0	0	0	0
I хонин толгойд ногдох мөнгөн орлого, мян төгрөг	15.0	15.0	14.7	14.4	14.1	13.8

Малын өсөлтөд ноогдох бүтээгдэхүүн	2073	2073	2210	2356	2512	2679
Малын өсөлтийг оруулсан нийт орлого	10630	10630	11003	11387	11782	12188

Эх сурвалж: БСТ-н тооцоо

Дээрх хүснэгтээс харвал малчин өрхийн нийт болон мөнгөн орлого малаа цөөлөх үед малаа өсгөх үеийнхээс илүү байгаа нь тодорхой байна. Энэ нь малын тоог цөөлснөөр үлдэх малын тэжээл хангамж, ашиг шим сайжирсны дээр малаа аж ахуйн эргэлтэд оруулж, илүү борлуулснаар махны мөнгөн орлого өсдөгтэй холбоотой юм.

Малын тоог цөөлснөөр бэлчээрийн ачаалал багасаж, биологийн олон янз байдлын амьдрах орчин тэлдэг нь нэн чухал эерэг нөлөө юм.

Хүснэгт 5.2.5.3 Сумын бэлчээрийн даац, ачаалал, хонин толгойгоор

Бэлчээрийн даац	237175	237175.1	237175.1	237175.1	237175.1	237175.1
Бэлчээрийн ачаалал бүгд	417922	389818	377963	359346	341652	324771
- Том мал	410915	382638	370851	352308	334693	317958
- Төл	7007	7181	7112	7038	6959	6813
Бэлчээрийн даац ашиглалтын хувь	176.2	164.4	159.4	151.5	144.1	136.9
Дутуу хооллолтын хувь	43.2%	39.2%	37.2%	34.0%	30.6%	27.0%

Хүснэгтээс хараад бэлчээрийн даац хэтрэлт, малын дутуу хооллолт багассанаар тарга тэвээрэг, нэгжийн ашиг шим сайжрах үндэслэл болж байна.

Малын тоог цөөлөх, барих, өсгөх үед эдийн засгийн эргэлт хурдсаж, бэлчээрийн ачааллыг бууруулах 2-оос дээш насны эр малын тоо багасаж байгааг дор үзүүлэв.

Хүснэгт 5.2.5.4 Малын тоог цөөлөх, барих, өсгөх сүргийн эргэлтийн үед эр малын тооны өөрчлөлт

№	Малын төрөл	Малын нас, хүйс	Малын тоо	Малын тоог барих	Малын тоог өсгөх
			цөөлөх	Малд эзлэх хувь	
1	Адуу	3-аас дээш насны эр	10.34	18.5	25.69
2	Үхэр		0.06	8.77	15.68
3	Хонь	2-оос дээш насны эр	6.84	12.87	10.22
4	Ямаа		6.88	14.4	9.94

Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж, түүнд бэлчээрийн даацад тохирсон малын тоог хонин толгойгоор заан түүнээс хэтэрсэн малыг жилд 5%-с ихгүйгээр аажмаар цөөлөх замаар хэрэгжүүлэх юм.

5.2.6 Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн сангийн агуулга, хоорондын уялдааг сайжруулах замаар нөөц ашиглалтын бүлгийг бэхжүүлэх, нөөц ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангах зөвлөмж

Байгалийн нөөц ашиглалтын мэдээллийн сангийн одоогийн байдал

Байгалийн нөөц, түүнийг ашигладаг бүлгийн мэдээлэл нь нөөцийн төрлөөсөө хамаараад өөр өөр байгууллага, тусдаа мэдээллийн санд бүртгэгдэж байна.

Тухайлбал, бэлчээр, хадлангийн нөөцийн ашиглалтыг сумын түвшинд газрын даамал бүртгэж, аймгийн ГХБХБГ газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгддэг бол, ойн нөөцийн ашиглалтыг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын ойн нэгж бүртгэж, байгаль орчны мэдээллийн санд оруулж байна.

Ийнхүү байгалийн нөөц ашиглалтын талаарх мэдээллийг өөр өөр байгууллага тусдаа бүртгэдэг явдал нь мэдээллийн нэгдмэл байдлыг хангахгүйгээр зогсохгүй байгалийн нөөцийн ашиглалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, бэлчээр ашиглалтын хувьд “Ногоон алт” төслийн хүрээнд бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан хэдий боловч тэрхүү гэрээний хэрэгжилтийн талаар тухайн асуудлыг хариуцсан албан хаагч болон БАХ-ын ахлагч гишүүд тодорхой мэдээлэлгүй байна. Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд бэлчээрийн ашиглалтын гэрээний хэрэгжилт, биелэлтийн асуудал тодорхой тусгагддаггүй орхигддог хандлага түгээмэл байна. Мөн газрын нэгдмэл сангийн тайланд зарим сумдад тодорхой хэмжээний ойн сангийн нөөцтэй гэж тусгагдсан байтал эдгээр сумдад ойн менежментийн төлөвлөгөөгүй байна. Түүнчлэн ойн нөөц ашиглалт, хамгаалалтын хувьд зарим сумдад ойн нөхөрлөл байгаа боловч ойн менежментийн төлөвлөгөө, ой зохион байгуулалт хийгдээгүй, ямар ч үйл ажиллагаа явуулдаггүй байдал түгээмэл байна. Мөн сумын газрын нэгдмэл сангийн тайланд тодорхой хэмжээний хадлангийн талбайтай гэж тусгасан боловч тус талбай хаана байдаг, хэрхэн ашиглагдаж байгаа талаар сумын холбогдох албан тушаалтнууд мэдэхгүй байдалтай байна. Хадлангийн талбай ашиглах гэрээ хийх нь ховор бөгөөд намар малчид, иргэд, аж ахуй нэгжүүд тодорхой бэлчээрийг байнга хаддаг албан бус тогтолцоо бий болсон байна.

Бэлчээрийн фото-мониторингийн мэдээллийн сангийн хүрээнд бэлчээрийн газрын гадаргын хэлбэр, хөрс, ургамалжилт, уур амьсгалын онцлогоор экологийн чадавхын бүлгүүдэд хуваагдаж, энэ нь төлөвлөлт болон мониторингийн үнэлгээний мэдээллийн суурь болж байна. ГЗБГЗЗГ, УЦУОСМХ, холбогдох мэргэжилтнүүд болон ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн, ХААИС-ийн эрдэмтэд, зөвлөхүүдтэй хамтарч боловсруулсан “Монгол орны бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийн загвар нь 2015 онд баталгаажсанаар эдүгээ улсын хэмжээнд бэлчээр ашиглалтыг төлөвлөх, бэлчээрийн төлөв байдлыг үнэлж, хянах арга хэрэгсэл болон ашиглагдаж байна.

Бэлчээрийн фото-мониторингийн хээрийн судалгааг Завхан аймгийн 23 сумдад 440 цэг, Ховд 17 сумдад 203 цэгээр хийж, “sample point” программ дээр боловсруулалт хийж, бэлчээрийн мониторингийн мэдээллийг газрын кадастрын системийн фото мониторингийн хэсэгт бүртгэж үр дүнг гаргадаг байна.

Нөөц ашиглалтын бүлэг, нөөц ашиглалтын гэрээний талаарх мэдээлэл нь газрын албанаас гадуурх бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд албан ёсоор хүрдэггүй тул аймаг, улсад байгаа мэдээлэл нь салбар хооронд зөрүүтэй байна. Энэ нь улс, аймгийн хэмжээнд мэдээлэл үнэн бодитой байх нөхцөлийг хангадаггүй. Суманд байгуулагдсан НАБ-ын мэдээллийг БОХУБ нь аймгийн байгаль орчин аялал жуулчлалын газарт цаасаар өгдөг. Уг газар нь ойн судалгаа хөгжлийн төвд цаасаар өгснөөр eic.mn-д бүргүүлж байна. Гэвч уг мэдээлэл нь өөр бусад мэдээллийн сангууд дахь мэдээлэлтэй уялдаггүй байна.

Орон нутагт нөөц ашиглалтын гэрээтэй холбоотой хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хариуцсан албан тушаалтнуудын хариуцлагын тогтолцоо сул, түүнийг хэрэгжүүлэх хөшүүрэг хангалтгүй байгаатай холбоотой байна. Тухайлбал, “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн систем” хэмээх газрын мэдээллийн санд тухайн суманд байгуулсан нөөц ашиглалтын гэрээ, байгуулагдсан малчдын бүлэг, нөхөрлөлүүдийн талаарх мэдээлэл байдаггүй учраас гэрээний хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх боломжгүй байна. Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт холбогдох бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан мэдээллийг “Land management” мэдээллийн санд оруулахыг санал болгосон албан тоотыг хүргүүлэв. Албан тоотыг Хавсралт 5.2.6а-д тусгав.

Зөвлөмж

Иймд төлөвлөлт, шийдвэр гаргалт, үнэлгээ, тайланг нэгдсэн цахим системд байршуулах, сумдын ЗДТГ болон ИТХ-н үйл ажиллагаа, захирамж, шийдвэр, тогтоол, тэдгээрийн хэрэгжилтийг мэдээлж байдаг цахим системийг одоо байгаа (татварын, мал эмнэлгийн, газрын, ус цаг уурын, статистикийн) системүүд дээр суурилж нэгтгэн хөгжүүлбэл сумын хэмжээнд хоорондоо уялдаа холбоогүй, салангид байдлаар ашиглагдаж буй мэдээллийн тогтолцоог нэгтгэсэн байдлаар ашиглах боломж бүрдэх юм. Өөрөөр хэлбэл хүнээс буюу албан тушаалтнаас үл хамаарсан мэдээллийн тогтолцоог бий болгох боломжтой болох юм. Ийм тогтолцооны саналын хувилбарыг Хавсралт 5.2.6б-д үзүүлэв.

Цаашид байгаль орчны мэдээллийн нэгдсэн сан дээр суурилан байгалийн нөөцийн (бэлчээр, хадлан, ус, ойн г.м) төлөв байдал, чанарын үзүүлэлт, эзэмшил, ашиглалтын бүртгэл, гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн үр дүн, нөхөн сэргээх, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг мэдээллийг нэгтгэн төвлөрүүлж, бодлого боловсруулах, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах хэмжээнд хөгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

5.2.7 Малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээрийг халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох зөвлөмж

Завхан, Ховд аймгийн ихэнх суманд 2021-2022 онд малын шүлхий өвчин гарч дотоод, гадаад зах зээлд малын мах борлуулах асуудал хорио цээрийн байдалд аймаг, сумаараа орсноос малчдын орлого буурах, малын тоо өсөж бэлчээрийн даац хэтрэх зэргээр сөрөг нөлөө нь илүү нэмэгдсэн юм.

Нөгөө талаар халдварт өвчний гаралт, тархалт өргөжиж байгаа нь баруун бүсэд мал эмнэлгийн улсын нэгдсэн хяналтын цэг огт байхгүй байгаатай ч бас холбоотой юм. Энэ байдлаас гарах нэг гарц нь малчдын бүлгүүдийг гэрээлсэн бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоож баталгаажуулан малын махыг наад зах нь дотоод зах зээлд нийлүүлэх, малын шилжилт хөдөлгөөнд малчдын оролцоо, хяналтыг сайжруулах явдал юм.

2021 онд Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд малчдын бүлгийн гэрээт бэлчээрийг эрүүл нутгаар тогтоож мах, түүхий эдээ зах зээлд үнэ хүргэн борлуулах туршилтыг АХБ-ны төслийн хүрээнд Бодлого судлалын төвөөс амжилттай хэрэгжүүлсэн юм.

Малчдын бүлгийн гишүүн малчин бүр малын шилжилт хөдөлгөөнд хатуу хяналт тавьж, мал эмнэлгийн зохих арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулснаар зүүн бусд малын шүлхий, богийн мялзан, үхрийн арьс товруутах өвчнүүд байнга гарч байгаа ч туршилтын 3 бүлгийн мал сүрэг 2021 оны 10-р сараас одоо хүртэл эрүүл байдлаа хадгалсаар байна. Энэ нь бүлгийн малчид, сумын МЭТ, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарын малын шилжилт хөдөлгөөнд тавьдаг хяналт сайжирсантай шууд холбоотой. Энэхүү туршилтын үр дүнд түшиглэн ““Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам”-ыг Бодлого судлалын төв МЭЕГ-тай хамтран шинэчлэн боловсруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

Үйлдвэрийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/193 дугаар тушаалаар батлуулж, аль ч сумын малчдын бүлэг, нөхөрлөлүүд гэрээт бэлчээрээ эрүүл нутгаар тогтоолгох эрх зүйн орчныг нээгээд байна /Журмыг үзэх линк: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530810504451/>

Энэхүү журмын дагуу:

- Малчдын бүлэг, нөхөрлөл нь гэрээт бэлчээрээ халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоолгох хүсэлтээ холбогдох мал эмнэлгийн байгууллагад гаргана.
- Хүсэлтийг хүлээн авсан мал эмнэлгийн газар журамд заасан шаардлагыг тухайн малчдын бүлэг, нөхөрлөл биелүүлсэн үед зарим халдварт өвчнөөс эрүүл байгааг шууд тогтоож болно.
- Харин эргэлзээтэй үед тухайн бүлгийн мал сүргээс түүврийн аргаар цус, салст бүрхүүлийн арчдас, баас, шээсний дээж авч тухайн өвчний оношийг бататгах шинжилгээ хийнэ. Тухайлбал: Малын гоц халдварт өвчин шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг болон бусад халдварт өвчнөөс тухайн бүлгийн мал сүрэг, гэрээт бэлчээр нутаг эрүүл, тайван болохыг судлан тогтоож болно.
- Ингэж тогтоосны үндсэн дээр тухайн өвчнөөр эрүүл болохыг баталгаажуулсан гэрчилгээг олгоно.
- Гэрчилгээ авсан малчдын бүлэг халдварт өвчингүй, эрүүл, тайван байдлаа тогтвортой хадгалах стратегийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

Завхан, Ховд аймгийн бүх суманд АДАПТ төслийн хүрээнд шинээр байгуулагдсан малчдын бүлгүүдээс сонгон гэрээт бэлчээрийн хэмжээнд нь малын халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох нь малын мах, түүхий эдийг нь зах зээлд үнэ хүргэж борлуулах, малын тоог бууруулан малчдын орлогыг нэмэгдүүлэх, бэлчээрийн даац, ачааллыг хөнгөвчлөх, малынхаа эрүүл мэндийн төлөө малчдын оролцоог нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийг малын халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох нь Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагын дагуу олон улсад хэрэгжүүлдэг хамгаалалттай аж ахуй /compartment-компартмент/ байгуулж, махны экспортыг нэмэгдүүлэх гол гаргалгааны урьдчилсан нөхцөл юм.

Малчдын бүлгийн эрүүл нутгийн тогтвортой байдлыг хадгалахын тулд тухайн аймгийн МЭГ, сумын МЭТ, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ажил дагаад сайжрах боломж бүрдэнэ. Энэхүү үйл ажиллагаа нь төр -хувийн хэвшил- нутгийн иргэдийн түншлэлийн хүрээнд оролцогч талуудын аль алиных нь ашиг сонирхолд нийцсэн нийтлэг зорилтыг хангах тэргүүн туршлага, шинэлэг санаа болж нэвтрэх бүрэн боломжтой юм.

Энэхүү ажлыг 1 сумын хэмжээнд нэвтрүүлэхэд нийт 9.0 сая. төгрөгийн төсөв шаардлагатай бөгөөд үүнд мэргэжлийн зөвлөхийн ажлын хөлс 1.4 сая, хээрийн ажлын унаа, томилолтын зардал 3.6 сая.төгрөг, орон нутгийн мал эмнэлгийн байгууллагын оролцоог хангах 0.5 сая.төгрөг, малын өвчний тандалт, шинжилгээний зардалд 3.5 сая.төгрөг орж байна.

ХАВСРАЛТ

Хавсралт 1 Төслийн үр дүнгийн товч танилцуулга



МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАМЖ БОЛОН ЭРСДЭЛИЙН
МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

**“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг дэмжих зорилгоор Ховд,
Завхан аймагт байгаа иргэдэд тулгуурласан байгууллагыг малчдын
оролцоотойгоор үнэлэх” зөвлөх үйлчилгээ**

**Нөөц ашиглалтын гэрээ /НАГ/ байгуулсан ажлын
талаарх танилцуулга, 2022 оны 9-р сарын 28**



БОДЛОГО СУДЛАЛЫН ТӨВ

Сити Тауэр 703Б, Ерөнхий сайд Амарын гудамж 8/1,
8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14200
Утас: 77119027
e-mail: cpr@cpr.mn
Web: www.cpr.mn

Агуулга

- Бэлчээр, хадлан, усны нөөц ашиглагчдын бүлэг /НАБ/ байгуулсан талаар
- Бэлчээр, хадлан, усны нөөц ашиглалтын гэрээ /НАГ/-г шинэчлэн боловсруулсан талаар
- Шинэчилсэн загвараар НАГ байгуулсан талаар
- НАГ-г хэрхэн хэрэгжүүлэх талаар орон нутгаас гарсан санал

Бэлчээр, хадлан, усны нөөц ашиглагчдын бүлэг /НАБ/ байгуулсан талаар

- **НАБ** байгуулах нь НАГ байгуулахын урьдах шат юм. Учир нь гэрээг малчдын бүлэгтэй хийдэг.
- 2 аймгийн сум бүрд 2-с доошгүй **НАБ** байгуулж, НАГ хийх хээрийн ажлыг 2022 оны 9-р сард хийж гүйцэтгэлээ. Ашигласан арга зүй
- **Малчдын бүлэг байгуулахаар санаачлагчдын хурлаар хэлэлцүүлж бүлгийг албан ёсоор байгуулах**
 - Гишүүн өрхийн төлөөллийг нэг газар цуглуулж, малчдын бүлэг байгуулах зорилго, шаардлага, ач холбогдол, АДАПТ төслөөс хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тэдгээрт хамрагдах боломж зэргийг тайлбарлав.
 - Санаачлагчдын хурлын ирцийг бүртгэх, асуудал хэлэлцэх дэг, асуулт хариулт, санал, хурлаас шийдвэр хэрхэн гаргах ажиллагааг санаачлагчдаас томилсон ахлагчтай хамтран зохион байгуулж, дадлагажууллаа.
- **Хэлэлцсэн асуудлаар шийдвэр гаргах.** Хуралд оролцогчдын олонхын саналаар бүлэгтэй нэр өгөх, ахлагчаа томилох, бүлэгт мөрдөгдөх үндсэн баримт бичиг (бүлгийн дүрэм, бэлчээр, ус ашиглах журам, дундын сангийн журам)-ийг батлуулж, энэ тухай хурлын тэмдэглэл хөтлүүлэв. Хурлаас баталсан бичиг баримтыг бүлэг бүрд албан ёсоор хүлээлгэн өглөө.
- **Нөөцийг гэрээгээр ашиглахаар хүсэлт гаргах.** Өвөл-хаврын бэлчээр гэрээгээр ашиглахаар харьяа багийн Иргэдийн нийтийн хурал (БИНХ)-д хүсэлт гаргахыг хуралд оролцсон гишүүд дэмжиж, ахлагчаараа төлөөлүүлэн хүргүүлэхээр тогтлоо.
- **Гэрээгээр ашиглах бэлчээрийн хил заагийг тогтоох.** Бүлгийн гишүүдийн хатуу цэгийн байршил, бэлчээрийн эргэлтийн гол цэгийн солилцлыг (GPS)-ээр хэмжиж бүртгэлээ. Гэрээт бэлчээрийн хил заагийг нарийвчилсан кадастрын зургийг хавсаргахаар тохиров.

НАБ байгуулах ажлын үр дүн

Ховд аймгийн 16 суманд 38, Завхан аймгийн 23 суманд 74, нийт 112 НАБ байгуулагдлаа.

Бэлчээр, хадлан, усны нөөц ашиглалтын гэрээ /НАГ/-г шинэчлэн боловсруулсан талаар

Нөөц ашиглалтын гэрээг дараах 3 төрлөөр шинэчлэн боловсруулав.

- Бэлчээр ашиглуулах гэрээ, Худаг эзэмшүүлэх гэрээ, Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээ
- Гэрээнд нөөцийг өмчлөгч төрийн төлөөлөл сумын Засаг дарга, нөөцийг ашиглагч малчдын бүлэг, нөхөрлөлийн гишүүн өрхүүдийн тухайн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах талаарх эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоо, байгалийн эрсдэл тохиолдсон үед зохицуулах механизмыг тусгалаа.
- Гэрээний төслийг боловсруулахдаа холбогдох хууль тогтоомж, журамд нийцүүлж, тухайн нөөцийг ашиглахад тулгарч байгаа гол бэрхшээлүүдийг шийдэхэд чиглүүлэн боловсруулсны гадна орон нутгийн холбогдох албан тушаалтан, малчдын төлөөллөөс санал авч, боломжтой саналуудыг тусгасан болно.
- Орон нутгийн саналыг хоёр аймгийн нийт сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, хурлын ажилтан, сумын Засаг дарга, газрын даамал, ХААТ-ийн мэргэжилтнүүд, багийн Засаг дарга нар зэрэг сум тус бүрд газар дээр нь танилцуулах замаар 222 хүн, АДАПТ төслийн шугамаар Завхан аймагт зохион байгуулсан семинарт оролцсон аймаг, сумын удирдлага, холбогдох мэргэжилтэн, малчдын төлөөлөл 200 хүн, НАГ-д гэрээнд гарын үсэг зурсан 889 малчин өрх, нийт 1311 төлөөллөөс саналыг авч тусгалаа.

Бэлчээр ашиглуулах гэрээ

Онцлог зохицуулалтууд

- НАБ, түүнчлэн бэлчээр ашиглуулах гэрээний хүрээнд газар ашиглагчийн эрх үүрэг, цаашид бүлгээ байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл болгон өөрчлөн байгуулж үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж, нөхцөлтэй холбоотой Газрын тухай болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хамаарах заалтыг нэмж тусгах,
- Малчдын бүлгийн үйл ажиллагааны цогц төлөвлөгөөнд тусгах нөөцийн ашиглалт, эзэмшилт ба бусад арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд Ашиглагчийн зүгээс ашиглаж болох санхүүжилтийн шинэ эх үүсвэр – Малын тоо толгойн албан татварын тухай, Төсвийн тухай хуулийн заалтыг тусгах,
- Бэлчээрийн ургац тогтоох, даац тооцох, малын тоог гэрээт бэлчээрийн даацад нийцүүлэх тооцоо үйлдэх зэрэг арга хэмжээг “Малын бэлчээрийн ургац тодорхойлох нийтлэг журам”-ын дагуу авч хэрэгжүүлэх,
- Төрийн албаны зөвлөлийн –д тусгагдсан “Газрын даамлын ажлын байрны тодорхойлолтын 3-д заасны дагуу бэлчээр ашиглуулах гэрээнд Өмчлөгчийг газрын даамал төлөөлөх, ингэснээр гэрээт бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, төлөв байдалд албан тушаалын ба мэргэжлийн хүрээнд хяналт тавих, үнэлгээ хийх ажлыг шууд хариуцах,
- Бэлчээр ашиглуулах гэрээг урт хугацаагаар буюу 15 жилийн хугацаатай байгуулах,
- Гэрээт бэлчээрийн хил заагийн дотор ургац тогтоох болон төлөв байдлыг үнэлгээний цэг байгуулах, энэ арга хэмжээг Засаг даргын захирамжид тусгай заалт болгож тусгах.
- Ган зуд зэрэг байгалийн эрсдэл тохиолдсон үед гэрээлсэн бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй бусдын малыг оруулах
- Бэлчээрийн даацын тооцоонд өвсөн тэжээлт зэрлэг хөхтөн амьтдыг оруулж тооцох

Худаг эзэмшүүлэх гэрээ

Үндэслэл

- Хүнс, хөдөө, аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 101/189/194 тоот тушаалаар баталсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-г суурь болгов.

Гэрээний зорилго

- Гэрээний зорилго нь худгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын харилцааг зохицуулахад оршино.
- Худаг уст цэгийг тодорхой эзэнтэй болгож, уст цэгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, эзэмшилтийг сайжруулан, байнгын ажиллагаатай байлгах, усны нөөц, худгийн орчны газрыг зохистой ашиглаж, хамгаалах, хүн ам, мал сүргийг усаар тогтмол хангахад оршино.

Өмчлөл

- Монгол улсын усны тухай хуулийн дагуу усны баялаг нь төрийн өмчид байна. Энэхүү гэрээгээр зохицуулж байгаа эзэмшил, ашиглалтын харилцаа нь усны баялгийн өмчлөл, эзэмшлийг хөндөхгүйгээр гагцхүү усны нөөцийн зохистой ашиглалт, худгийн тоног төхөөрөмж, байшин барилгын эзэмшил, ашиглалтын харилцааг зохицуулна.
- Худгийг сэргээн засварлахад суурилсан нийт тоног төхөөрөмж, байшин барилга нь төрийн өмч байна.
- Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч сумын засаг дарга төрийн өмчийн хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдсон харилцааг энэхүү гэрээ болон холбогдох хууль, журмын дагуу зохицуулах бүрэн эрхийг эдэлнэ.
- Худгийг сэргээн засварлахад эзэмшигчийн зүгээс оруулсан тоног төхөөрөмж, байшин барилга нь эзэмшигчийн өмч байна.

Эзэмшлийн зориулалт

- Худгийг мал услах /ундны усны, тариа ногоо услах гэх мэт/ хэрэгцээг хангах зориулалтаар эзэмшүүлэх
- Худгийн усыг байнгын ашиглагч нь эзэмшигчийн гишүүн өрхүүд байна.

Худгийн усны төлбөр болон үйлчилгээний хөлс

- Худгийн үйлчилгээний хөлс нь худгаас ус гаргах тоног төхөөрөмжийг ажиллуулах болон засварлах урсгал зардал, худгийн тоног төхөөрөмж болон худгийн барилгад их засвар хийх, сайжруулах зардал /элэгдлийн сан/, худаг хариуцагчийн цалин, худгийн усыг бохирдол, хөлдөлтөөс хамгаалах зардал, худгийн орчны газрыг талхагдал, бохирдлоос сэргийлэх арга хэмжээний зардлаас бүрдэнэ.

Худгийн үйлчилгээний хөлсийг ус хэрэглэгчид хариуцна.

Эзэмшигчийн эрх үүрэг

- Гишүүн бус эрх ус хэрэглэсэн тохиолдолд үйлчилгээний хөлс авах
- Худгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах
- Худагт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр нэхэмжлэх
- Худгийн ашиглалт, засвар үйлчилгээг үйлчилгээний хөлсөөр хийх
- Худгийн орчмын газар, байгаль орчны хууль тогтоомжийн дагуу хамгаалах, бохирдол, талхагдалаас сэргийлэх арга хэмжээ авах
- Эзэмшигчийн хариуцаагагүйгээс худагт аливаа хохирол учирсан, орчмын газар талхагдалд тохиолдолд өөрийн зардлаар нөхөн сэргээх арга хэмжээ авах
- Худгийн их засвар шинэчлэлтийг хийх элэгдлийн сан байгуулах;
- Худгаас малаа услах, унд ахуйн ус хэрэглэх хуваарь гаргаж мөрдүүлэх
- Худгийг ажиллуулах хариуцагчийг томилох, түүнд үйлчилгээний хөлсийг хураах, худаг ажиллуулахтай холбоотой зардлыг дундын сангаас авах эрх олгох
- Худгийн үйлчилгээний хөлсийг гишүүн өрхүүдийн малын болон ундны усны хэрэглээтэй харгалзуулан ногдуулж, хураах

Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээ

Үндэслэл

- Газрын хуулийн 53.5-д заасан “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэн, хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурвас тарих зэргээр өөрийн хүч, хөрөнгөөр сайжруулалт хийж, ургацыг нь тогтвортой дээшлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад сумын Засаг дарга уг талбайг нь эзэмшүүлж болно” гэнийг үндэслэн хадлангийн талбайг эзэмшүүлэх замаар түүнийг зохистой ашиглаж хамгаалах сонирхлыг төрүүлэх зорилгыг иш үндэс болгов.
- Түүнчлэн “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Байгалийн ургамлын тухай хууль”, “Байгалийн ургамал ашигласны төлбөрийн ухай хууль”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль”, “Газрын төлбөрийн тухай хууль”, бусад холбогдох хууль, журмыг үндэслэв.

Онцлог зохицуулалтууд

Хадлангийн газрын эзэмшлийн гэрээнд гэрээ байгуулахдаа

- газрыг хүлээлцэхдээ акт үйлдэн хүлээлгэн өгөх
- хэрэгжилтэд жил бүр хяналт тавих
- хадлангийн газраа тухайн жил бүрэн ашиглах боломжгүй бол бусдад гэрээгээр ашиглуулах
- байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг хадлангийн газраа сайжруулахад зарцуулах
- Бэлтгэсэн хадлангаа эхний ээлжид нөхөрлөлийн гишүүн малчид, сумын малчдад орон нутгийн ханшаар, үлдэх хэсгийг зах зээлд борлуулах
- Сумын өвсний фондод хадлангийн газрын га тутамд 1 боодол өвсөөр тооцож, сумын ЗДТГ-аас тогтоосон газарт хүргэж өгөх
- гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх зэрэг заалтууд нэмэлтээр орсон болно.

Ойн санг эзэмшүүлэх гэрээ:

Ойн санг эзэмшүүлэх гэрээний загварыг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 227 дугаар тогтоолын хавсралт “Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журам”-ыг үндэслэн шинэчлэн боловсруулав. Ойн санг эзэмших гэрээнд доорх заалтуудыг нэмж оруулав. Үүнд: Эзэмшлийн ойн санд түймэр, хөнөөлт шавж, өвчин зэрэг гамшгийн хор уршгийг арилгахад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, санхүүгийн туслалцаа үзүүлэх, эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх, Ойн нөхөрлөлийн дундын сан байгуулах. гэх мэт

Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журамд заасан Багийн дарга, тухайн багийг хариуцсан байгаль хамгаалагч нь нөхөрлөлөөс ирүүлсэн материалыг үндэслэн нөхөрлөлийн эзэмших ойн сангийн ойн талбайн хэмжээг сум дундын ойн ангитай хамтран /ойн зураг дээрх хэсэглэл, ялгарал/-р гарган тэмдэг даран баталгаажуулах, сумын засаг даргын түвшинд хийх ажлууд ихээхэн цаг хугацаа, мэргэжлийн байгууллагын оролцоо, санхүүжилт хэрэгтэй тул шинэ ойн нөхөрлөл байгуулах ажлыг төслийн богино хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй байв

Нөөц ашиглалтын гэрээг хэрэгжүүлэх талаар орон нутгаас гарсан санал

- Гэрээний төслийг хэлэлцүүлэх болон гэрээг байгуулах явцад орон нутгаас гарсан гол санал нь гэрээ байгуулаад орхивол ямар ч ач холбогдолгүй “цаас үйлдвэрлэсэн” ажил болно.
- Хамгийн гол нь гэрээг хэрэгжүүлэх талаар төслөөс бодитой дэмжлэг үзүүлж чадвал ажил болж чадна гэсэн ойлголт хүлээлтэй байна.


Төслөөс хүсэж байгаа дэмжлэгийн талаар орон нутгийн захиргаа, малчдаас гарсан саналыг тоймлон үзвэл дараах чиглэлтэй байна. Үүнд:

- Мал борлуулалтын урамшууллыг олгох замаар малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх
- Хэд хэдэн сумын дунд мал борлуулах нэг цэгийн үйл ажиллагаа
- Гүний худаг засварлах, шинээр гаргах
- Малын чанар, эрүүл мэнд, хадлангийн талбайг сайжруулах
- Хурга махлуулж борлуулах

Дээрх саналыг хэрэгжүүлэхэд 1 суманд дараах төсөв шаардагдахаар байна. Үүнд:

- Мал борлуулалтын урамшууллыг олгоход 3-5 сая төгрөг, нийттөгрөг
- Мал борлуулах нэг цэгийн үйл ажиллагааг дэмжихэд 90 сая төгрөг
- Гүний худаг засварлах, шинээр гаргах- 1 худаг 20 сая, 2 худаг 40 сая
- Малын чанар, эрүүл мэнд, хадлангийн талбайг сайжруулахад 10 сая төгрөг
- Хурга махлуулж борлуулахад 10 сая төгрөг

НАГ-г амьдралд хэрэгжүүлж, бодит ажил болгох талаар төслөөс хүлээж байгаа хөрөнгө оруулалтын байршил





Нөөц ашиглагчдын бүлгийн тухай

Малчид, сумын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдад зориулсан танилцуулга

Бодого судлалын төв
2022 оны 7-8, 9 дүгээр сар

Нөөц ашиглагчдын бүлэг

- “АДАПТ” төслийн хүрээнд НАБ гэдгийг малчдын бүлэг ба байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл гэсэн хоёр хэлбэртэй байхаар тогтоосон
- НАБ-тэй холбоотой эрх зүйн асуудлууд
 - Иргэний хуулийн **481 дүгээр зүйл Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл**
 - 481.1. Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд **холбоо болон нөхөрлөлийн** хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно.
 - Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтад “өвөлжөө, хаваржааны бэлчээрийг **малчдын бүлэг**, хэсэгт болзол, гэрээгээр ашиглуулж болно” гэсэн бүлгийн тухай нэршил тусгагдсан байдаг.
 - Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэдийн бүлгийг малчдын бүлэг гэнэ гэж Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.3-т тодорхойлжээ
 - “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл (**БНХМН**) гэж нутгийн иргэдэд байгалийн нөөцийн хамгаалах, нөхөн сэргээх эрх олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг хэлнэ” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасан
- “АДАПТ” төслийн баримт бичигт заасны дагуу НАБ-ийг бэлчээр, хадлан, ус, ойн нөөц ашиглах чиглэлээр бие даасан байдлаар тус тусад нь байгуулна.

НАБ хэрхэн байгуулагдах вэ

НАБ нь **сайн дурын үндсэн дээр, иргэдийн санаачлагаар байгуулагдана**. Иймд иргэд анхлан санаачлах зарчмаар эхлэл нь тавигдана

Санаачлагчдаас зохион байгуулж санаачлагчдын хурал хийх:

- Хурлын зар /хурлаа хаана хэзээ хийх/-ыг санаачлагчдад хүргэх
- Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг зарын хамт хүргүүлэх

Санаачлагчдын хурлын дэг:

- Хурлын ирцийг ирвэл зохих санаачлагчдын тоонд харьцуулж гаргах, ирц 75 хувиас дээш бол хурал хүчин төгөлдөр гэж үзэх
- Хурлыг санаачлагчдаас нэг хүн даргалах
- Зараар хүргүүлсэн асуудлыг хэлэлцэх дэс, хурлын дотоод журам, дэгийг хэлэлцүүлж батлуулах
- Хэлэлцэх асуудлыг нэг бүрчлэн танилцуулах, асуулт хариулт явуулах
- Хэлэлцсэн асуудлаар хуралд оролцож буй санаачлагчдын ердийн олонх /66.6 хувиас дээш/-ийн саналаар батлах

Санаачлагчдын хурлаас шийдвэр гаргах

- Хэлэлцсэн асуудал тус бүрээр хурлаас гарсан шийдвэрийг тус тусад нь танилцуулах
- Хурлаас тэмдэглэл гарана. Тэмдэглэл хөтлөх санаачлагчийг хурлаас нэр зааж ажилуулна. Хурлаас гаргасан шийдвэрийг тэмдэглэлд нэг бүрчлэн тусгана.
- Тэмдэглэл хөтөлсөн болон хурал даргалагч гарын үсэг зурж тэмдэглэлийг баталгаажуулна

- Үргэлжлэл -

- НАБ байгуулах болон холбогдох бусад асуудлаар дараах шийдвэрийг санаачлагчдын хурлаас гаргана. Үүнд:
 - НАБ-ийн гишүүн өрхийг тогтоох
 - НАБ-ийн оноосон нэр
 - НАБ-ийн ахлагчийг сонгох
 - НАБ-ийн үйл ажиллагаа, харилцааг зохицуулах бусад баримт бичгийг хэлэлцэж батлах
 - НАБ-ийн дүрэм
 - Нөөц хамтран ашиглах журам
 - Дундын сангийн журам
 - НАБ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө
 - Нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө
- НАБ нь өрхийн гишүүнчлэлтэй, гишүүн нь өрхийн гишүүд байна.
- Малчдын бүлгийг хугацаагүй байгуулах ба БНХМН-ийг ...

НАБ-ийн дүрэм

Сайн дурын үндсэн дээр байгуулагддаг хэдий ч НАБ өөрийн үйл ажиллагаа, харилцааг зохицуулах дүрэмтэй байна. Дүрмийг санаачлагчдын хурлаас батлах ба дараах агуулгатай байна. Үүнд:

- НАБ-ийн үүсгэн байгуулалт, ерөнхий мэдээлэл – нэр, харьяа сум, баг, байршил
- Нийтлэг асуудлууд буюу холбогдох хууль тогтоомж, зохицуулалт, зохион байгуулалт
- НАБ-ийн зорилго, үндсэн үйл ажиллагаа
- НАБ-ийн удирдлага ба шийдвэр гаргалт
- НАБ-ийн бүх гишүүдийн хурал, шийдвэр гаргах зарчим
- НАБ-ийн үндсэн эрх үүрэг, хариуцлага
- НАБ-ийн ахлагчийн эрх үүрэг
- НАБ-ийн гишүүнчлэл
- НАБ-ийн гишүүний арх, үүрэг
- Бүлгээс гарах, элсэх

НАБ-ийн бэлчээр, ус ашиглалтын журам

Энэхүү журмыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж батална. Журмын агуулга:

Зорилт: НАБ-ээс гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн тогтвортой ашиглалт/хамгаалалтыг зохицуулах.

Журмыг хэрэгжүүлэхэд Засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглуулах гэрээ, энэхүү журам, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бНАБ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баримтлах

Бэлчээрийн даац, холбогдох тооцоо үйлдэх аргачлалыг энэ журамд товч зааж өгнө. Малын тоог хонин толгойгоор, ургацыг сумын ЭДТГ-ын мэдээллээр, малын тооны өөрчлөлтийг оны эцсийн мал тооллогын дүнгээр тавиул малыг оруулах

Бэлчээрийн даацыг зохицуулах. Малын тоо бэлчээрийн даацаас 10 хувиас илүү хэтэрсэн мал цөөлөх арга хэмжээ авах.

- Даацаас хэтэрсэн малын нийт тоог бууруулахдаа гишүүн өрхүүдэд ар тооцох
- Цөөн малтай, орлогын өөр эх үүсвэр байхгүй ядуу өрхийн малын тоо цөөлөх үүргээс хөнгөлөх, чөлөөлөх,
- Бэлчээрийн даацыг зохицуулах асуудлыг НАБ-ийн бүх гишүүдийн хурлаар нээлттэй хэлэлцүүлж, шийдвэрлэнэ.

Худаг шинээр гаргах, сэргээн засварлаж ашигласан тохиолдолд “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ын дагуу гэрээ хийж хүлээн авах,

Булаг, задгай ус, хужир мараа бүхий нийтээр ашиглах нөөцийг НАБ дангаар ашиглахгүй

НАБ-ийн дундын сангийн журам

- Энэхүү журмыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж батална. Журамд дараах асуудлыг тусгана. Үүнд:
- Дундын санг бүрдүүлэх хөрөнгийн эх үүсвэр – гишүүдийн ба бусдын хувь хандив тусламж, өөрийн үйл ажиллагааны орлого
- Гишүүний оролцооны хувь – тодорхой тоо хэмжээ заана
- Дундын сангийн хөрөнгийн бүртгэл
- Дундын сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаа, арга хэмжээнд захиран зарцуулах. Үүнд:
 - Бэлчээрийг гэрээгээр зохистой хамтран ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх
 - Гишүүдийн мэдлэг, чадавхийг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах
 - Гэрээгээр ашиглаж буй бэлчээрт байгаа хурдгийг ашиглах, хамгаалах, засварлах
 - Малын үүлдэрлэг чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах
 - Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг хамтран борлуулах
 - Хадлан тэжээл бэлтгэх, хашаа, хороо, саравч засварлах ажилбайгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нөөц баялгийг зохистой ашиглах
 - Тулгамдсан асуудлуудыг хамтран шийдвэрлэх, хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэртэй болох
 - Тэмдэглэлт үйл явдалд хөрөнгө гаргах
 - Гишүүддээ сайн дурын үндсэн дээр тусламж, дэмжлэг үзүүлэх

Хавсралт 26 Нөөц ашиглалтын гэрээ байгуулах



Малчид, сумын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдад зориулсан танилцуулга

**Бодлого судлалын төв
2022 оны 7-8 дугаар сар**

Хоёр. НАГ, НАГ байгуулах

НАГ бол НАБ-ээс байгалийн нөөцийг гэрээний үндсэн дээр болзолтой ашиглах чиглэлээр өмчлөгч ба ашиглагчийн хооронд байгуулсан хүчин төгөлдөр гэрээ юм.

Өмнө өгүүлсэнчлэн, бэлчээр, хадлан, ус, ой гэсэн үндсэн дөрвөн нөөц тус бүрд харгалзуулан боловсруулсан НАГ-г байгуулна. Үүнд:

- Бэлчээр ашиглуулах гэрээ
- Худаг эзэмшүүлэх гэрээ
- Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээ
- Ойн хамтын менежментийн гэрээ

НАГ-ийг байгуулахдаа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэнэ.

Бэлчээр ашиглуулах шинэчилсэн гэрээ

Шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл

- Бэлчээрийн даац хэтрэлтээс урьдчилан сэргийлэх үр нөлөө бүхий арга хэмжээг малчдын хамтын байгууллагын түвшинд хэрэгжүүлэхгүй явж ирсэн
- Бэлчээр ашиглах эрхээ баталгаажуулахыг хүссэн малчидтай хамтран өвөлжөө, хаваржааны бэлчээрийг гэрээгээр ашиглуулах боломжийг дэмжиж чадаагүй
- Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах гэрээний заалтыг бүр талууд дүгнэх ажил сумдад жигдрээгүй, энэ арга хэмжээнд ЗДТГ-ын албан тушаалтны оролцоо сул
- Бэлчээрийн даацын хэтрэлт, доройтлыг сааруулах, малын тоонд нийцүүлэх үр нөлөө бүхий механизм, малчдын сонирхлыг татсан эдийн засгийн арга хэмжээ авдаггүй,
- Гэрээний хэрэгжилтийн байдал, түүнтэй дагалдан гарч болох асуудлыг үндэслэн цаашид сунгах, эсхүл цуцлах, дуусгавар болгох талаар ямар нэг арга хэмжээ авдаггүй
- Гэрээний хэрэгжилттэй холбоотой зөрчил, хохирлыг арилгах, шийдвэрлэх талаар тодорхой тусгагдаагүй
- Талуудаас гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, цаашид авах арга хэмжээний талаар Ашиглагчдад мэдээлдэггүй

Гэрээнд оруулахаар санал болгож буй нэмэлт, өөрчлөлт

Одоо мөрдөж буй бэлчээр ашиглалтын гэрээнд дараах шинэ бүлэг, заалт, нэмэлт оруулж тусгахаар санал боловсрууллаа.

1. НАБ, түүнчлэн бэлчээр ашиглуулах гэрээний хүрээнд газар ашиглагчийн эрх үүрэг, цаашид байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл болгон өөрчлөн байгуулж үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломж, нөхцөл, тавигдаж болох шаардлагыг харгалзан Газрын тухай болон Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хамаарах заалтыг нэмж тусгах,
2. Гэрээг Өмчлөгчид хамааруулан бэлчээр ашиглуулах гэж өөрчлөн нэрлэх,
3. Гэрээ байгуулах, дүгнэх, сунгах, цуцлах асуудлыг 2.4 гэсэн тусдаа заалт болгож орууллаа. Ингэснээр гэрээг жил бүр дүгнэж, талуудын үүргийн биелэлтийг харгалзан сунгах, цуцлах асуудлыг тухай бүр шийдвэрлэхгүй байгаа,
4. Өмчлөгч буюу сумын Засаг даргыг төлөөлж газрын даамал гэрээнд гарын үсэг зурах. Газрын тухай хуулийн 23.4.2, 23.4.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 47 дугаар тогтоолд үндэслэсэн болно.
5. Гэрээний хэрэгжилт, үүргийн биелэлттэй холбоотой зөрчил, хохирлын талаар албан ёсны дүгнэлт гаргуулах, хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх, арилгуулах асуудлыг БОХУБ-д хариуцуулах

-Үргэлжлэл-

6. Гэрээт бэлчээрийн төлөв байдлыг үнэлэх, ургац тогтоох цэгийг НАБ-ийн гэрээт бэлчээрт шинээр тогтоох
7. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх
8. Малчдын бүлгийн үйл ажиллагааны цогц төлөвлөгөөнд тусгах нөөцийн ашиглалт, эзэмшилт ба бусад арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд Ашиглагчийн зүгээс ашиглаж болох санхүүжилтийн шинэ эх үүсвэр – Малын тоо толгойн албан татварын тухай, Төсвийн тухай хуулийн заалтыг тусгах,
9. Бэлчээрийн ургац тогтоох, даац тооцох, малын тоог гэрээт бэлчээрийн даацад нийцүүлэх тооцоо үйлдэх, гэрээний хэрэгжилтийг дүгнэх зэрэг арга хэмжээг “Малын бэлчээрийн ургац тодорхойлох нийтлэг журам”-ын дагуу авч хэрэгжүүлэх,
10. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 47 дугаар тогтоолын 14 дүгээр хавсралтад тусгагдсан “Газрын даамлын албан тушаалын тодорхойлолтын 3-д заасны дагуу бэлчээр ашиглуулах гэрээнд Өмчлөгчийг газрын даамал төлөөлөх, ингэснээр гэрээт бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, төлөв байдалд албан тушаалын ба мэргэжлийн хүрээнд хяналт тавих, үнэлгээ хийх ажлыг шууд хариуцах,
11. Бэлчээр ашиглуулах гэрээг урт хугацаагаар буюу 15 жилийн хугацаатай байгуулах,

-Үргэлжлэл-

12. Гэрээт бэлчээрийн хил заагийн дотор ургац тогтоох болон төлөв байдлыг үнэлгээний цэг байгуулах, энэ арга хэмжээг Засаг даргын захирамжид тусгай заалт болгож тусгах.

13. Ган, зуд зэрэг байгалийн бэрхшээл, эрсдэл тохиолдсон үед гэрээлсэн бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүйгээр малчдын бусад бүлэг, малчдын малыг оруулах, мөн бусдын бэлчээрт орох харилцан үүргийг тусгах,

14. Бэлчээрийн даацын тооцоонд өвсөн тэжээлт зэрлэг хөхтөн амьтдыг оруулж тооцох,

15. Бэлчээрийн даацад нийцүүлэх, ачааллыг багасгах зорилгоор мал борлуулахад урамшуулал олгох арга хэмжээг сумын захиргаанаас хэрэгжүүлэх

16. Гэрээнд өрхийн тэргүүнээс гадна гэр бүлийн гишүүд (эхнэр) гарын үсэг зурах, байгалийн нөөцийн менежмент, ашиглалтад жендерийн тэгш байдлыг хангах

Бэлчээр ашиглуулах гэрээний ач холбогдол

Бэлчээр гэрээгээр ашиглуулах нь дараах ач холбогдол, давуу талтай. Үүнд:

- 1. Бэлчээр “өөриймсөг хандах эзэнтэй” болж, зөвхөн ашиглагчийн байр сууринаас бус, “ашиглагч нь хамгаалагч байх” зохистой харилцаа бүрдэж, өгөөжтэй арга технологиор бэлчээрээ сайжруулах хөшүүрэг бий болно.
- 2. Сүргийнхээ зохистой хэмжээ, бүтцийг хадгалах эрмэлзэл малчдад төлөвшиж, малыг эдийн засгийн эргэлтэд оруулж борлуулж ах, ашиг шим, чанарыг эрхэмлэх сэтгэлгээ төлөвшинө.
- Малын тоог бэлчээрийн даацтай нийцүүлэх үүднээс сүргээсээ тооцоотой зарлагадах, улмаар хуримтлалтай болж мал аж ахуйд хөрөнгө оруулдаг үйлдвэрлэгч болж чадна.
- 3. Мал аж ахуйг чанар, бүтээмжид суурилсан тогтвортой хөгжлийн гольдролд оруулж чадна.
- МАА-н бүтээгдэхүүний өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг бодит үйлдвэрлэл, нийлүүлэлтээр хангаж, үнийн хөөрөгдөл, хөөсөн өсөлтөөс сэргийлнэ.
- 4. Бэлчээрийн эдэлбэрээс бусад эдэлбэрт шилжихэд малчид, нутгийн захиргаа, мал аж ахуйн салбарын эрх ашгийг зохистой харгалздаг нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5. Унаган төрхийг нь хадгалсан, байгальд ээлтэй аргаар нөхөн сэргээсэн бэлчээрийн малаас гаралтай экологийн цэвэр бүтээгдэхүүнээр зах зээлд өрсөлдөж, эдийн засгийг солонгоруулах гарц нээгдэнэ.

НАБ байгуулагдсаны дараах шийдвэрлэх асуудлууд, арга хэмжээ

НАБ байгуулах гол зорилго бэлчээр ашиглах эрхээ хуулийн зохих заалтын дагуу баталгаажуулахад оршдог хэдий ч хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай арга хэмжээ НАБ-ээрээ хамтран авах ёстой. Үүнд:

- Гэрээгээр ашиглах нөөцийн хил заагийг гар зургаар тоймлох, гишүүн өрхийн үл хөдлөх цэгийн байршлыг тэмдэглэх,
- Гэрээгээр ашиглахаар санал болгох бэлчээрийн хил заагаа тоймлосны дараа цаг агаарын ба бэлчээрийн ургац хэвийн нөхцөлд хөрш малчин өрх/НАБ-ийн мал идэшлэдэг бэлчээр давхцах, хэт шахах зэрэг зөрчил үүсгэх байдал байгаа эсэхийг нягтлах,
- Гэрээгээр ашиглахаар санал болгох бэлчээрийн хил заагийг хөршүүддээ танилцуулж ямар нэг зөрчилтэй, маргаантай асуудал байхгүй гэсэн баталгааг гарын үсгээр авах,
- Гэрээгээр ашиглахаар тоймлосон бэлчээрийн хил заагийг тогтоож, хөрш малчидтай зөвшилцсөний дараа бэлчээр гэрээгээр ашиглах хүсэлтээ хэлэлцүүлэхээс багийн ИНХ-д гаргах
- Багийн ИНХ-д хүсэлтийг хэлэлцэхэд НАБ-ийн гишүүд бүрэн оролцох

НАГ-ний талаарх энэхүү танилцуулга, бусад мэдээллийг авснаар дараах асуултад хууль эрх зүйн ба зохион байгуулалтын хүрээ, зохицуулалтын талаас нь зохих тайлбар, хариулт, зөвлөгөө өгөх мэдлэг ойлголттой болно

- НАБ /малчдын бүлэг, байгалийн нөөцийн менежментийн нөхөрлөл/-ийн тухай
- НАБ-ийг хэрхэн санаачилж байгуулах вэ?
- НАБ-ийн гишүүн гэж хэнийг хэлэх вэ?
- НАБ-с ямар нөөцийг гэрээгээр ашиглах, эсхүл эзэмших /нөөцийг ашиглах, эзэмших үндэслэлийг ялгаж тайлбарлах/ вэ?
- Багийн ИНХ-д ямар материал бүрдүүлж, хүсэлт гаргах вэ?
- Сумын Засаг даратай НАГ байгуулахад ямар баримт бичгийг НАБ бүрдүүлэх ёстой вэ?
- НАБ-ийн хүрээнд нэгдмэл зорилготой хамт олны зарчмаар ажиллахад ямар баримт бичгийг баталж мөрдөх вэ?
- НАГ байгуулахад ЗДТГ-аас ямар баримт бичиг бэлдэх вэ?
- НАГ байгуулах шийдвэрийг хэн гаргах, НАГ-ийг байгуулахад хэн хэн төлөөлж гарын үсгээр баталгаажуулах вэ?
- НАГ-д НАБ-ийн ямар гишүүд гарын үсгээ зурах вэ, яагаад?

Хавсралт 2.1 Нөөц ашиглалтын бүлгийн гэрээний талаарх саналын хуудас ²

БАЙГУУЛЛАГА/ СУМЫН НЭР

Бодлого судлалын төвөөс тараасан 3 төрлийн нөөцийн гэрээтэй танилцаж саналаа нэгтгэж бичнэ үү.

1. БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2. ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

3. ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

НЭМЭЛТ САНАЛАА cpr@cpr.mn ХАЯГААР ИЛГЭЭНЭ ҮҮ.

Саналтай холбогдуулан эргэн холбоо барих хүний нэр, утасны дугаар:

.....

² Байгууллага/сум саналаа нэгтгэж бичнэ

Хавсралт 2.2 Нөөц ашиглалтын гэрээний төсөл дээр орон нутгаас гарсан санал, түүнийг гэрээний төсөлд тусгасан нь

Санал гаргасан	Саналын агуулга	Саналыг тусгасан нь
Шилүүстэй: Г. Эрдэнэчулуун 93018809	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	Бэлчээр ашиглуулах гэрээг төр иргэний хооронд байх ёстой хууль зүйн акт байх нь зүйтэй. Ямар нэг асуудал гарахад лицензийн зөвшөөрөл зэрэг асуудал гарахад зохицуулах асуудалд хэрэгтэй юм.	Саналыг гэрээнд бүрэн тусгаж, малчдыг уул уурхай зэрэг бусад ашиглалтад бэлчээрээ алдах эрсдэлээс хамгаалсан
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Ус нийтийн өмч учраас нийт иргэдэд бүлэг хүмүүст ч мөн нийтээр ашиглах гэрээ хийх нь зүйтэй	Саналыг харгалзан үзэж, байгалийн ил задгай ус дээр гэрээ хийгээгүй
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
Бүлэг, нөхөрлөлөөр дамжуулан эзэмшүүлэх буюу нэгдэж хамтарч ажиллах гэрээ байгуулах нь зөв	Саналыг бүрэн тусгаж, гэрээг бүлэгтэй хийсэн	
Цагаанхайрхан Идэр:	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	<ul style="list-style-type: none"> - Отрын бүс нутаг тогтоох - Отор нүүдэл дамжин өнгөрөх хугацааг тогтоох - Өвөлжөө хаваржаанаасаа гарч буух хугацааг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулж тогтоох - Бэлчээр өнжөөх, сэргээх 	Гэрээнд ган, зуд болоход харилцан орж, гарах эрхийг тусгасан, отрын бэлчээрийг нийтээр ашиглахаар зааж, гэрээнд оруулаагүй, нүүх хугацаа жил бүр харилцан адилгүй тул гэрээнд хатуу заагаагүй, өвөл-хаврын бэлчээрт гэрээ хийсэн тул зун-намрын сэдгээ тусаагүй болно
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	<ul style="list-style-type: none"> - Худаг ашиглах журамтай болж журмын дагуу худаг эзэмшүүлэх - Мал услах төлбөр төлбөр жишиг тогтоох - Худаг эзэмшигчийн оролцоог хангах 	Саналыг авч, худаг ашиглах нийтлэг журмыг баримтлан гэрээ хийсэн, нийт ашиглагчийн оролцоо, төлбөрийн асуудлыг бүрэн тусгасан
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Сумын аюулгүй нөөцөд худалдаж авах	Сумын аюулгүй нөөцөд өвс нийлүүлэх асуудлыг тусгав
НЭМЭЛТ САНАЛ		
Түдэвтэй: 92001200 98211238	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	Бэлчээрийн тухай хууль гарч уг хуульд яаж тусгагдсанаар бэлчээр ашиглуулах гэрээг малчид, мал бүхий иргэдтэй хийх. Гэрээгээр ашиглуулбал малчид, мал бүхий иргэдийн эрх, үүргийг нь нарийн тусгах гэрээгээр ашиглах бэлчээрийн ургац, даацыг тогтоох, мөн га-ийн хэмжээг тогтоох	Хуулийн дагуу малчдын бүлэгтэй гэрээ хийсэн, иргэн, өртэй хийгээгүй, эрх үүргийг нарийн зааж өгсөн, га-н хэмжээ, даацыг тогтоосон
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Худаг эзэмшигчийн эрх үүргийг сайн тусгах. Энэ жил манай суманд шинээр 2 худаг гаргаж, 3 худгийг сэргээн засварласан. Малчид бүлгээрээ худаг ашиглах, гэрээ зөрчвөл цуцлах гэх мэт	Гэрээнд эрх, үүргийг тодорхой зааж, хариуцлагын тогтолцоог оруулж өгсөн
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
Хадлангийн талбайг гэрээгээр эзэмшүүлбэл сумын засаг дарга, газрын даамал, хадлан авагч малчин,	Саналыг гэрээнд бүрэн тусгасан, малчдын	

	мал бүхий иргэд хамтран гэрээ хийж хадлан хадах талбайн хэмжээ, байршил тогтоож гэрээ хийх. Мөн тухайн жилийн ургацаас хамаарч нөхөрлөл, хоршоотой гэрээ байгуулах	бүлэгтэй гэрээ хийсэн, хоршоо нь аж ахуйн гэж тул гэрээ хийгээгүй
Яруу: ХААТ-ын дарга Ц. Бавуудорж 94091206	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	- Бэлчээр ашиглалтын гэрээнд тусгах заалтуудыг үндэслэн гурван талт гэрээ байгуулах	Тусгай хамгаалалттай газар нутагт гурван талт гэрээ хийх шаардлагатай, саналыг авсан
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Одоо эзэмшиж байгаа малчидтай шинэчилсэн гэрээ байгуулах, паспортжуулах чиглэлээр холбогдох (нөхөрлөл) бичиг баримтыг мэргэжилтэн бидэнд эсвэл тухайн сумын ЗДТГ-аас гаргуулж байвал сайн байна.	Саналыг авсан, төслийн зүгээс одоогийн гэрээнүүдийг шинэчлэх ажлыг дэмжвэл хэрэгжүүлэх боломжтой
ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ		
- Хадлангийн газрыг тухайн орчимд ойрхон нутагладаг малчидтай нь гэрээ байгуулах - Хадлангийн газрыг хашаажуулах - Цаашид усалгаатай болговол үр дүнгээ өгнө - Малын татвараас 50-аас дээш хувийг зарцуулдаг байх	Саналыг авсан, ойролцоо нутагладаг малчин өрхүүд гэрээнд хамрагдсан, хашаажуулах, усалгаатай болгох асуудлыг бүлэг өөрөө шийдэх тул албан журмаар оруулаагүй.	
Алдархаан: Ж. Болд 88861268	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	Бэлчээрийн гэрээг богино хугацаатай байвал зүгээр, урт хугацаатай байгуулбал бусад малчид болон иргэдээс хэл ам гарч болзошгүй	Гэрээг хуулийн дагуу 5-15 жилээр байгуулсан, ер нь аль болох урт хугацаатай байх тусмаа өөриймсөг сэтгэлгээ төрнө гэдэг зарчмыг баримталсан
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Худгийг ойр орчмын айл өрхүүдийн дунд эзэмшүүлэх нь зохистой бөгөөд эвдрэлийг өөрсдөө хариуцах нь зөв. Нэг хүнд эзэмшүүлснээр худгийн төлбөр тарифыг өөрсдөө тогтоож хэл ам их гардаг	Саналыг бүрэн тусгаж, ашиглагчдын тэгш эрхийг хангасны зэрэгцээ зардал хуваах зарчмыг тусгасан
ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ		
- Хадлангийн талбайг хашиж хамгаалах боломжгүй. Бусад үед нь малын бэлчээр байдаг тул. - Ногоон тэжээл болон олон наст ургамал тариалах чиглэлээр ажил зохион байгуулбал оновчтой болно	Саналыг авсан, хаших эсэх асуудлыг бүлэг өөрсдөө шийдэх нь зөв гэж үзэв. Тэжээл тарих нь ангилал шилжих тул боломжгүй.	
Эрдэнэхайрхан: Засаг даргын орлогч Н. Батбаяр 88464639	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	- Бэлчээр эзэмшигчийн саналыг үндэслэн сум орон нутгаас отроор өвөлжих иргэдэд зөвшөөрөл олгох - Өвөлжөөний бүс нутагт өвөлжөө эзэмших зөвшөөрөл олгох - Хаваржаа намаржаа, зуслангийн бүсэд айл өрх, сууринудад эзэмшүүлэхгүй байх	Отрын нутаг нь нийтээр ашиглах тул гэрээлэгдэхгүй 8 зун-намрын бэлчээрт гэрээ байгуулах эрх зүйн орчин бүрдээгүй тул саналыг авсан гэж үзэв
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээний 2 дугаар зүйлийн 2.2 дахь зүйлд заасан 10 жил гэсэн хугацааг 5-6 жилээр байвал зүгээр байна.	Урт байх тусам өөриймсөг сэтгэлгээ төрдөг тул саналыг аваагүй	
Тэлмэн:	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	


Засаг даргын орлогч Ж. Отгонбаяр 98117276	Бэлчээрийг ашиглуулах гэрээг дэмжиж байна, малчдын оролцоо хариуцлага дээшилнэ	Санал нэг
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Гэрээ боломжийн байна, усан хангамж муудаж байгаа өнөө үед эзэнтэй болговол зүгээр	Санал нэг, гэрээнд тусгасан
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Хадлангийн газар дур зоргоороо өвс хадаж зардаг. Эзэмшүүлж өгвөл хаа хаанаа хариуцлагатай болно	Санал нэг, гэрээгээр эзэнтэй болгож байна
Баянтэс: Ц. Цэрэндорж 99325285	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	Санал байхгүй, дэмжиж байна	
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Санал байхгүй, дэмжиж байна	
ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ		
	Санал байхгүй, дэмжиж байна	
Их-Уул: ХААТ-ын дарга Д. Цогт 98709750	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	Хугацааны хувьд 5 дээш жил байхаар, малын чанарлаг байдлыг харгалзаж үзэх боломж олгох	Урт байх тусам өөриймсөг сэтгэлгээ төрдөг тул саналыг аваагүй
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	<ul style="list-style-type: none"> - Газар нутгийн маргааныг харгалзаж үзэх - Хариуцлагыг нэмэгдүүлэх 	Саналыг авсан, хариуцлагыг нэмэгдүүлж байгаа, ойролцоо нутагладаг өрхүүд ашиглагч байх тул саналыг авсан
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	<ul style="list-style-type: none"> - Хугацааны хувьд урт хугацаагаар байх - Чанарлаг байдлыг харгалзаж үзэх 	Саналыг авсан
Ургамал: Б. Гомбо 89685997	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	Бэлчээр ашиглуулах гэрээг тухайн жилийн ургамлын гарц, малын тоо толгой, сум, багийн нутаг дэвсгэрийн онцлогоос шалтгаалан харилцан адилгүй (сумын нөхцөл байдалдаа тохируулан) зохицуулалт хийх эрхийг засаг даргад өгөх	Саналыг авсан
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Дэмжиж байна, санал үгүй	
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Дэмжиж байна, санал үгүй	
Тэс:	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	<ul style="list-style-type: none"> - Бэлчээрийг малчдад гэрээгээр эзэмшүүлэх малчдын өвөлжөө, хаваржаа, намаржааны хилийн цэсийг сайн тогтоож өгөх - Бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг бариулах - Эрчимжсэн МАА-г түлхүү хөгжүүлэх 	Саналыг авсан, кадастрын зураг хавсаргаж байгаа, малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх үүргийг тусгасан, заавал эрчимжсэн аж ахуй хөгжүүлэхийг гэрээгээр заах боломжгүй
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	<ul style="list-style-type: none"> - Худаг эзэмших гэрээг талууд сайн тохиролцож хийх - Худаг эзэмшихэд оролцооны мөнгийг нь малчдад буцааж олгох - Худгуудаа 100% төр өөрөө хариуцах - Төслийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх 	Сайн тохиролцож хийх саналыг авсан, тохиролцож байж гарын үсэг зурж байгаа, төр өөрөө 100% хариуцах саналыг аваагүй, ашиглагчдын оролцоо хэрэгтэй
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	

	<ul style="list-style-type: none"> - Хадлангийн талбайг усалгаатай талбай болгоход төслийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх - Малчдын бүлэг хоршоог дэмжин ХАА-н тоног төхөөрөмжөөр дэмжих 	Гэрээтэй холбоогүй заалт тул саналыг аваагүй
Асгат	БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ	
	Санал байхгүй, дэмжиж байна	
	ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	<ul style="list-style-type: none"> - Худгийг сэргээн засварлахад нөхөрлөл болон төрөөс хуваан санхүүжилт бий болгон янзлах - Эзэмшүүлэх хугацааг 3-н жил - Худаг усны стандарт, шинжилгээний хариуг жил бүр нөхөрлөл өөрөө бие даан шинжлүүлж шинжилгээний хариугаа гаргуулах 	Сэргээн засварлах зардлыг ашиглагч хариуцахаар тусгасан, хугацааны хувьд хэт богино тул саналыг аваагүй
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
<ul style="list-style-type: none"> - Хадлангийн газар нутагт хор хөнөөл учруулах, ашиглах нөхөн сэргээлт хийж дараа дараагийн нөхөрлөлүүд үйл ажиллагаа явуулахад хэвийн болгох 	Саналыг авсан	
Сантмаргаз	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Санал байхгүй, дэмжиж байна	
	ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ	
	Хадлангийн гэрээний Тавдугаар заалтыг хасах	Саналыг хүлээн авч гэрээнээс хассан

Хавсралт 2.3 Худаг эзэмшүүлэх шинэчилсэн гэрээний танилцуулга



Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж, эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь



ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

Бодлого судлалын төв
www.cpr.mn

2022 оны 08-р сарын

Худгийн усны төлбөр болон үйлчилгээний хөлс

1. Хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан услах зориулалтаар усыг үнэ төлбөргүй хэрэглэнэ. Төр, засгаас баримталж байгаа энэхүү бодлого өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд зохих өөрчлөлтийг оруулж болно.
2. Худгийн үйлчилгээний хөлс нь худгаас ус гаргах тоног төхөөрөмжийг ажиллуулах болон засварлах урсгал зардал, худгийн тоног төхөөрөмж болон худгийн барилгад их засвар хийх, сайжруулах зардал /элэгдлийн сан/, худаг хариуцагчийн цалин, худгийн усыг бохирдол, хөлдөлтөөс хамгаалах зардал, худгийн орчны газрыг талхагдал, бохирдлоос сэргийлэх арга хэмжээний зардлаас бүрдэнэ.
3. Худгийн үйлчилгээний хөлсийг ус хэрэглэгчид хариуцна.

Засаг даргын эрх үүрэг

- БНХМН- нь худаг эзэмшүүлэх гэрээг 5 жилийн хугацаатай хийх;
- Худаг эзэмшигчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэх
- Худгийн ашиглалтын норм, нормативыг мөрдүүлэх;
- Гэрээний хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих ажлыг багийн засаг дарга, байгаль хамгаалагчийн оролцоотойгоор зохион байгуулах
- Хэрэгжилтийн үнэлгээгээр тогтоогдсон зөрчлийг арилгах асуудлыг БОХУБ-д хариуцуулж гүйцэтгүүлэх
- Худгийн үйлчилгээний хөлсний талаар санал боловсруулахад эзэмшигчид шаардлагатай мэргэжлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах
- Энэ гэрээний 9.2.11-д заасан үйлчилгээний хөлсийн талаарх саналыг хянаж, ИТХ-аар батлуулж, мөрдүүлэх

БНХМН-ийн эрх үүрэг

- Гишүүн бус өрх ус хэрэглэсэн тохиолдолд үйлчилгээний хөлс авах
- Худгийн ашиглалт, засвар үйлчилгээг үйлчилгээний хөлсөөр хийх
- Худгийн ойр орчим 200 метрт шинээр хашаа, саравч барихгүй байх;
- Худгийн ашиглалтын норм, нормативыг дагаж мөрдөх;
- Худгийн их засвар, шинэчлэлтийг хийх элэгдлийн сан байгуулах;
- Худгаас малаа услах, унд ахуйн ус хэрэглэх хуваарь гаргаж мөрдүүлэх
- Худгийг ажиллуулах хариуцагчийг томилох, түүнд үйлчилгээний хөлсийг хураах, худаг ажиллуулахтай холбоотой зардлыг дундын сангаас авах эрх олгох
- Худгийн үйлчилгээний хөлсийг энэхүү гэрээний 7.2-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд хангалттай хэмжээнд тогтоож, зөвшилцөн батлуулахаар Засаг даргад мэдүүлэх
- Худгийн үйлчилгээний хөлсийг гишүүн өрхүүдийн малын болон ундны усны хэрэглээтэй харгалзуулан ногдуулж, хураах
- Хураасан үйлчилгээний хөлсийг худаг эзэмшигч малчдын бүлэг, нөхөрлөлийн дундын сангийн дансанд байршуулан энэхүү гэрээний 7.2-д заасан арга хэмжээнд зарцуулах

Хариуцлага

Зөрчлийн тухай хуулийн:

- 1.3 дахь зүйл заалт- Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
- 1.4 дэх зүйл заалт- Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй;
- 1.5 дах зүйл заалт - Усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 3.дах зүйл заалт - Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 8.дах зүйл заалт - Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрүүгийн хуулийн:

24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах

1.дэх заалт -Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хориглох зүйл


Монгол улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалын А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт "Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм" -д заасны дагуу худгийн эрүүл ахуйн хориглолтын бүсийг 50 метр, хязгаарлалтын бүсийг 200 метрээр тус тус тогтоосон байна.

1. А. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;
- Ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах;
- Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;
- Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;
- Судалгаа шинжилгээ, унд ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
- Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;
- Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;
- Машин техник угаах;
- Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;
- Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох;

Б. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөхөөс гадна дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

1. Гаднын хүн орох;
2. Авто тээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах;
3. Мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих;



ЗАВХАН АЙМГИЙН
ДОРВОЛЖИН СУМЫН ЦОГТ БАГИЙН ИРГЭДИЙН
НИЙТИЙН ХУУЛЬН ТОГТООЛ


2022 оны 09 сарын 06 өдөр Дугаар 01 Цэгт

Малчдын бүлэгт бэлчээр
гэрээгээр ашиглуулах, худаг эзэмшүүлэх тухай

Монгол Улсын захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх, Монгол улсын Газрын тухай хуулийн 52 зүйлийн 52.2 дэх заалтууд, "Замба" бүлгийн 2022 оны 08 дугаар сарын 15 өдрийн хүсэлт, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8, 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалтууд, "Сайхан" худаг ашиглагчдын бүлгийн 2022 оны 08 сарын 20-ны өдрийн хүсэлтийг харгалзан БИИХ-ын оролцогчдын 100 хувийн саналыг тус тус үндэслэн тогтоох нь:

1. "Замба" малчдын бүлэгт Талын хар, "Замба" гэдэг газарт байрладаг өвөлжөө, хаваржааны бэлчээрийг 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.
2. Сайхан худаг ашиглагчдын бүлэгт "Замба" худгийг 5 жилийн хугацаагаар гэрээгээр эзэмшүүлсугай.
3. "Замба" малчдын бүлгийн бэлчээр ашиглалт, "Сайхан" худаг ашиглагчдын бүлгийн худаг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтийг жил бүр дүнэн хяналт, хяналт тавьж ажиллахыг Цогт багийн засаг дарга /В.Цэрэнбат/-д даалгасугай.

ДАРГАЛГАН  С.ПҮРЭВНЯМ /



ЗАВХАН АЙМГИЙН
ДОРВОЛЖИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 09 өдөр Дугаар 029 Бүгд

Малчдын бүлэгт худаг гэрээгээр
эзэмшүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8, 29 дүгээр зүйлийн 29.2.1, Хүнс Хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 101/189/194 тоот тушаалаар баталсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийн сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ын 4.4.3 дахь заалт, Буурал багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоол, Цогт багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 09 дүгээр 06-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Буурал багийн "Мэргэн гахай" худаг ашиглагчдын бүлэгт Жанчив гүний худгийг, Цогт багийн "Сайхан" худаг ашиглагчдын бүлэгт Замба худгийг 5 жилийн хугацаатай гэрээгээр эзэмшүүлж, ашиглуулахыг зөвшөөрсугай.
2. Худаг эзэмшүүлж ашиглах гэрээг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
3. Мэргэн гахай, Сайхан худаг ашиглагчдын бүлгийн худаг эзэмшин ашиглах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүнэн хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Ч.Отонжаргал), багийн Засаг дарга В.Цэрэнбат, Р.Алзахгүй нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  В.БАТВӨЛЦ

Zahiranj-2022

Хавсралт 2.3.1 Ховд аймаг, НАГ-г шинэчлэн боловсруулахад орон нутгаас санал авсан оролцогчдын нэрс, албан тушаал

№	Овог нэр	Албан тушаал	Хүйс
Алтай сум			
1	Х.Түмэндэлгэр	Засаг дарга	эмэгтэй
2	Б.Бат-Эрдэнэ	ИТХ-ын дарга	эрэгтэй
3	Б.Түмэндэмбэрэл	Газрын даамал	эрэгтэй
4	Ж.Бямбадорж	Байгаль хамгаалагч	эрэгтэй
5	О.Муушар	Барлаг багийн засаг дарга	эрэгтэй
6	Б.Алтангэрэл	Мянган угалзатын нуруу БЦГ-ын байгаль хамгаалагч	эрэгтэй
7	Д.Цогбадрах	Алтангадас багийн засаг дарга	эрэгтэй
8	Л.Гандолгор	ХААТ-ын үржлийн мэргэжилтэн	эмэгтэй
9	Т.Өнөржаргал	ХААТ-ын мэргэжилтэн	эрэгтэй
10	Б.Олдохжаргал	ЗДТГ	эмэгтэй
Булган сум			
1	Б.Мөнхтөр	Засаг даргын орлогч	эрэгтэй
2	Д.Батхуяг	ХААТ-ын мэргэжилтэн	эрэгтэй
3	Ц.Галсанравдан	Багийн засаг дарга	эрэгтэй
4	Б.Гансүх	Багийн засаг дарга	эрэгтэй
1	Ш.Ганболд	Тамгын газрын дарга	эрэгтэй
5	М.Болотхаан	Баянсудал багийн засаг дарга	эрэгтэй
6	У.Ганбат	Байтаг багийн засаг дарга	эрэгтэй
7	Б.Батзориг	Булган-Онгог сав газрын дарга	эрэгтэй
8	Д.Сайнсор	ТХГН-ын мэргэжилтэн	эрэгтэй
9	С.Ганцоож	Газрын даамал	эмэгтэй
10	Ж.Дамдинбазар	Сумын засаг дарга	эрэгтэй
Дарви сум			
1	Л.Мөнхжаргал	Тамгын газрын дарга	эрэгтэй
2	Б.Энхболд	ЗД-орлогч	эрэгтэй
3	Д.Ившинхорол	Газрын даамал	эмэгтэй
4	Л.Рэгжийбуу	ХААТ-ын мэргэжилтэн	эмэгтэй
5	Н.Батболд	ИТХ-ын нарийн бичгийн дарга, БОХУБ	эрэгтэй
6	Ё.Бат-Эрдэнэ	Мөнгөн аяга багийн засаг дарга	эрэгтэй
7	Ш.Тэгшбуян	Баянбулаг багийн засаг дарга	эрэгтэй
8	М.Орхон	Дэлгэр багийн засаг дарга	эрэгтэй
Мөст сум			
1	Л.Бямба-очир	Тамгын газрын дарга	эрэгтэй
2	Д.Лхагвадорж	Цэцэг гол багийн засаг дарга	эрэгтэй
3	Г.Буяндэлгэр	Хужирт багийн засаг дарга	эрэгтэй
4	Х.Гантөмөр	Баянхайрхан багийн засаг дарга	эрэгтэй
5	Э.Отгонбаатар	Давст багийн засаг дарга	эрэгтэй
6	Г.Батбаяр	Улаантолгой багийн засаг дарга	эрэгтэй
7	С.Баасандорж	Засаг дарга	эрэгтэй
8	Н.Цогоо	Засаг даргын орлогч	эрэгтэй
9	А.Ариунболд	ИТХ-ын дарга	эрэгтэй
10	Д.Түмэнхүү	ХААТ-ын дарга	эрэгтэй
11	Б.Алтангэрэл	БОХУБ	эрэгтэй

12	О.Пүрэвдаш	Газрын даамал	эрэгтэй
13	Ж.Лхагвадорж	ХААТ-ын мэргэжилтэн	эрэгтэй
Цэцэг сум			
1	Ж.Мөнхзориг	Засаг дарга	эрэгтэй
2	Б.Одонбаяр	Засаг даргын орлогч	эрэгтэй
3	Б.Үйлэнзаяа	ИТХ-ын нарийн бичгийн дарга	эмэгтэй
4	Д.Гантуяа	ХААТ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн	эмэгтэй
5	Д.Төмөрхуяг	ХААТ-ын мэргэжилтэн	эрэгтэй
6	Н.Батчулуун	Хажинга багийн засаг дарга	эрэгтэй
7	М.Зоргио	Цэцэг нуур багийн засаг дарга	эрэгтэй
8	Т.Сүхбат	Баян-Овоо багийн засаг дарга	эрэгтэй
Үенч сум			
1	О.Мягмар	Засаг даргын орлогч	эрэгтэй
2	Л.Алимаа	ХААТ-ын мэргэжилтэн	эмэгтэй
3	Х.Солонго	Газрын даамал	эмэгтэй
4	Д.Мөнхдалай	Байгал орчны хяналтын улсын байцаагч	эрэгтэй
5	Т.Уранбилэг	ИТХ-ын нарийн бичгийн дарга	эмэгтэй
6	Б.Нямжаргал	Хууль, эрхзүйч	эмэгтэй
7	О.Баярмаа	Малын эмч	эмэгтэй
8	Г.Нандинцэцэг	Нягтлан	эмэгтэй
9	Э.Аззаяа	Цагаан түнгэ багийн засаг дарга	эрэгтэй
10	Э.Уртнасан	Сумын засаг дарга	эрэгтэй
Чандмань сум			
1	Д.Бат	ИТХ-ын дарга	Эр
2	С.Гантөмөр	ИТХ-ын нарийн бичгийн дарга	Эр
3	Ц.Нямтулга	ИТХ-ын ажилтан	Эр
4	Б.Чинбат	ЗДО	Эр
5	Д.Мягмар	ХААТ-ийн дарга	Эр
6	Т.Сэр-Од	ХААТ-гийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн	Эр
7	Д.Алтантуяа	БЗД	Эр
8	С.Жаргалсайхан	БОХУБ	Эр
9	Ц.Энхтуяа	Татварын байцаагч	Эм
10	Б.Догсом	ТНС төслийн зохицуулагч	Эр
11	Д.Батцоож	Ихэр Наран МБ ахлагч	Эр
12	Түвшинбаяр	Сүлжээ БЗД	Эр
13	Э.Ариунболд	Хөх сайр малчдын бүлгийн ахлагч	Эр
14	Г.Мягмар	Оргих худаг ашиглагчдын бүлгийн ахлагч	Эр
Эрдэнэбүрэн сум			
1	Б.Энхбат	ИТХ-ын дарга	Эр
2	Н.Цэрэнтогтох	Засаг дарга	Эр
3	Г.Нямсүх	БЗД	Эр
4	Алтан-Өргөө	Нийгмийн даатгалын байцаагч	Эм
5	Д.Мягмарсүрэн	БЗД	Эр
6	Ч.Гантуяа	ЗДТГ-ын бичиг хэрэг	Эм
7	Г.Цэрэннамид	Улсын бүртгэгч	Эр
8	П.Банзрагч	Татварын улсын байцаагч	Эр
9	Б.Даваацэрэн	БОХУБ	Эр
10	Б.Дэлгэрдалай	Газрын даамал	Эр

11	Ц.Гантөмөр	ХААТ мэргэжилтэн	Эм
12	О.Жавзанханд	ХААТ мэргэжилтэн	Эм
Мянгад сум			
1	М.Баатар	Засаг дарга	Эр
2	Ө.Хишигтогтох	БОХУБ	Эм
3	Ж.Эрхбаяр	ХААТ дарга	Эр
4	Ц.Цэцэгмаа	газрын даамал	Эм
5	Д.Женгул	Татварын улсын байцаагч	Эм
6	Г.Батсүх	БЗД	Эр
7	О.Гантулга	БЗД	Эр
8	М.Баянжаргал	БЗД	Эр
9	Ч.Улаанхүү	ЗДТГ-ын дарга	Эр
10	Д.Нямдорж	ЗДО	Эр
11	Р.Баяржаргал	Төрийн сан	Эр
Дөргөн сум			
1	А.Батцоож	ИТХ-ын дарга	Эр
2	Л.Цэдэн-Иш	Засаг дарга	Эр
3	Л. Пүрэвцэцэг	ИТХ-ын ажилтан	Эм
4	Д.Буянтогтох	байгаль хамгаалагч	Эр
5	Б.Бат	ЗДТГ-ын дарга	Эр
7	Н.Ганцэцэг	газрын даамал	Эм
8	Н.Ганбат	БЗД	Эр
9	Б.Төмөрцоож	Татварын улсын байцаагч	Эр
10	Ц.Энхбат	БЗД	Эр
11	Л.Цэнд-Аюуш	БЗД	Эр
12	Л.Содномцэрэн	ХААТ-гийн мэргэжилтэн	Эр

Зэрэг сум			
	Б.Батсүх	ИТХ-ын дарга	эрэгтэй
	О.Хүдэр	ЗД-ын орлогч	эрэгтэй
	Д.Чулуунтогтох	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Ж.Онцбаяр	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Ариунболд	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Бат-Эрдэнэ	Газрын даамал	эрэгтэй
	П.Болортуяа	БОХУБ	эмэгтэй
	Азбилэг	ИТХ-ын нбд	эрэгтэй
	Х.Батбилэг	Бургасан багийн ЗД	эрэгтэй
Манхан сум			
	Т.Лхагвасүрэн	Засаг дарга	эрэгтэй
	Г.Ядамжав	ЗДТГ-ын дарга	эрэгтэй
	Б.Баяржаргал	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Г.Гантогтох	БОХУБ	эмэгтэй
	Галбадрах	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Нансалмаа	Газрын даамал	эмэгтэй
	Алтангэрэл	Баянгол багийн ЗД	эрэгтэй
	Х.Мөнхдаваа	ЗД-ын орлогч	эрэгтэй
	Мөнх-Эрдэнэ	Тахилт багийн Засаг дарга	эрэгтэй
Дуут сум			
	Ц.Одбаатар	ИТХ-ын дарга	эрэгтэй
	С.Ганзориг	Засаг дарга	эрэгтэй

	Ц.Баянмөнх	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Д.Сэргэлэн	Газрын даамал	эмэгтэй
	Ж.Занданхүү	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	А.Болормаа	СБАХ тэргүүн	эмэгтэй
	Д.Баттөмөр	ИТХ-ын нбд	эрэгтэй
	Л.Алтанцэцэг	БОХУБ	эмэгтэй
	Т.Эрдэнэ-Оюун	Эрх зүйч	эмэгтэй
	И.Ганхуяг	Шивэрт багийн Засаг дарга	эрэгтэй
	Д.Намжилсүрэн	Баянгол багийн Засаг дага	эрэгтэй
Буянт сум			
	Б.Түвшинсайхан	Засаг дарга	эрэгтэй
	Б.Цэнд-Аюуш	ИТХ-ын дарга	эрэгтэй
	Д.Баттулга	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Б.Мөнгөнцэцэг	ХААТ мэргэжилтэн	эмэгтэй
	Ц.Идэрсайхан	ЗД-ын орлогч	эрэгтэй
	Д.Баттулга	ИТХ-ын нбд	эрэгтэй
	Л.Баасанхүү	Газрын даамал	эрэгтэй
	И.Баасандорж	БОХУБ	эрэгтэй
	Б.Уянга	Татварын байцаагч	эмэгтэй
	Д.Батдорж	БАХ-ийн ахлагч	эрэгтэй
Мөнххайрхан сум			
	Я.Очир	ИТХ-ын дарга	эрэгтэй
	Б.Батболд	Засаг дарга	эрэгтэй
	Р.Отгонжаргал	ЗД-ын орлогч	эрэгтэй
	В.Батчулуун	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Л.Эрдэнэтуул	ХААТ мэргэжилтэн	эмэгтэй
	С.Оюун-Эрдэнэ	Газрын даамал	эмэгтэй
	Б.Булгантамир	БОХУБ	эмэгтэй
	Мөнх-Алдар	БЗД	эрэгтэй
	С.Мөнх-Очир	БАХ-ийн ахлагч	эрэгтэй
	Б.Түвшинзориг	ИТХ-ын нбд	эрэгтэй
Ховд сум			
	О.Тумерхан	Засаг дарга	эрэгтэй
	Ж.Мухтар	ЗД-ын орлогч	эрэгтэй
	Х.Өнөрхан	ЗДТГ-ын дарга	эрэгтэй
	Ш.Дүрэмхан	ХААТ мэргэжилтэн	эрэгтэй
	Х.Жанар	Газрын даамал	эмэгтэй
	С.Айбат	БОХУБ	эмэгтэй
	Х.Аблайхан	ИТХ-ын нбд	эмэгтэй
	Х.Володя	Төрийн сангийн мэргэжилтэн	эрэгтэй
	Т.Далелхан	Хуулийн мэргэжилтэн	эрэгтэй
	Б.Айбол	Багийн ЗД	эрэгтэй

Хавсралт 2.3.2 Завхан аймаг, НАГ-г шинэчлэн боловсруулахад орон нутгаас санал авсан оролцогчдын нэрс, албан тушаал

Дөрвөлжин сум			
1	Н.Батболд	Сумын засаг дарга	эр
2	Ч.Отгонжаргал	ХААТ-ийн мэргэжилтэн	эм
3	В.Уранчимэг	ЗДТГ-ын дарга	эм
4	В.Цэрэнбат	Багийн засаг дарга	эр
5	Р.Алзахгүй	Багийн засаг дарга	эр
6	Н.Батбилэг	БОХУБ	эр
Эрдэнэхайрхан сум			
1	А.Балжир	Сумын засаг дарга	эр
2	Г.Энхтуяа	ХААТ-ийн мэргэжилтэн	эм
3	Э.Маргад-Эрдэнэ	ХААТ-ийн мэргэжилтэн	эр
4	С.Цэгмид	Багийн засаг дарга	эр
5	Б.Балсан	Багийн засаг дарга	эр
Завханмандал сум			
1	Г.Мягмаржав	Сумын засаг дарга	эр
2	Н.Авирмэд	ХААТ-ийн мэргэжилтэн	эм
3	Б.Нүрзэд	ХААТ-ийн мэргэжилтэн	эр
4	Б.Балжинням	Багийн засаг дарга	эр
5	Ш.Мөнхзориг	Багийн засаг дарга	эр
Ургамал сум			
1	Г.Гэрэлт-Од	Сумын засаг дарга	эр
2	М.Чанцалдулам	ХААТ-ийн мэргэжилтэн	эм
3	Д.Мөнхзул	Газрын даамал	эр
4	Ц.Мэндээ	ИТХ-ын ажилтан	эм
5	Ц.Бямбадорж	Багийн засаг дарга	эр
Сантмаргаз сум			
1	Б.Эрдэнэбаатар	Сумын засаг дарга	эр
2	Т.Хатанбаатар	Сумын ИТХ-ын дарга	эр
3	Б.Туяа	ХААТ-ийн мэргэжилтэн	эм
4	Б.Долгорсүрэн	ХААТ-ийн мэргэжилтэн	эм
5	Г.Түмэндэмбэрэл	Багийн засаг дарга	эр
6	Б.Эрдэнэцогт	СБАХ ТББ-ын тэргүүн	эр
7	Б.Балсан	Багийн засаг дарга	эр
8	М.Өнөржаргал	Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга	эм
Цэцэн-Уул			
1	Б.Оргилсайхан	Сумын засаг дарга	эр
2	Д.Даваадорж	Газрын даамал	эр
3	Н.Батдорж	ХААТ-ийн дарга	эр
4	М.Баянмөнх	БОХУБ	эр
Яруу сум			
1	Н.Эрдэнэнэмэх	Сумын засаг дарга	эр
2	Н.Бавуудорж	ХААТ-ийн мэргэжилтэн	эр
3	С.Сүхбаатар	БОХУБ	эр
4	С.Лхагва	Багийн засаг дарга	эр
5	Ж.Дашдондов	Багийн засаг дарга	эр
Асгат			
1	Л.Нямдорж	Газрын даамал	эр
2	Е.Нямрагчаа	Засаг дарга	эр
3	Б.Батгэрэл	БЗД	эр
4	В.Чимэддорж	БЗД	эм

Түдэвтэй			
1	Л.Цэндсүрэн	Газрын даамал	эм
2	Д.Ганчимэг	БЗД	эм
3	Ц.Батнөхөрлөл	ИТХ дарга	эр
4	Ц.Отгонбаяр	Засаг дарга	эр
Баянхайрхан			
1	Б.Батсайхан	СЗД	эр
2	Б.Баасанбат	Орлогч	эр
3	Б.Сумъяа	ХААТ мэргэжилтэн	эм
4	Б.Төгсдэмбэрэл	Газрын даамал	эм
5	М.Батлхагва	БЗД	эр
6	Н.Гомбо	БЗД	эр
7	Д.Эрдэнээ	БЗД	эм
8	Х.Одсайхан	ХААТ мэргэжилтэн	эр
9	М.Чимэдцэрэн	Байгаль хамгаалагч	эр

Хавсралт 2.4. Нөөц ашиглалтын Шинэчилсэн гэрээний загварууд

БАТЛАВ СУМЫН ЗАСАГ ДАРГА

.....

БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

202 оны сарын -ны өдөр

Гэрээний дугаар:

НЭГ ТАЛААС аймгийн сумын Засаг дарга (цаашид “Өмчлөгч” гэх), НӨГӨӨ ТАЛААС аймгийн сумын малчдын **бүлэг, нөхөрлөл (нэр)** (цаашид “Ашиглагч” гэх)-д бэлчээр гэрээгээр ашиглуулах, хамгаалах талаар харилцан тохиролцож, Монгол улсын Иргэний хуулийн 189.1, 189.5, 481.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.17, Газрын тухай хуулийн 45.1, 52.2, 52.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4.1.3, 4.2.3, 17.2.2, 19.7, 26.3, 27.1, 27.7, 48.1.1, 50.4, 50.5, 52.1, 54.1, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17.2, 21.2, 21.2, 29.2, 30.10, 33.1, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 22.6, 23.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5.4, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.1, Төсвийн тухай хуулийн 60.2.8 дахь заалт, Засаг даргын 202 оны тоот захирамжийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү гэрээгээр малчдын бүлэг, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд байгалийн бэлчээрийг ашиглуулах, хамгаалах, түүнчлэн гэрээний хэрэгжилт, үүргийн биелэлтэд хяналт тавих, дүгнэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Хоёр. Бэлчээр ашиглалтын зориулалт, хэмжээ, байршил

- 2.1 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийг зөвхөн мал аж ахуй эрхлэх зориулалтаар ашиглана.
- 2.2 Ашиглагчаас гэрээгээр ашиглуулах бэлчээрийн талбайг га-аар тогтоов.

2.3 Бэлчээрийн зуны дээд ургацыг олон жилийн дунджаар ц/га;

2.4 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн даацыг хонин толгойд шилжүүлснээр дараах жишиг үзүүдэлтээр тогтоов. Үүнд:

2.4.1.1Өвөлжөөний бэлчээр	га, даац	хонин толгой
2.4.1.2Хаваржааны бэлчээр	га, даац	хонин толгой
2.4.1.3Өвөлжөө-хаваржааны бэлчээр	га, даац	хонин толгой

2.5 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн даацын тооцоонд өвсөн тэжээлт зэрлэг хөхтөн амьтдыг оруулж тооцно.

2.6 Ашиглагчдын талаарх мэдээлэл (Хавсралт 1), гэрээлсэн бэлчээрийн байршил, хэмжээ, улирлын ашиглалтын зураг (Хавсралт 2), ашиглагчийн малын тооны мэдээлэл (Хавсралт 3), бэлчээрийн даацад нийцүүлэх үүднээс малын тоог цөөлөх ... жилийн төлөвлөгөө (Хавсралт 4), гэрээт бэлчээрийн төлөв байдлын суурь мэдээлэл (Хавсралт 5)-ийг тус тус хавсаргав.

2.7 Гэрээний хүчинтэй хугацаа сунгалтгүйгээр 15 /арван тав/ жил байна.

Гурав. Өмчлөгчийн эрх, үүрэг

3.1. Өмчлөгч нь дараах эрх, үүрэгтэй.

3.1.1. Гэрээлсэн бэлчээрт эрх бүхий этгээдийн тогтоосон цэгт бэлчээрийн ургац, даацыг жил бүр тогтоох

3.1.2. Сүүлийн 5 жилийн дундаж ургацыг үндэслэн байвал зохих малын тооны дээд хязгаарыг шинэчлэн тооцож ашиглагчид хүргүүлэх

3.1.3. Байгаль-цаг уурын онцгой байдал тохиолдох үед ашиглагчдын бэлчээрийн даацад тохируулан бусдын малыг оруулах, эсхүл гадагш нүүлгэх, өөр суманд отроор ороход тухайн сумын Засаг даргатай тохиролцож, саадгүй зохион байгуулах;

3.1.4. Цаг агаарын хүндрэлтэй үед сум дотроо нүүдэллэх, нутаглах боломжтой газар, байршил, багтаамжийн мэдээллээр хангах;

3.1.5. Ашиглагчдын гэрээт бэлчээрт 3.1.3-д заасан зохих зөвшөөрөлгүйгээр мал оруулсан гаднын малчдыг нүүлгэх арга хэмжээ авах;

3.1.6. Бэлчээрт хөрөнгө оруулалт (худаг гаргах, хөв байгуулах, уст цэг тохижуулах, малын хашаа, хороо барих, засаж сэлбэх гэх мэт) хийх талаар ашиглагчтай зөвшилцөн хэрэгжүүлэх;

3.1.7. Гэрээт бэлчээрийн даацыг хэтрүүлсэн, төлөв байдлыг доройтуулсан, хохирол учруулсан тохиолдолд буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх, арилгуулах талаар шийдвэр гаргах, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.8. Гэрээт бэлчээрт буюу ойролцоо байршсан зэрлэг амьтад ундаалдаг булаг, шанд, баян бүрд болон хужир мараа бүхий газрыг тухайн амьтдын төллөлт, шилжилт, ундаалдаг үед айл, малаас чөлөөлүүлэх арга хэмжээ авах

3.2 Бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилт, үйл ажиллагааны цогц төлөвлөгөө ба менежментийн төлөвлөгөөний биелэлтийг энэхүү гэрээний 5-д заасны дагуу жил бүр дүгнэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авах;

3.3 Мал борлуулсны урамшуулалд олгох эх үүсвэр бүрдүүлэх, эх үүсвэрээс мөнгөн урамшуулал олгох;

3.4 Гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн тухай болон талуудаас цаашид авах арга хэмжээний талаарх мэдэгдлийг Ашиглагчид бичгээр албан ёсоор хүргүүлэх

3.5 Бэлчээр ашиглуулах гэрээ дүгнэсэн дүнг БОХУБ-д хүргүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авхуулах

Дөрөв. Ашиглагчийн эрх, үүрэг

4.1. Бэлчээр ашиглагч нь дараах эрх, үүрэгтэй.

4.1.1. Гэрээлсэн бэлчээрийг мал аж ахуй эрхлэх зориулалтаар зохистой ашиглах;

4.1.2. Гэрээт бэлчээрт мал оруулах, нутаглах зэргээр дур мэдэн ашигласан, хашаа, хороо барьсан зэрэг бүлгийн гишүүн бус этгээдийн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг төлүүлэх, арилгуулахыг талаар өмчлөгчөөс шаардах;

4.1.3. Гэрээлсэн бэлчээрт байлгавал зохих малын тоо (хонин толгойд шилжүүлснээр)-г энэхүү гэрээний 2.4-д заасан даацад нийцүүлэх тухайн жилийн зорилт (урьд оноос 5% бууруулах)-ыг биелүүлэх, төлөв байдал, бүтээмжийг нь суурь түвшин (хавсралт 5)-ээс нь доройтуулахгүйгээр зохистой ашиглах;

4.1.4. Бусад ашиглагчдын бэлчээрийн хил заагийг хүндэтгэн өөрсдийн малаа оруулахгүй, нүүж нутаглахгүй байх;

4.1.5. Ган, зуд зэрэг байгалийн эрсдэл тохиолдсон үед гэрээлсэн бэлчээрийн даацыг хэтрүүлэлгүй бусдын малыг оруулах

4.1.6. Тогтоосон журмын дагуу дайран өнгөрөхөөс бусад тохиолдолд гэрээлсэн бэлчээрт мал дур мэдэн оруулахгүй байхыг бусдаас шаардах;

4.1.7. Энэхүү гэрээний 3.1.8-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.1.8. Энэхүү гэрээний 3.5-д заасны дагуу мал борлуулсны урамшууллыг зохих эх үүсвэрээс авах;

4.1.9. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг сунгуулах, цуцлах, дуусгавар болгох, шинэчилж байгуулах талаар Өмчлүүлэгчид хүсэлт гаргах.

Тав. Гэрээ байгуулах, дүгнэх

5.1 Газрын тухай хуулийн 23.4.2 дахь заалт болон сумын Засаг даргын захирамжийг үндэслэн бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах арга хэмжээг газрын даамал хариуцан гүйцэтгэнэ.

5.2 Бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах болон дүгнэхэд албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийнх нь дагуу Газрын даамал, Хөдөө аж ахуйн тасаг (ХААТ)-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтнийг ажиллуулна.

5.3 Бэлчээр ашиглуулах гэрээг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан дүгнэнэ.

5.5 Бэлчээр ашиглуулах гэрээний биелэлт, үүргийн гүйцэтгэлийг Газрын даамал ХААТ-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран нэгтгэсэн тайланг Засаг даргад хүргүүлнэ.

Зургаа. Бэлчээр ашиглуулах гэрээг сунгах, цуцлах, дуусгавар болгох

6.1 Дараах тохиолдолд бэлчээр ашиглуулах гэрээг сунгана.

6.1.1 Гэрээний хүчинтэй хугацаа дууссан бөгөөд аль нэг тал, эсхүл ашиглагч дангаар гэрээ сунгах хүсэлтээ албан ёсоор гаргасан,

6.1.2 Гэрээ сунгах хүсэлт гаргагч тал энэ тухай гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө бичгээр ирүүлсэн

6.1.3 Гэрээ сунгах асуудлаар Өмчлөгч эцсийн шийдвэрийг гаргана.

6.2 Бэлчээр ашиглуулах гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу болон гэрээнд заасан хугацаанаас нь өмнө дараах үндэслэлээр цуцалж болно.

6.2.1 Бэлчээр ашиглагч гэрээг цуцлах хүсэлт гаргасан.

6.2.2 Бэлчээрийг хүний эрүүл мэнд, байгаль орчин, нөөцийн аюулгүй байдалд сөргөөр ашигласан нь тогтоогдсон.

6.2.3 Бэлчээрийн төлөв байдлыг байгалийн аясаар нөхөн сэргэх боломжгүй болтол нь доройтуулсан нь нотлогдсон.

6.2.4 Гэрээнд заасан бэлчээрийг зориулалтын дагуу ашиглаагүй, худаг, ил ус, хужир мараа зэрэг дагалдах нөөцийг дахин ашиглах боломжгүйгээр эвдэж гэмтээсэн, сүйтгэсэн.

6.3 Энэхүү гэрээнд зааснаас бусад тохиолдолд Өмчлөгч өөрийн санаачилгаар энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах, дуусгавар болгохыг хориглоно.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Урьдчилан мэдээлэх, мэдэх боломжгүй зуд, ган, үер зэрэг байгалийн аюултай үзэгдэл, түймэр, мал амьтны гоц халдварт өвчний тархалт, эдгээртэй холбоотой хорио цээр, нийтийн дайчилгааны улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээнд тусгасан нөхцөлийн талаар харилцан үүрэг хүлээхгүй.

Найм. Хориглох зүйл

8.1. Байгаль орчинд хохирол учруулах аливаа үйл ажиллагаа явуулах;

8.2. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зориулалтаар гэрээгээр олгогдсон бэлчээрийг бусдын мал бэлчээх, дайран өнгөрөхөд саадтайгаар хаших;

8.3. Хүн, малын усанд зориулж худаг гаргах, сэг зэмийг зөвшөөрсөн цэгт булахаас бусад зорилгоор газрын хөрсийг хөндөх;

8.4. Бэлчээр, түүний хөрс, ургамлын нөмрөгт сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулах;

Ес. Хариуцлага

9.1. Талууд, аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Арав. Талуудын хооронд үүсэх маргааныг шийдвэрлэх

10.1. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын талаарх маргааныг харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ. Эс тохиролцвоос Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

Арван нэг. Бусад

11.1. Гэрээ байгуулах талууд, эсхүл тэдгээрийн төлөөлөл гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэхүү гэрээг хүчин төгөлдөр болсонд тооцно.

11.2. Гэрээнд хавсаргасан нэр бүхий баримт бичгүүд түүний салшгүй хэсэг мөн.

11.3. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

11.4 Энэхүү гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, 202 оны сарын -ны өдөр гарын үсэг зурав. Гэрээний нэг хувийг албан хэрэгцээнд зориулан талуудад хадгалуулав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Өмчлөгчийг төлөөлж:

Ашиглагчийг төлөөлж:

Сумын Газрын даамал

Малчдын бүлэг, нөхөрлөлийн ахлагч

.....
/овог нэр/

.....
/овог нэр/

Гарын үсэг

Гарын үсэг

Регистр:
Харилцах утас:

Регистр:
Харилцах утас:

Гэрээтэй танилцаж зөвшөөрсөн:

Гишүүн өрхийн тэргүүн		Гэр бүлийн гишүүн /эхнэр болон бусад/	
Овог нэр	Гарын үсэг	Овог нэр	Гарын үсэг

БАТЛАВ СУМЫН ЗАСАГ ДАРГА

.....

ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

20 оны ... дугаар

сарын ... -ны өдөр

Дугаар ...

.....

Нэг. Гэрээний үндэслэл

1.1 Монгол улсын "Газрын тухай хууль" "Байгаль орчныг хамгаалах тухай хууль", "Байгалийн ургамлын тухай хууль", "Байгалийн ургамал ашигласны төлбөрийн ухай хууль", "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль", "Газрын төлбөрийн тухай хууль", Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол, өвс, техникийн ерөнхий шаардлага MNS 0592:2008, өвс тээвэрлэлтийн ерөнхий шаардлага №1NS 5647:2006-г тус тус үндэслэл болгон хадлангийн зориулалтаар олгох газрын эзэмшил, ашиглалт, хамгаалалт, хяналт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг нөхөрлөл, төрийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 311 дүгээр зүйл,аймгийн.....сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20..... оны ... дугаар сарын ... ны өдрийн тоот тогтоолыг үндэслэн нэг талаас аймгийн сумын Засаг дарга/цаашид "Засаг дарга" гэх/, нөгөө талаас Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл /цаашид "нөхөрлөл" гэх/ -ийн ахлагч нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 2.2 нөхөрлөл нь тус сумын хадлангийн ангилалд багтах нэртэй газар га хадлангийн талбайг 20.. оны ... дугаар сарын ... ны өдрөөс 20.. оны ... дугаар сарын ... ны өдрийг хүртэл 10 жилийн хугацаанд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 311 дүгээр зүйлд заасны дагуу хадлангийн зориулалтаар эзэмшүүлэхээр тохиролцов.

Гурав. Засаг даргын эрх, үүрэг

3.1 Засаг дарга гэрээлэх хадлангийн талбайг нөхөрлөлд акт үйлдэн хүлээлгэн өгөх ба акт нь гэрээний салшгүй хэсэг болно. Актад хадлангийн талбайн байршил, хилийн зааг, эргэлтийн цэг, талбайн хэмжээ, нэгж талбарын дугаар, хадлангийн газрын төлөв байдлыг үнэлсэн мэдээллийг гэрээнд хавсаргана.

- 3.2 Нөхөрлөлтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэнэ.
- 3.3 Гэрээт хадлангийн талбайн ургацыг эрх бүхий этгээдээр жил бүр тогтоолгох
- 3.4 Нөхөрлөлийн гэрээт хадлангийн талбайд гарсан түймэр болон бусад байгалийн аюул гамшгийн хор уршгийг арилгуулах, шаардлагатай гэж үзвэл энэ ажилд иргэд аж ахуй нэгж, байгууллагыг татан оролцуулж туслалцуулна.
- 3.5 Хадлангийн газраа тухайн жил нөхөрлөлийн хүчээр бүрэн ашиглах боломжгүй бол нөхөрлөлтэй тохиролцон бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд гэрээт хадлангийн газарт хадлан бэлтгэх зөвшөөрөл олгож болно.
- 3.6 Нөхөрлөл нь энэхүү гэрээнд заасан үүрэг, холбогдох хууль тогтоомж, журмыг дараалсан хоёр жил биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцална.
- 3.7 Нөхөрлөлтэй байгуулсан хадлангийн газар эзэмшүүлэх гэрээг холбогдох журамд заасан хугацаагаар сунгана.
- 3.8 Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын 15 хувийг хадлангийн газрыг хамгаалж, сайжруулах арга хэмжээнд зарцуулж, сумын ИТХ-д тайлагнах

Дөрөв. Нөхөрлөлийн эрх, үүрэг

- 4.1 Нөхөрлөл нь гэрээт хадлангийн талбайг энэхүү гэрээний 2.2-д заасан зориулалтын дагуу, 3.1-д заасан төлөв байдлаас доройтуулахгүйгээр зохистой ашиглах
- 4.2 Нөхөрлөл нь жил бүр бэлтгэх хадлангийн хэмжээ, түүнээс орох төлбөрийн орлогын талаар тухайн жилийн ургац тогтоосон мэдээллийг үндэслэн Засаг даргатай жил бүр зөвшилцөн баталгаажуулах
- 4.3 Хадлангийн талбайгаа бусдад шилжүүлэхгүй, зөвшөөрөлгүй иргэн ААН-д ашиглуулахгүй байх
- 4.4 Газрын хөрс, ургамлын бүтцэд сөрөг нөлөө үзүүлдэг тоног төхөөрөмж, саран тармуур ашиглахгүй байх, тоног төхөөрөм, техник хэрэгсэлд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, ирийг 10 см-ээс доош тавихгүй байх
- 4.5 Гэрээт талбайд хадлан бэлтгэх хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм зөрчсөнөөс шалтгаалах түймрийн эрсдэлийг хариуцах. Энэ үүднээс техникийн аюулгүй байдлыг ханган ажиллах, гал унтраах хэрэгсэлтэй байх, тээврийн хэрэгслийн гал унтраагуур, яндангийн оч баригчтай байх
- 4.6 Хадлангийн газрын хөрсийг хамгаалах, доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор салаа зам гаргахгүй байх, ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях
- 4.7 Тухайн жилийн бэлтгэсэн өвснөөс 2%-р тооцож, сумын өвсний фондод хандивлах
- 4.8 Бэлтгэсэн өвсийг нөхөрлөлийн гишүүд, сумын малчдад орон нутгийн ханшаар, үлдэх хэсгийг зах зээлд борлуулах
- 4.9 Тухайн жилийн ургамлын гарцаас шалтгаалан 08 сарын 15-с 10 сарын 1-ны дотор хадлан бэлтгэх
- 4.10 Хадлангийн бэлтгэж дууссаны дараа хадлангийн талбайн хог хаягдал, орчны бохирдлыг бүрэн арилгах

Тав. Хадлангийн төлбөр хураамж

- 5.1 Байгалийн ургамал ашигласны төлбөрийг “Элбэг ургамал” гэсэн ангиллын дагуу 1 га хадлангийн талбайгаас бэлтгэх өвсний 5 хувийг орон нутгийн талбай дээрх ханшаар үнэлж тооцно
- 5.2 Байгалийн ургамал ашигласны нийт төлбөр..... төгрөгийг сумын төрийн сангийн тоот дансанд хадлан эхлэхийн өмнө тушаана

Зургаа. Гэрээг цуцлах ба бусад асуудлууд

- 6.1 Нөхөрлөл нь гэрээлсэн хадлангийн газраас өөр газарт хадсан, гэрээнд заасан хэмжээнээс илүү газар хадсан, бусдын өвөлжөө-хаваржаанд 500 метрээс дотогш хадлан хийсэн,

- байгаль орчинтой зүй бус харьцаж гарз хохирол учруулсан тохиолдолд гэрээг цуцалж, Зөрчлийн тухай хуулийн 8.1 дэх заалтын дагуу хуулийн этгээдийг 3 сая төгрөгөөр торгоно.
- 6.2 Хадлангийн талбайд ил задгай хог хаягдал үүсгэсэн тохиолдолд зөрчлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг үндэслэн хуулийн этгээдийг 300 мянган төгрөгөөр торгож зөрчлийг арилгуулна
- 6.3 Байгалийн ургамал ашигласны төлбөр төлөх, сумын аюулгүй фондод өвс нийлүүлэх үүргээ дараалсан 2 жил биелүүлээгүй тохиолдолд хадлангийн гэрээг цуцална
- 6.4 Гэрээ байгуулсан талуудын хооронд үүссэн маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцож чадаагүй бол шүүхийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 6.5 Нөхөрлөл гэрээнд заасан үүргээ зөрчиж, байгаль орчинд хохирол учруулсныг холбогдох мэргэжлийн байгууллагаас тогтоосон тохиолдолд гарсан хохирлыг нөхөрлөлийн гишүүдийн хөрөнгөөр бүрэн арилгуулах, нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

..... сумын Газрын даамал нөхөрлөлийн ахлагч
..... / /
Хаяг:	Хаяг:
Утас:	Утас:

Хавсралт 1. Хадлангийн бүлэг, БНХМН-ийн гишүүдийн мэдээлэл

№	Овог нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар	Гарын үсэг

БАТЛАВ СУМЫН ЗАСАГ ДАРГА

.....

ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны сарын __-ны өдөр

.....

Гэрээний дугаар: _____

Энэ гэрээг НЭГ ТАЛААС аймгийн сумын Засаг дарга (цаашид “Өмчлөгч” гэх), нөгөө талаас сумын Хавсралт 1-д дурдсан “.....” малчдын бүлэг, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, малчдын бүлэг (цаашид эзэмшигч гэх)-ийн гишүүд төсвийн болон төслийн хөрөнгөөр байгуулсан худгийг эзэмшин зохистой ашиглах, хамгаалах талаар харилцан тохиролцож, Иргэний хуулийн 189 дүгээр зүйл, 195 дугаар зүйлийн 1.2.3 дэх заалт, 196 дугаар зүйлийн 1.2 дэх заалт, 198 дугаар зүйл, 199 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 13.1.6, 22 дугаар зүйлийн 22.4, 22.6, дэх заалтууд, 23 дугаар зүйлийн 23.1, 24 дүгээр зүйлийн 24.1, 28 дугаар зүйлийн 8 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 2.1, 32 дугаар зүйлийн 32.3, 32.4, 32.6, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 49 дүгээр зүйл, 57 дугаар зүйл, 58 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1.3, 1.4, 1.5 Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын хамтарсан 2005 оны 101/189/194 тоот тушаалаар баталсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”, сумын Засаг даргын 20.... оны тоот захирамжийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Гэрээний зорилго

1. Энэхүү гэрээний зорилго нь:

- 1.2. газарт байрлах худгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын харилцааг зохицуулах
- 1.3. Худгийг тодорхой эзэнтэй болгож, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, эзэмшилтийг сайжруулан, байнгын ажиллагаатай байлгах, усны нөөц, худгийн орчны газрыг зохистой ашиглаж, хамгаалах, хүн ам, мал сүргийг усаар тогтмол хангахад оршино.

2. Өмчлөл

- 2.1. Усны тухай хуулийн дагуу усны баялаг нь төрийн өмчид байна. Энэхүү гэрээгээр зохицуулж байгаа харилцаа нь усны нөөцийн өмчлөлийг хөндөхгүйгээр гагцхүү усны нөөцийн зохистой ашиглалт, худгийн тоног төхөөрөмж, байшин барилгын эзэмшил, ашиглалтын харилцааг зохицуулна.
- 2.2. Худгийн байшин барилга, тоног төхөөрөмж нь орон нутгийн өмч байна.
- 2.3. Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч сумын Засаг дарга худгийн өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдсон харилцааг энэхүү гэрээ болон холбогдох хууль, журмын дагуу зохицуулах бүрэн эрхийг эдэлнэ.
- 2.4. Худгийг сэргээн засварлахад эзэмшигчийн зүгээс оруулсан тоног төхөөрөмж, байшин барилга нь эзэмшигчийн өмч байна.

3. Эзэмшлийн зориулалт

- 3.1. Худгийг мал услах /ундны усны, тариа ногоо услах гэх мэт/ хэрэгцээг хангах зориулалтаар эзэмшүүлэв.

3.2. Худгийн усыг байнгын хэрэглэгч нь эзэмшигч малчдын бүлэг, нөхөрлөлийн гишүүн өрхүүд байна.

4. Худгийн байршил

4.1. /худгийн нэр/ худаг нь/газрын нэр/-д
Уртраг.....Өргөрөг..... байрлана.

5. Худгийн үзүүлэлтүүд

5.1. Худаг нь доорх эд зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- a. Шахуурга /үзүүлэлтүүд/
- b. Цахилгаан үүсгүүр /үзүүлэлтүүд/
- c. Барилга, байгууламж
- d. Мал услах онгоц
- e. Бусад

6. Эзэмшүүлэх хугацаа

6.1. Таван жил

7. Худгийн усны төлбөр болон үйлчилгээний хөлс

7.1. Хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан услах зориулалтаар усыг үнэ төлбөргүй хэрэглэнэ. Төр, засгаас баримталж байгаа энэхүү бодлого өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд зохих өөрчлөлтийг оруулж болно.

7.2. Худгийн үйлчилгээний хөлс нь худгаас ус гаргах тоног төхөөрөмжийг ажиллуулах болон засварлах урсгал зардал, худгийн тоног төхөөрөмж болон худгийн барилгад их засвар хийх, сайжруулах зардал /элэгдлийн сан/, худаг хариуцагчийн цалин, худгийн усыг бохирдол, хөлдөлтөөс хамгаалах зардал, худгийн орчны газрыг талхагдал, бохирдлоос сэргийлэх арга хэмжээний зардлаас бүрдэнэ.

7.3. Худгийн үйлчилгээний хөлсийг ус хэрэглэгчид хариуцна.

8. Өмчлөгчийн эрх, үүрэг

8.1. Өмчлөгч доорх эрх эдэлнэ.

8.1.1. Эзэмшигчийн зүгээс худгийн усны нөөц, барилга, тоног төхөөрөмж, орчмын газрыг хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу зүй зохистой ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

8.2. Өмчлөгч доорх үүрэг хүлээнэ.

8.2.1. Худгийг зүй зохистой эзэмшиж, ашиглахтай холбоотой эзэмшигчийн эрх мэдэл, хүч бололцоо хүрэхгүй аливаа асуудлаар эзэмшигчид дэмжлэг туслалцаа үзүүлэх

8.2.2. Худаг эзэмшигчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэх

8.2.3. Худгийн ашиглалтын норм, нормативыг мөрдүүлэх;

8.2.4. Гэрээний хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих ажлыг багийн засаг дарга, байгаль хамгаалагчийн оролцоотойгоор зохион байгуулах

8.2.5. Хэрэгжилтийн үнэлгээгээр тогтоогдсон зөрчлийг арилгах асуудлыг БОХУБ-д хариуцуулж гүйцэтгүүлэх

8.2.6. Худгийн үйлчилгээний хөлсний талаар санал боловсруулахад эзэмшигчид шаардлагатай мэргэжлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах

8.2.7. Энэ гэрээний 9.2.11-д заасан үйлчилгээний хөлсний талаарх саналыг хянаж, ИТХ-аар батлуулж, мөрдүүлэх

9. Эзэмшигчийн эрх, үүрэг

9.1. Эзэмшигч доорх эрх эдэлнэ.

9.1.1. Худгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах

- 9.1.2. Худагт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр нэхэмжлэх
- 9.1.3. Гэрээ дууссан үед сунгуулах хүсэлтээ гаргах
- 9.1.4. Гишүүн бус өрх ус хэрэглэсэн тохиолдолд үйлчилгээний хөлс авах
 - 9.2. Эзэмшигч доорх үүрэг хүлээнэ.
 - 9.2.1. Энэхүү гэрээнд заасан үүргийг биелүүлэх
 - 9.2.2. Худгийн ашиглалт, засвар үйлчилгээг үйлчилгээний хөлсөөр хийх
 - 9.2.3. Худгийн орчмын газар, байгаль орчны хууль тогтоомжийн дагуу хамгаалах, бохирдол, талхагдлаас сэргийлэх арга хэмжээ авах
 - 9.2.4. Эзэмшигчийн хариуцлагагүйгээс худагт аливаа хохирол учирсан, орчмын газар талхлагдсан тохиолдолд өөрийн зардлаар нөхөн сэргээх арга хэмжээ авах
 - 9.2.5. Байгаль орчинд болон бусдын эзэмшил, ашиглалтын газарт хохирол учруулсан аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх
 - 9.2.6. Худгийн ойр орчим 200 метрт шинээр хашаа, саравч барихгүй байх;
 - 9.2.7. Худгийн ашиглалтын норм, нормативыг дагаж мөрдөх;
 - 9.2.8. Худгийн их засвар, шинэчлэлтийг хийх элэгдлийн сан байгуулах;
 - 9.2.9. Худгаас малаа услах, унд ахуйн ус хэрэглэх хуваарь гаргаж мөрдүүлэх
 - 9.2.10. Худгийг ажиллуулах хариуцагчийг томилох, түүнд үйлчилгээний хөлсийг хураах, худаг ажиллуулахтай холбоотой зардлыг дундын сангаас авах эрх олгох
 - 9.2.11. Худгийн үйлчилгээний хөлсийг энэхүү гэрээний 7.2-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд хангалттай хэмжээнд тогтоож, зөвшилцөн батлуулахаар Засаг даргад мэдүүлэх
 - 9.2.12. Худгийн үйлчилгээний хөлсийг гишүүн өрхүүдийн малын болон ундны усны хэрэглээтэй харгалзуулан ногдуулж, хураах
 - 9.2.13. Хураасан үйлчилгээний хөлсийг худаг эзэмшигч малчдын бүлэг, нөхөрлөлийн дундын сангийн дансанд байршуулан энэхүү гэрээний 7.2-д заасан арга хэмжээнд зарцуулах

10. Гэрээг дүгнэх

- 10.1. Засаг даргын захирамжийг үндэслэн худаг эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх ажлыг сумын ХАА-н тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, БОХУБ, байгаль хамгаалагч хариуцна.

11. Эзэмших эрхийг цуцлах, дуусгавар болох

- 11.1. Худгийг эзэмших эрх дараах тохиолдолд дуусгавар болно.
 - 11.1.1. Эзэмших гэрээт хугацаа дууссан бөгөөд эзэмшигчийн зүгээс сунгуулах хүсэлт гаргаагүй
 - 11.1.2. Эзэмшигч гэрээг цуцлах хүсэлт гаргасан
 - 11.2. Өмчлөгч доорх тохиолдолд эзэмшигчийн худаг эзэмших эрхийг хүчингүй болгоно. Үүнд:
 - 11.2.1. Эзэмшигч зохих хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ 2 жил дараалан биелүүлээгүй
 - 11.2.2. Худгийг хүний эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын эсрэг ашигласан болох нь тогтоогдсон

12. Хариуцлага

- 12.1. Эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан үндэслэлээр дараах хариуцлага хүлээнэ. Үүнд:

Зөрчлийн тухай хуулийн:

- 1.3 дахь зүйл заалт- Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
- 1.4 дэх зүйл заалт- Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй;
- 1.5 дах зүйл заалт - Усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 3.дах зүйл заалт - Усны эх, undаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 8.дах зүйл заалт - Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрүүгийн хуулийн:

24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах

- 1.дэх заалт -Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

13. Худгийн ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх

13.1.Худгийн ашиглалтын талаарх маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

13.2.Талууд тохиролцож чадахгүй бол дээд шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

14. Хориглох зүйл

Монгол улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалын А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм” -д заасны дагуу худгийн эрүүл ахуйн хориглолтын бүсийг 50 метр, хязгаарлалтын бүсийг 200 метрээр тус тус тогтоосон байна.

14.1.А. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- 14.1.1.Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;
- 14.1.2.Ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах;
- 14.1.3.Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;
- 14.1.4.Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;
- 14.1.5.Судалгаа шинжилгээ, унд ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
- 14.1.6.Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;

14.1.7.Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;

14.1.8.Машин техник угаах;

14.1.9.Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;

14.1.10.Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;

14.1.11.Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох;

Б. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөхөөс гадна дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:

14.1.12.Гаднын хүн орох;

14.1.13.Авто тээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах;

14.1.14.Мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих;

15. Бусад

15.1.Талуудын төлөөлөл гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэхүү гэрээг хүчин төгөлдөр болсонд тооцно.

15.2.Гэрээнд хавсаргасан нэр бүхий баримт бичгүүд түүний салшгүй хэсэг мөн.

15.3.Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

15.4.Энэхүү гэрээг 2 эх хувь үйлдэж, 202.. оны ___-р сарын ___-ны өдөр гарын үсэг зурав. Гэрээний нэг хувийг талуудад албан хэрэгцээнд зориулан хадгалуулав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Өмчлөгчийг төлөөлж:

..... аймгийн.....сумын Хөдөө
Аж Ахуйн Тасгийн бэлчээр хариуцсан
мэргэжилтэн

..... овогтой

Гарын үсэг _____

Харилцах утас:

Эзэмшигчийг төлөөлж:

“.....” малчдын
бүлэг/БНХМН-ийн ахлагч

..... овогтой.....

Гарын үсэг _____

Регистр №

Харилцах утас:

Хавсралт 1. Худаг эзэмшигч малчдын бүлэг, БНХМН-ийн гишүүн өрхийн мэдээлэл

№	Овог нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар	Гарын үсэг

БАТЛАВ СУМЫН ЗАСАГ ДАРГА

ОЙН САНГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

20... оны . . сар ...өдөр

Дугаар

.....

Нэг.Ерөнхий зүйл

1.1 Гэрээний зорилго нь ойн санг аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой нөхцөл, болзол, хугацаатайгаар эзэмшүүлж, ойн нөөцийг өөриймсөг сэтгэлгээгээр хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулахад оршино.

1.2.Ойн тухайн хуулийн 3 дугаар зүйлийн 2 дугаар хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 2 дугаар хэсгийн 5 дугаар хэсэг, Засгийн газрын 1998 оны 125 дугаар тогтоолоор баталсан "Ойн санг гэрээгээр эзэмшүүлэх тухай журам"-д заасны дагуу аймгийн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 оны дугаар сарын ____ -ны өдрийн __ дугаар шийдвэр, Засаг даргын 20.. оны __ дугаар сарын ____ -ны өдрийн _____ дугаар захирамжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Ойн санг эзэмшүүлсэн байдал

_____ аймгийн _____ сумын газрын ойн сангаас _____ га талбайг _____ аймгийн _____ сум _____ аж ахуйн нэгж, нөхөрлөл, байгууллагад _____ жилийн хугацаагаар эзэмшүүлэв. Эзэмшлийн ойн сангийн нийт нөөц нь ____ шоо метр, үүнээс ашиглалтын ойн нөөц ____ шоо метр, хамгаалалтын бүсийн ойн нөөц _____ шоо метр.

Энэхүү гэрээгээр эзэмшүүлсэн ойн сангийн таксацын үзүүлэлт, эзэмшлийн ойн сангийн модны талбай, нөөц, ойн сангийн талбайн төрөл, ойн сангийн менежментийн төлөвлөгөөг 1, 2, 3, 4 дүгээр хавсралтаар тодорхойлов. Эдгээр хавсралт нь гэрээний салшгүй хэсэг мөн.

Гурав.Сумын Засаг даргын Тамгын газрын хүлээх үүрэг

Сумын Засаг даргын Тамгын газар дараах үүрэг хүлээнэ:

- 3.1 Ойн сан эзэмшигчийн хууль тогтоомж хэрэгжүүлэлт болон гэрээ, менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцож зөрчлийг арилгах арга хэмжээ авч байх.
- 3.2 Улс орны эрх ашигтай холбогдсон онцгой арга хэмжээ авахаас бусад тохиолдолд ойн сан эзэмшигчийг эзэмшлийн ойн сангийн нутаг дэвсгэрт Ойн тухай хууль, бусад холбогдох заавар, журмын дагуу түлшний болон хэрэгцээний мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, мод үржүүлгийн газар байгуулах, ойжуулалт хийх, хадлан авах гэх мэт ажлуудыг хэвийн явуулах нөхцөл, бололцоогоор хангах;
- 3.3 Ойн сан эзэмшигчийн үйл ажиллагаанд бух талын дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- 3.4 Эзэмшлийн ойн санд түймэр, хөнөөлт шавж, өвчин зэрэг гамшгийн хор уршгийг арилгахад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, санхүүгийн туслалцаа үзүүлэх;

Дөрөв. Ойн санг эзэмшигчийн эрх, үүрэг

Ойн санг эзэмшигч нь Ойн санг гэрээгээр эзэмших журмын 20 дугаар зүйлд заасан эрхийг эдлэхийн зэрэгцээ дараах үүргийг хүлээнэ.

- 4.1.Ойн тухай болон байгаль орчныг хамгаалахтай холбогдсон бусад хууль тогтоомж, гэрээний үүргээ чандлан сахих;
- 4.2.Эзэмшлийн ойн сангийн нөөц, түүний өөрчлөлтийн тухай мэдээллийг сумын Засаг дарга, бусад байгууллага; албан тушаалтанд тогтоосон хугацаанд нь гарган өгөх;
- 4.3.Эзэмшлийн ойн санг түймэр, хөнөөлт шавж өвчнөөс сэргийлэх ажлыг өөрсдийн хүчээр зохион байгуулж, түймэр гарсан үед шуурхай мэдээлэх, унтраах арга хэмжээ авах;

- 4.4.Эзэмшлийн ойн санд өөрийн хөрөнгөөр хайгуул судалгааны ажлыг мэргэжлийн аж ахуйн нэгжээр хийлгэж, энэ үндсэн дээр менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авах;
- 4.5.Модны үр, тарьц, суулгацын байнгын нөөцийг бий болгох, гэрээнд зааснаар ойжуулалтын ажлыг гүйцэтгэж, урьд жилүүдэд тарьсан таримал ойг ойн санд шилжүүлэн өгөх;
- 4.6.Эзэмшлийн ойн сангийн газар, ургамал, амьтны аймаг, бусад баялгийг хамгаалах арга хэмжээ авах;
- 4.7.Эзэмшлийн ойн сангаас хууль бусаар мод түлээ бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах, ан гөрөө хийх явдалтай тэмцэж, гарсан зөрчлийг тухай бүр холбогдох байгууллагад мэдээлж арилгах арга хэмжээ авах;
- 4.8.Хуульд заасан хугацаанд ой зохион байгуулалтыг хийлгэж байх;
- 4.9. Эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах;
- 4.10.Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;
- 4.11. Ойн нөхөрлөлийн дундын сан байгуулах.
- 4.12.Гэрээ, менежментийн төлөвлөгөөний биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор гарган сумын Засаг даргад танилцуулж, үр дүнг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байх.

Тав. Бусад зүйл

- 5.1.Тухайн үед гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ;
- 5.2.Эрүүгийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай хууль, Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хууль, бусад эрх зүйн актууд болон энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагад зохих хариуцлага ногдуулна;
- 5.3.Тухайн сумын Засаг дарга болон байгаль орчны хяналтын байцаагчийн саналыг үндэслэн байгаль орчны хяналтын байцаагч, байгаль хамгаалагчдын тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын ойн санг эзэмших гэрээг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр цуцална.
- 5.4.Аж ахуйн нэгж, байгууллагын ойн санг эзэмших гэрээ нотариатаар батлуулсны дараа хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

.....сумын ЗДТГ-ыг	ААН, ойн нөхөрлөлийг	Танилцаж зөвшөөрсөн: Байгаль
Төлөөлж:	Төлөөлж:	орчны хяналтын Улсын байцаагч
Албан тушаал:	Албан тушаал:	Овог нэр:
_____	_____	_____
Овог нэр	Овог нэр	Гарын үсэг
Гарын үсэг	Гарын үсэг	_____
Харилцах утас:	Харилцах утас:	_____

Хавсралт 1. Ойн нөхөрлөл, БНХМН-ийн гишүүдийн мэдээлэл

№	Овог нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар	Гарын үсэг

Хавсралт 2.4 А Нөөц ашиглалтын шинэчилсэн гэрээ байгуулсан байдлыг нэг нэг сумын жишээн дээр

Хавсралт 2.4.1 Бэлчээр ашиглуулах гэрээ Үенч сумыг жишээн дээр

БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2022 оны 02 сарын 22 ны өдөр

Гэрээний дугаар: _____

НЭГ ТАЛААС Толг аймгийн Үенч сумын Засаг дарга Т.Түвшин
 (цаашид "Өмчлөгч" гэх) НӨГӨБ ТАЛААС Толг аймгийн Үенч сумын
 малчдын Бүлэг, нөхөрлөл Толг (цаашид "Ашиглагч" гэх)-д бэлчээр
 гэрээгээр ашиглуулах, хамгаалах талаар хоригцон тохиролцож, Монгол улсын Иргэний
 хуулийн 189.1, 189.5, 481.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын
 тухай хуулийн 59.1.17, Газрын тухай хуулийн 45.1, 52.2, 52.3, Байгаль орчныг хамгаалах
 тухай хуулийн 4.1.3, 4.2.3, 17.2.2, 19.7, 26.3, 27.1, 27.7, 40.1.1, 50.4, 50.5, 52.1, 54.1 Тусгай
 хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17.2, 21.2, 21.2, 20.2, 30.10, 33.1, Усны тухай
 хуулийн 13 дугаар зүйлийн 22.6, 23.1, Малын генетикийн нөөцийн тухай хуулийн 5.4, 18 дугаар
 зүйлийн 18.3, 18.4 дэх заалт, Малын тоо толгойн янбан татварын тухай хуулийн 7.1,
 Төсвийн тухай хуулийн 60.2.8 дахь заалт, сумын БТХ-ын 202 оны тоот тогтоол, Засаг
 даргын 202 оны тоот захирамжийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү гэрээгээр малчдын бүлэг, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд
 байгалийн бэлчээрийг ашиглуулах, хамгаалах, түүнчлэн гэрээний хэрэгцээт, үүргийн
 биелэлтэд хяналт тавих, дүгнэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Хоёр. Бэлчээр ашиглалтын зориулалт, хэмжээ, байршил

2.1 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийг зөвхөн мал аж ахуй эрхлэх зориулалтаар
 ашиглана.

2.2 Ашиглагчаас гэрээгээр ашиглуулах бэлчээрийн талбайг 4375 га-аар тогтоов.

2.3 Бэлчээрийн зуны дээд ургацыг олон жилийн дунджаар ц/га.

2.4 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн давацг хонин толгойд шилжүүлснээр дараах
 жижиг үзүүлэлтээр тогтоов. Үүнд

2.4.1.1 Өвөлжөөний бэлчээр	га, даац	хонин толгой
2.4.1.2 Хаваржааны бэлчээр	га, даац	хонин толгой
2.4.1.3 Өвөлжөө-хаваржааны бэлчээр	га, даац	хонин толгой

2.5 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн давацн тооцоонд өвсөн тэжээлт зэрлэг хөхтөн
 амьтдыг оруулж тооцно.

2.6 Бүлгийн гишүүдийн мэдээлэл (Хавсралт 1), бүлгийн гишүүн өрхийн малын тооны
 мэдээлэл (Хавсралт 2), гэрээт бэлчээрийн байршил, хэмжээ, улирлын ашиглалтын зураг
 (Хавсралт 3), гэрээт бэлчээрийн төлөв байдлын суурь мэдээлэл (Хавсралт 4), бэлчээрийн
 давацд нийцүүлэх үүднээс малын тоог цөөлөх ... жилийн төлөвлөгөө (Хавсралт 5)-г тус тус
 хавсаргаа.

2.7 Гэрээний хүчинтэй хугацаа сунгалтгүйгээр 15 /арван тав/ жил байна.

Гурав. Өмчлөгчийн эрх, үүрэг

3.1 Өмчлөгч нь дараах эрх, үүрэгтэй.

3.1.1. Гэрээлсэн бэлчээрт эрх бүхий этгээдийн тогтоосон цэгт бэлчээрийн ургац,
 даацыг жил бүр тогтоох.

3.1.2. Сүүлийн 5 жилийн дундаж ургацыг үндэслэн байвал зохих малын тооны дээд
 хязгаарыг шинэчлэн тооцож ашиглагчид хүргүүлэх.

3.1.2. Сүүлийн 5 жилийн дундаж ургацыг үндэслэн байвал зохих малын тооны дээд хязгаарыг шинэчлэн тооцож ашиглагчид хүргүүлэх

3.1.3. Байгаль-цаг уурын онцгой байдал тохиолдох үед ашиглагчдын бэлчээрийн даацад тохируулан бусдын малыг оруулах, эсхүл гадагш нүүлгэх, өөр суманд отроор ороход тухайн сумын Засаг даргатай тохиролцож, саадгүй зохион байгуулах;

3.1.4. Цаг агаарын хүндрэлтэй үед сум дотроо нүүдэллэх, нутаглах боломжтой газар, байршил, багтаамжийн мэдээллээр хангах;

3.1.5. Ашиглагчдын гэрээт бэлчээрт 3.1.3-д заасан зохих зөвшөөрөлгүйгээр мал оруулсан гаднын малчдыг нүүлгэх арга хэмжээ авах;

3.1.6. Бэлчээрт хөрөнгө оруулалт (худаг гаргах, хөв байгуулах, уст цэг тохижуулах, малын хашаа, хороо барих, засаж сэлбэх гэх мэт) хийх талаар ашиглагчтай зөвшилцөн хэрэгжүүлэх;

3.1.7. Гэрээт бэлчээрийн даацыг хэтрүүлсэн, төлөв байдлыг доройтуулсан, хохирол учруулсан тохиолдолд буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх, арилгуулах талаар шийдвэр гаргах, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.8. Гэрээт бэлчээрт буюу ойролцоо байршсан зэрлэг амьтад ундаалдаг булаг, шанд, баян бүрд болон хужир мараа бүхий газрыг тухайн амьтдын төллөлт, шилжилт, ундаалдаг үед айл, малаас чөлөөлүүлэх арга хэмжээ авах

3.2 Бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилт, үйл ажиллагааны цогц төлөвлөгөө ба менежментийн төлөвлөгөөний биелэлтийг энэхүү гэрээний 5-д заасны дагуу жил бүр дүгнэх, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээг авах;

3.3 Мал борлуулсны урамшуулалд олгох эх үүсвэр бүрдүүлэх, эх үүсвэрээс мөнгөн урамшуулал олгох;

3.4 Гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн тухай болон талуудаас цаашид авах арга хэмжээний талаарх мэдэгдлийг Ашиглагчид бичгээр албан ёсоор хүргүүлэх

3.5 Бэлчээр ашиглуулах гэрээ дүгнэсэн дүнг БОХУБ-д хүргүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авхуулах

Дөрөв. Ашиглагчийн эрх, үүрэг

4.1. Бэлчээр ашиглагч нь дараах эрх, үүрэгтэй.

4.1.1. Гэрээлсэн бэлчээрийг мал аж ахуй эрхлэх зориулалтаар зохистой ашиглах;

4.1.2. Гэрээт бэлчээрт мал оруулах, нутаглах зэргээр дур мэдэн ашигласан, хашаа, хороо барьсан зэрэг бүлгийн гишүүн бус этгээдийн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг төлүүлэх, арилгуулахыг талаар өмчлөгчөөс шаардах;

4.1.3. Гэрээлсэн бэлчээрт байлгавал зохих малын тоо (хонин толгойд шилжүүлснээр)-г энэхүү гэрээний 2.4-д заасан даацад нийцүүлэх тухайн жилийн зорилт (урьд оноос 5% бууруулах)-ыг биелүүлэх, төлөв байдал, бүтээмжийг нь суурь түвшин (хавсралт 5)-ээс нь доройтуулахгүйгээр зохистой ашиглах;

4.1.4. Бусад ашиглагчдын бэлчээрийн хил заагийг хүндэтгэн өөрсдийн малаа оруулахгүй, нүүж нутаглахгүй байх;

4.1.5. Ган, зуд зэрэг байгалийн эрсдэл тохиолдсон үед гэрээлсэн бэлчээрийн даацыг хэтрүүлэлгүй бусдын малыг оруулах

4.1.6. Тогтоосон журмын дагуу дайран өнгөрөхөөс бусад тохиолдолд гэрээлсэн бэлчээрт мал дур мэдэн оруулахгүй байхыг бусдаас шаардах;

4.1.7. Энэхүү гэрээний 3.1.8-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.1.8. Энэхүү гэрээний 3.5-д заасны дагуу мал борлуулсны урамшууллыг зохих эх үүсвэрээс авах;

4.1.9. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг сунгуулах, цуцлах, дуусгавар болгох, шинэчилж байгуулах талаар Өмчлүүлэгчид хүсэлт гаргах.

Тав. Гэрээ байгуулах, дүгнэх

5.1 Газрын тухай хуулийн 23.4.2 дахь заалт болон сумын Засаг даргын захирамжийг үндэслэн бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах арга хэмжээг газрын даамал хариуцан гүйцэтгэнэ.

5.2 Бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах болон дүгнэхэд албан тушаалын гүйцэтгэх чиг үүргийнх нь дагуу Газрын даамал, Хөдөө аж ахуйн тасаг (ХААТ)-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтнийг ажиллуулна.

5.3 Бэлчээр ашиглуулах гэрээг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан дүгнэнэ.

5.5 Бэлчээр ашиглуулах гэрээний биелэлт, үүргийн гүйцэтгэлийг Газрын даамал ХААТ-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран нэгтгэсэн тайланг Засаг даргад хүргүүлнэ.

Зургаа. Бэлчээр ашиглуулах гэрээг сунгах, цуцлах, дуусгавар болгох

6.1 Дараах тохиолдолд бэлчээр ашиглуулах гэрээг сунгана.

6.1.1 Гэрээний хүчинтэй хугацаа дууссан бөгөөд аль нэг тал, эсхүл ашиглагч дангаар гэрээ сунгах хүсэлтээ албан ёсоор гаргасан,

6.1.2 Гэрээ сунгах хүсэлт гаргагч тал энэ тухай гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө бичгээр ирүүлсэн

6.1.3 Гэрээ сунгах асуудлаар Өмчлөгч эцсийн шийдвэрийг гаргана.

6.2 Бэлчээр ашиглуулах гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу болон гэрээнд заасан хугацаанаас нь өмнө дараах үндэслэлээр цуцалж болно.

6.2.1 Бэлчээр ашиглагч гэрээг цуцлах хүсэлт гаргасан.

6.2.2 Бэлчээрийг хүний эрүүл мэнд, байгаль орчин, нөөцийн аюулгүй байдалд сөргөөр ашигласан нь тогтоогдсон.

6.2.3 Бэлчээрийн төлөв байдлыг байгалийн аясаар нөхөн сэргэх боломжгүй болтол нь доройтуулсан нь нотлогдсон.

6.2.4 Гэрээнд заасан бэлчээрийг зориулалтын дагуу ашиглаагүй, худаг, ил ус, хужир мараа зэрэг дагалдах нөөцийг дахин ашиглах боломжгүйгээр эвдэж гэмтээсэн, сүйтгэсэн.

6.3 Энэхүү гэрээнд зааснаас бусад тохиолдолд Өмчлөгч өөрийн санаачилгаар энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах, дуусгавар болгохыг хориглоно.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

7.1. Урьдчилан мэдээлэх, мэдэх боломжгүй зуд, ган, үер зэрэг байгалийн аюултай үзэгдэл, түймэр, мал амьтны гоц халдварт өвчний тархалт, эдгээртэй холбоотой хорио цээр, нийтийн дайчилгааны улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээнд тусгасан нөхцөлийн талаар харилцан үүрэг хүлээхгүй.

Найм. Хориглох зүйл

8.1. Байгаль орчинд хохирол учруулах аливаа үйл ажиллагаа явуулах;

8.2. Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх зориулалтаар гэрээгээр олгогдсон бэлчээрийг бусдын мал бэлчээх, дайран өнгөрөхөд саадтайгаар хаших;

8.3. Хүн, малын усанд зориулж худаг гаргах, сэг зэмийг зөвшөөрсөн цэгт булахаас бусад зорилгоор газрын хөрсийг хөндөх;

8.4. Бэлчээр, түүний хөрс, ургамлын нөмрөгт сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулах;

Ес. Хариуцлага

9.1. Талууд, аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Арав. Талуудын хооронд үүсэх маргааныг шийдвэрлэх

10.1. Бэлчээр ашиглалт, хамгаалалтын талаарх маргааныг харилцан зөвшилцөх журмаар шийдвэрлэнэ. Эс тохиролцвоос Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

Арван нэг. Бусад

11.1. Гэрээ байгуулах талууд, эсхүл тэдгээрийн төлөөлөл гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэхүү гэрээг хүчин төгөлдөр болсонд тооцно.

11.2. Гэрээнд хавсаргасан нэр бүхий баримт бичгүүд түүний салшгүй хэсэг мөн.


11.3. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

Өмчлөгчийг төлөөлж:

Ашиглагчийг төлөөлж:

Сумын Газрын даамал

Малдын Бүлэг, нөхөрлөлийн ахлагч


Товог нэрт

Д. Зүдэнгэлүүн
Товог нэрт

Гарын үсэг

Гарын үсэг

Регистр: *11К 81023401*
Харилцах утас: *99804091*

Регистр: *11К 6302233*
Харилцах утас: *9920 9827, 98129805*

ХУДАГ ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 09 сарын 14-ны өдөр

Сэтг

Гэрээний дугаар: 01

Энэ гэрээг НЭГ ТАЛААС *Б.О.О* аймгийн *Эрдэнэбүрэн* сумын Засаг дарга *У.Наранболор* (цаашид "Өмчлөгч" гэх), нөгөө талаас *Эрдэнэбүрэн* сумын Хавсралт 1-д дурдсан "*Нэг худаг*" малчдын бүлэг, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, малчдын бүлэг (цаашид эзэмшигч гэх)-ийн гишүүд төсвийн болон төслийн хөрөнгөөр байгуулсан худгийг эзэмшин зохистой ашиглах, хамгаалах талаар харилцан тохиролцож, Иргэний хуулийн 189 дүгээр зүйл, 195 дугаар зүйлийн 1.2.3 дэх заалт, 196 дугаар зүйлийн 1.2 дэх заалт, 198 дугаар зүйл, 199 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 13.1.6, 22 дугаар зүйлийн 22.4, 22.6, дэх заалтууд, 23 дугаар зүйлийн 23.1, 24 дүгээр зүйлийн 24.1, 28 дугаар зүйлийн 8 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 2.1, 32 дугаар зүйлийн 32.3, 32.4, 32.6, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 49 дүгээр зүйл, 57 дугаар зүйл, 58 дугаар зүйл, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын хамтарсан 2005 оны 101/189/194 тоот тушаалаар баталсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам", сумын Засаг даргын 2022 онытоот захирамжийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Гэрээний зорилго

1. Энэхүү гэрээний зорилго нь:

- 1.1. *Нэг худаг* газарт байрлах худгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын харилцааг зохицуулах
- 1.2. Худгийг тодорхой эзэнтэй болгож, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, эзэмшилтийг сайжруулан, байнгын ажиллагаатай байлгах, усны нөөц, худгийн орчны газрыг зохистой ашиглаж, хамгаалах, хүн ам, мал сүргийг усаар тогтмол хангахад оршино.

2. Өмчлөл

- 2.1. Усны тухай хуулийн дагуу усны баялаг нь төрийн өмчид байна. Энэхүү гэрээгээр зохицуулж байгаа харилцаа нь усны нөөцийн өмчлөлийг хөндөхгүйгээр гагцхүү усны нөөцийн зохистой ашиглалт, худгийн тоног төхөөрөмж, байшин барилгын эзэмшил, ашиглалтын харилцааг зохицуулна.
- 2.2. Худгийн байшин барилга, тоног төхөөрөмж нь орон нутгийн өмч байна.
- 2.3. Төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч сумын Засаг дарга худгийн өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдсон харилцааг энэхүү гэрээ болон холбогдох хууль, журмын дагуу зохицуулах бүрэн эрхийг эдэлнэ.
- 2.4. Худгийг сэргээн засварлахад эзэмшигчийн зүгээс оруулсан тоног төхөөрөмж, байшин барилга нь эзэмшигчийн өмч байна.

3. Эзэмшлийн зориулалт

- 3.1. Худгийг мал услах /ундны усны, тариа ногоо услах гэх мэт/ хэрэгцээг хангах зориулалтаар эзэмшүүлэв.
- 3.2. Худгийн усыг байнгын хэрэглэгч нь эзэмшигч малчдын бүлэг, нөхөрлөлийн гишүүн өрхүүд байна.

4. Худгийн байршил

- 4.1. *Нэг худаг* /худгийн нэр/ худаг нь *Нэг худаг* /газрын нэр/-д

Уртраг $N 48^{\circ} 15' 33.4$ Өргөрөг $E 091^{\circ} 23' 88.5$ байрлана.

5. Худгийн үзүүлэлтүүд

- 5.1. Худаг нь доорх эд зүйлсээс бүрдэнэ. Үүнд:
- a. Шахуурга /үзүүлэлтүүд/
 - b. Цахилгаан үүсгүүр /үзүүлэлтүүд/
 - c. Барилга, байгууламж
 - d. Мал услах онгоц
 - e. Бусад

6. Эзэмшүүлэх хугацаа

- 6.1. Таван жил

7. Худгийн усны төлбөр болон үйлчилгээний хөлс

- 7.1. Хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан услах зориулалтаар усыг үнэ төлбөргүй хэрэглэнэ. Төр, засгаас баримталж байгаа энэхүү бодлого өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд зохих өөрчлөлтийг оруулж болно.
- 7.2. Худгийн үйлчилгээний хөлс нь худгаас ус гаргах тоног төхөөрөмжийг ажиллуулах болон засварлах урсгал зардал, худгийн тоног төхөөрөмж болон худгийн барилгад их засвар хийх, сайжруулах зардал /элэгдлийн сан/, худаг хариуцагчийн цалин, худгийн усыг бохирдол, хөлдөлтөөс хамгаалах зардал, худгийн орчны газрыг талхагдал, бохирдлоос сэргийлэх арга хэмжээний зардлаас бүрдэнэ.
- 7.3. Худгийн үйлчилгээний хөлсийг ус хэрэглэгчид хариуцна.

8. Өмчлөгчийн эрх, үүрэг

- 8.1. Өмчлөгч доорх эрх эдэлнэ.

8.1.1. Эзэмшигчийн зүгээс худгийн усны нөөц, барилга, тоног төхөөрөмж, орчмын газрыг хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу зүй зохистой ашиглаж байгаа эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

- 8.2. Өмчлөгч доорх үүрэг хүлээнэ.

8.2.1. Худгийг зүй зохистой эзэмшиж, ашиглахтай холбоотой эзэмшигчийн эрх мэдэл, хүч бололцоо хүрэхгүй аливаа асуудлаар эзэмшигчид дэмжлэг туслалцаа үзүүлэх

8.2.2. Худаг эзэмшигчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэх

8.2.3. Худгийн ашиглалтын норм, нормативыг мөрдүүлэх;

8.2.4. Гэрээний хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих ажлыг багийн засаг дарга, байгаль хамгаалагчийн оролцоотойгоор зохион байгуулах

8.2.5. Хэрэгжилтийн үнэлгээгээр тогтоогдсон зөрчлийг арилгах асуудлыг БОХУБ-д хариуцуулж гүйцэтгүүлэх

8.2.6. Худгийн үйлчилгээний хөлсний талаар санал боловсруулахад эзэмшигчид шаардлагатай мэргэжлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах

8.2.7. Энэ гэрээний 9.2.11-д заасан үйлчилгээний хөлсийн талаарх саналыг хянаж, ИТХ-аар батлуулж, мөрдүүлэх

9. Эзэмшигчийн эрх, үүрэг

- 9.1. Эзэмшигч доорх эрх эдэлнэ.

9.1.1. Худгийг энэхүү гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглах

9.1.2. Худагт учруулсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэхээр нэхэмжлэх

9.1.3. Гэрээ дууссан үед сунгуулах хүсэлтээ гаргах

9.1.4. Гишүүн бус өрх ус хэрэглэсэн тохиолдолд үйлчилгээний хөлс авах

9.2. Эзэмшигч доорх үүрэг хүлээнэ.

- 9.2.1. Энэхүү гэрээнд заасан үүргийг биелүүлэх
- 9.2.2. Худгийн ашиглалт, засвар үйлчилгээг үйлчилгээний хөлсөөр хийх
- 9.2.3. Худгийн орчмын газар, байгаль орчны хууль тогтоомжийн дагуу хамгаалах, бохирдол, талхагдлаас сэргийлэх арга хэмжээ авах
- 9.2.4. Эзэмшигчийн хариуцлагагүйгээс худагт аливаа хохирол учирсан, орчмын газар талхлагдсан тохиолдолд өөрийн зардлаар нөхөн сэргээх арга хэмжээ авах
- 9.2.5. Байгаль орчинд болон бусдын эзэмшил, ашиглалтын газарт хохирол учруулсан аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх
- 9.2.6. Худгийн ойр орчим 200 метрт шинээр хашаа, саравч барихгүй байх;
- 9.2.7. Худгийн ашиглалтын норм, нормативыг дагаж мөрдөх;
- 9.2.8. Худгийн их засвар, шинэчлэлтийг хийх элэгдлийн сан байгуулах;
- 9.2.9. Худгаас малаа услах, унд ахуйн ус хэрэглэх хуваарь гаргаж мөрдүүлэх
- 9.2.10. Худгийг ажиллуулах хариуцагчийг томилох, түүнд үйлчилгээний хөлсийг хураах, худаг ажиллуулахтай холбоотой зардлыг дундын сангаас авах эрх олгох
- 9.2.11. Худгийн үйлчилгээний хөлсийг энэхүү гэрээний 7.2-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхэд хангалттай хэмжээнд тогтоож, зөвшилцөн батлуулахаар Засаг даргад мэдүүлэх
- 9.2.12. Худгийн үйлчилгээний хөлсийг гишүүн өрхүүдийн малын болон ундны усны хэрэглээтэй харгалзуулан ногдуулж, хураах
- 9.2.13. Хураасан үйлчилгээний хөлсийг худаг эзэмшигч малчдын бүлэг, нөхөрлөлийн дундын сангийн дансанд байршуулан энэхүү гэрээний 7.2-д заасан арга хэмжээнд зарцуулах

10. Гэрээг дүгнэх

- 10.1. Засаг даргын захирамжийг үндэслэн худаг эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх ажлыг сумын ХАА-н тасгийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, БОХУБ, байгаль хамгаалагч хариуцна.

11. Эзэмших эрхийг цуцлах, дуусгавар болох

- 11.1. Худгийг эзэмших эрх дараах тохиолдолд дуусгавар болно.
 - 11.1.1. Эзэмших гэрээт хугацаа дууссан бөгөөд эзэмшигчийн зүгээс сунгуулах хүсэлт гаргаагүй
 - 11.1.2. Эзэмшигч гэрээг цуцлах хүсэлт гаргасан
- 11.2. Өмчлөгч доорх тохиолдолд эзэмшигчийн худаг эзэмших эрхийг хүчингүй болгоно. Үүнд:
 - 11.2.1. Эзэмшигч зохих хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ 2 жил дараалан биелүүлээгүй
 - 11.2.2. Худгийг хүний эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын эсрэг ашигласан болох нь тогтоогдсон

12. Хариуцлага

- 12.1. Эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан үндэслэлээр дараах хариуцлага хүлээнэ. Үүнд:

Зөрчлийн тухай хуулийн:

- 1.3 дахь зүйл заалт- Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
- 1.4 дэх зүйл заалт- Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй;
- 1.5 дах зүйл заалт - Усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 3.дах зүйл заалт - Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 8.дах зүйл заалт - Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрүүгийн хуулийн:

24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах

- 1.дэх заалт -Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг агаар, газар, газрын хэвлий, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

13. Худгийн ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх

- 13.1. Худгийн ашиглалтын талаарх маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.
- 13.2. Талууд тохиролцож чадахгүй бол дээд шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

14. Хориглох зүйл

Монгол улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалын А-230/127 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм” -д заасны дагуу худгийн эрүүл ахуйн хориглолтын бүсийг 50 метр, хязгаарлалтын бүсийг 200 метрээр тус тус тогтоосон байна.

- 14.1. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын ба хязгаарлалтын бүсэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:
 - 14.1.1.Газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох;
 - 14.1.2.Ашиглалтаас гарсан цооногийг техникийн болон бусад зорилгоор нөөцөд байлгах;
 - 14.1.3.Цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах;
 - 14.1.4.Уст үеийн дээд талтай залгаа үеийн чулуулагт нөлөөлөх аливаа ажиллагаа явуулах;

- 14.1.5. Судалгаа шинжилгээ, унд ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;
- 14.1.6. Бүх төрлийн бордоо, пестицид хэрэглэх;
- 14.1.7. Газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис, түүнийг агуулсан ашигт малтмал хадгалах, агуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байрлуулах;
- 14.1.8. Машин техник угаах;
- 14.1.9. Мал амьтны гаралтай түүхий эд боловсруулах, хадгалах;
- 14.1.10. Орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барьж ашиглах;
- 14.1.11. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох;
- 14.2. Худаг уст цэгийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөхөөс гадна дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:
 - 14.2.1. Гаднын хүн орох;
 - 14.2.2. Авто тээврийн болон зөөврийн бусад хэрэгсэл байрлуулах;
 - 14.2.3. Мал бэлчээх, мал аж ахуй болон туслах аж ахуй эрхлэх, ногоо тарих;

15. Бусад

- 15.1. Талуудын төлөөлөл гарын үсэг зурсан өдрөөс эхлэн энэхүү гэрээг хүчин төгөлдөр болсонд тооцно.
- 15.2. Гэрээнд хавсаргасан нэр бүхий баримт бичгүүд түүний салшгүй хэсэг мөн.
- 15.3. Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 15.4. Энэхүү гэрээг 2 эх хувь үйлдэж, 2022 оны 09-р сарын 12-ны өдөр гарын үсэг зурав. Гэрээний нэг хувийг албан хэрэгцээнд хадгалуулав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Өмчлөгчийг төлөөлж:

Дорж аймгийн Арзгал сумын
Хөдөө Аж Ахуйн Тасгийн бэлчээр
хариуцсан мэргэжилтэн
Арзгал овогтой Баттөмөр
Гарын үсэг _____
Харилцах утас: 99463299


Эзэмшигчийг төлөөлж:

"Носн аугал" малчдын
бүлэг/БНХМН-ийн ахлагч
Дарь овогтой Баттөмөр
Гарын үсэг Баттөмөр
РД: 1073070515
Харилцах утас: 98876788

Хавсралт 1. Худаг эзэмшигч малчдын бүлэг, БНХМНөхөрлөлийн гишүүн өрхийн мэдээлэл

№	Овог нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар	Гарын үсэг
1.	А. Батталсар	11073070515	98876788	Батталсар
2.	Н. Болжигзор	11082040535	98432127	НЦСГ
3.	Д. Доржпурв	11098060913	98627739	Доржпурв
4.	Б. Батболд	11089122314	98896296	Батболд
5.	Х. Матаржав	11072031804	98267739	Матаржав
6.	Н. Олонбаяр	11078061339	98837992	Олонбаяр
7.	Д. Дэлгэрсайхан	11072081512	98433734	Д. Дэлгэрсайхан

Ноён худаг /Эрдэнэбүрэн Цураг баг/



ХАДЛАНГИЙН ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 09 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 01

Смг

Нэг. Газрын тухай үндэслэл

1.1 Монгол улсын "Газрын тухай хууль" "Байгаль орчныг хамгаалах тухай хууль", "Байгалийн ургамлын тухай хууль", "Байгалийн ургамал ашигласны төлбөрийн ухай хууль", "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль", "Газрын төлбөрийн тухай хууль", Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоол, өвс, техникийн ерөнхий шаардлага MNS 0592:2008, өвс тээвэрлэлтийн ерөнхий шаардлага №1NS 5647:2006-г тус тус үндэслэл болгон хадлангийн зориулалтаар олгох газрын эзэмшил, ашиглалт, хамгаалалт, хяналт, тээвэрлэлтийн үйл ажиллагааг нөхөрлөл, төрийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 311 дүгээр зүйл, *Ховд* аймгийн *Дорноц* сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07 дугаар сарын 28 ны өдрийн 9/03 тоот тогтоолыг үндэслэн нэг талаас *Ховд* аймгийн *Дорноц* сумын Засаг дарга *А. Цогзол-Увс* /цаашид "Засаг дарга" гэх/, нөгөө талаас *"Хурт толгой"* Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл /цаашид "нөхөрлөл" гэх/ -ийн ахлагч *А. Б. Цогзол* нар харилцан төхиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 2.2 *Хурт толгой* нөхөрлөл нь тус сумын хадлангийн ангилалд багтах *А. Б. Цогзол* нэртэй газар 2 га хадлангийн талбайг 2022 оны 09 дугаар сарын 15 ны өдрөөс 2032 оны 09 дугаар сарын 15 ны өдрийг хүртэл 10 жилийн хугацаанд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 311 дүгээр зүйлд заасны дагуу хадлангийн зориулалтаар эзэмшүүлэхээр тохиролцов.

Гурав. Засаг даргын эрх, үүрэг

- 3.1 Засаг дарга гэрээлэх хадлангийн талбайг нөхөрлөлд акт үйлдэн хүлээлгэн өгөх ба акт нь гэрээний салшгүй хэсэг болно. Актад хадлангийн талбайн байршил, хилийн зааг, эргэлтийн цэг, талбайн хэмжээ, нэгж талбарын дугаар, хадлангийн газрын төлөв байдлыг үнэлсэн мэдээллийг гэрээнд хавсаргана.
- 3.2 Нөхөрлөлтэй байгууллага гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэнэ.
- 3.3 Гэрээт хадлангийн талбайн ургацыг эрх бүхий этгээдээр жил бүр тогтоолгох
- 3.4 Нөхөрлөлийн гэрээний хадлангийн талбайд гарсан түймэр болон бусад байгалийн аюул гамшгийн үр шийг арилгуулах, шаардлагатай гэж үзвэл энэ ажилд иргэд аж ахуй нэгж, байгууллагыг татан оролцуулж туслалцуулна.
- 3.5 Хадлангийн газраа тухайн жил нөхөрлөлийн хүчээр бүрэн ашиглах боломжгүй бол нөхөрлөлтэй тохиролцон бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд гэрээт хадлангийн газарт хадлан бэлтгэх зөвшөөрөл олгож болно.

- 3.6 Нөхөрлөл нь энэхүү гэрээнд заасан үүрэг, холбогдох хууль тогтоомж, журмыг дараалсан хоёр жил биелүүлээгүй бол гэрээг хугацаанаас нь өмнө цуцална.
- 3.7 Нөхөрлөлтэй байгуулсан хадлангийн газар эзэмшүүлэх гэрээг холбогдох журамд заасан хугацаагаар сунгана.
- 3.8 Байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын 15 хувийг хадлангийн газрыг хамгаалж, сайжруулах арга хэмжээнд зарцуулж, сумын ИТХ-д тайлагнах

Дөрөв. Нөхөрлөлийн эрх, үүрэг

- 4.1 Нөхөрлөл нь гэрээт хадлангийн талбайг энэхүү гэрээний 2.2-д заасан зориулалтын дагуу, 3.1-д заасан төлөв байдлаас доройтуулахгүйгээр зохистой ашиглах
- 4.2 Нөхөрлөл нь жил бүр бэлтгэх хадлангийн хэмжээ, түүнээс орох төлбөрийн орлогын талаар тухайн жилийн ургац тогтоосон мэдээллийг үндэслэн Засаг даргатай жил бүр зөвшилцөн баталгаажуулах
- 4.3 Хадлангийн талбайгаа бусдад шилжүүлэхгүй, зөвшөөрөлгүй иргэн ААН-д ашиглуулахгүй байх
- 4.4 Газрын хөрс, ургамлын бүтцэд сөрөг нөлөө үзүүлдэг тоног төхөөрөмж, саран тармуур ашиглахгүй байх, тоног төхөөрөм, техник хэрэгсэлд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, ирийг 10 см-ээс доош тавихгүй байх
- 4.5 Гэрээт талбайд хадлан бэлтгэх хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм зөрчсөнөөс шалтгаалах түймрийн эрсдэлийг хариуцах. Энэ үүднээс техникийн аюулгүй байдлыг ханган ажиллах, гар унтраах хэрэгсэлтэй байх, тээврийн хэрэгслийн гал унтраагуур, яндангийн баригчтай байх
- 4.6 Хадлангийн газрын хөрсийг шалтгаалах, доройтлоос урьдчилан сэргийлэх зорилгоор салаа зам гаргахгүй байх, ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях
- 4.7 Тухайн жилийн бэлтгэсэн өвснөөс 2%-р тооцож, сумын өвсний фондод хандивлах
- 4.8 Бэлтгэсэн өвсийг нөхөрлөлийн гишүүд, сумын малчдад орон нутгийн ханшаар, үлдэх хэсгийг зах зээлд борлуулах
- 4.9 Тухайн жилийн ургамлын гарцаас шалтгаалан 08 сарын 15-с 10 сарын 1-ны дотор хадлан бэлтгэх
- 4.10 Хадлангийн бэлтгэж дууссаны дараа хадлангийн талбайн хог хаягдал, орчны бохирдлыг бүрэн арилгах

Тав. Хадлангийн төлбөр хураамж

- 5.1 Байгалийн ургамал ашигласны төлбөрийг "Элбэг ургамал" гэсэн ангиллын дагуу хадлангийн талбайгаас бэлтгэх өвсний 5 хувийг орон нутгийн талбай дээрх ханшаар үнэлж тооцно
- 5.2 Байгалийн ургамал ашигласны нийт төлбөр..... төгрөгийг сумын төрийн сангийн тоот дансанд хадлан эхлэхийн өмнө тушаана

Зургаа. Гэрээг цуцлах ба бусад асуудлууд

- 6.1 Нөхөрлөл нь гэрээлсэн хадлангийн газраас өөр газарт хадсан, гэрээнд заасан хэмжээнээс илүү газар хадсан, бусдын өвөлжөө-хаваржаанд 500 метрээс дотогш хадлан хийсэн, байгаль орчинтой зүй бус харьцаж гарз хохирол учруулсан тохиолдолд гэрээг цуцалж, Зөрчлийн тухай хуулийн 8.1 дэх заалтын дагуу хуулийн этгээдийг 3 сая төгрөгөөр торгоно.

- 6.2 Хадлангийн талбайд ил задгай хог хаягдал үүсгэсэн тохиолдолд зөрчлийн тухай хуулийн 6.1 дэх заалтыг үндэслэн хуулийн этгээдийг 300 мянган төгрөгөөр торгож зөрчлийг арилгуулна
- 6.3 Байгалийн ургамал ашигласны төлбөр төлөх, сумын аюулгүй фондод өвс нийлүүлэх үүргээ дараалсан 2 жил биелүүлээгүй тохиолдолд хадлангийн гэрээг цуцална
- 6.4 Гэрээ байгуулсан талуудын хооронд үүссэн маргааныг харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцож чадаагүй бол шүүхийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.
- 6.5 Нөхөрлөл гэрээнд заасан үүргээ зөрчиж, байгаль орчинд хохирол учруулсныг холбогдох мэргэжлийн байгууллагаас тогтоосон тохиолдолд гарсан хохирлыг нөхөрлөлийн гишүүдийн хөрөнгөөр бүрэн арилгуулах, нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авна.



ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Дурэн мөнхтэй нөхөрлөлийн
ахлагч Д.Батсүхтэй Д.Батсүхтэй
Хаяг: battsoojavirmed@gmail.com
Утас: 88436008


ХОВД АЙМАГ
ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 1129

Урд гол

Газар ашиглуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэр нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 23.4 дэх заалт, 52.2 дахь заалт, 2022 оны 09 сарын 23-ний сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын хуралдааны 07/04 дугаартай тогтоол, Тахилт багийн Иргэдийн Нийтийн Хурлын 2022 оны 09-р сарын 09-ний өдрийн хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тахилт багийн нутаг дэвсгэрт Худгийн ар орчмын газарт 3950 га өвлийн бэлчээрийн газрыг “Худгийн Ар” малчдын бүлэгт, Худгийн Ар орчмын газарт 3450 га өвлийн бэлчээрийг “Хөх сайр” малчдын бүлэгт тус тус 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

2. “Хөх сайр”, “Худгийн Ар” нэртэй малчдын бүлгүүдтэй Өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг газрын даамал (Г.Мөнхзул)-д зөвшөөрсүгэй.

3. Тухайн малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Г.Мөнхзул), ХААТ-ийн ус бэлчээр хариуцсан мэргэжилтэн (Т.Сэр-Од), Тахилт багийн Засаг дарга (Д.Алтантуяа) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.ОНОЛБААТАР

Zax-2022 A/



ХОВД АЙМАГ
ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/160

Хар ус

Малчдын бүлэгт газар
ашиглуулах тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалт, мөн хуулийн 23.4 дэх заалтын 2 дахь хэсэг, 2018 оны 03 сарын 14-ны сумын Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын хуралдааны 9/04 дугаартай тогтоол, Хонгио багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хонгио багийн нутаг дэвсгэрт Хаварзан хэмээх газар 2200 га өвлийн бэлчээрийн газрыг малчдын "Хаварзан" бүлэгт, Зурхайч орчмын газарт малчдын "Зурхайч" бүлэгт 4400 га өвлийн бэлчээрийг тус тус 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

2."Хаварзан", "Зурхайч" нэртэй малчдын бүлэгтэй Өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг газрын даамал (Б.Дэлгэрдалай)-д зөвшөөрсүгэй.

3.Тухайн малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Б.Дэлгэрдалай) ХААТ-ийн ус бэлчээр хариуцсан мэргэжилтэн (Ц.Гантөмөр), багийн Засаг дарга (Д.Батболд) нарт даалгасугай.



У.ЦЭРЭНТОГТОХ



ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
АВГАШ БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 1/06

Юмны эх

Хадлангийн газар эзэмшүүлэх тухай

Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, "Хүрэн толгой" хадлангийн бүлэг, нөхөрлөлөөс ирүүлсэн хадлангийн газар эзэмших хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Тус багийн нутаг дэвсгэрт Авгаш орчимд газрын нэгдмэл сангийн хадлангийн ангилалд хамрагддаг нийт 2 га хадлангийн талбайг "Хүрэн толгой" хадлангийн бүлэг нөхөрлөлд гэрээгээр эзэмшүүлэхигшиглуулахыг зөвшөөрсүгэй.
2. Хадлангийн газар эзэмшүүлэх гэрээний хугацааг 10 /арван/ жилээр тогтоохыг санал болгосугай.
3. "Хүрэн толгой" хадлангийн бүлэг, нөхөрлөлтэй хадлангийн газар эзэмшүүлэх гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг дарга (Л.Цэдэн-Иш)-д уламжилсугай.

ДАРГАЛАГЧ



Б.ЭРДЭНЭБААТАР



ХОВД АЙМГИЙН ДӨРГӨН СУМЫН
СЭЭР БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 4/3

Сээр

Г Бэлчээр гэрээгээр ашиглах хүсэлтийн тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалт, "Цом", нэртэй малчдын бүлэг, нөхөрлөлөөс ирүүлсэн бэлчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Тус багийн нутаг дэвсгэрт Цом орчимд нийт 3600 га өвлийн бэлчээрийг "Цом" малчдын бүлэгт гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.
2. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 (арван тав) жилээр тогтоохыг санал болгосугай.
3. "Цом" малчдын бүлэг, нөхөрлөлтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг дарга /Л.Цэдэн-Иш/-д уламжилсугай.

ДАРГАЛАГЧ



О.МӨНГӨНХҮҮ



ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 09/04

Сээр

Газар ашиглуулах, эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Сээр, Агваш багийн Иргэдийн Нийтийн хурлын тогтоолыг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1.Сээр багийн нутаг дэвсгэрт Цом орчимд нийт 3600 га өвлийн бэлчээрийг "Цом" малчдын бүлэгт 15 жилээр гэрээгээр ашиглуулах

2.Агваш багийн нутаг дэвсгэрт Агваш орчимд газрын нэгдмэл сангийн хадлангийн ангилалд хамрагддаг нийт 2 га хадлангийн талбайг "Хүрэн толгой" хадлангийн бүлэг нөхөрлөлд 10 жилээр эзэмшүүлэх.

3."Цом" малчдын бэлчээр ашиглагчдын бүлэг, нөхөрлөл, "Хүрэн толгой" хадлангийн бүлэг нөхөрлөлтэй гэрээ байгуулахыг сумын Засаг дарга (Л.Цэдэн-Иш)-д даалгасугай.

ДАРГА



А. БАТЦОЖ



ХОВД АЙМАГ
ДӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/58

Сээр

Газар ашиглуулах тухай

Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтын 2 дахь хэсэг, Сээр багийн Иргэдийн Нийтийн Хурлын тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сээр багийн нутаг дэвсгэрт Цом уул орчмын газарт 3600 га өвлийн бэлчээрийн газрыг малчдын Цом бүлэгт 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

2.“Цом” нэртэй малчдын бүлэгтэй Өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг Газрын даамал (Б.Ганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тухайн малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Б.Ганцэцэг), Хөдөө аж ахуйн мэргэжилтэн (Л.Содномцэрэн), Сээр багийн Засаг дарга (Ц.Энхбат) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Л.ЦЭДЭН-ИШ



ХОВД АЙМАГ
МЯНГАД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын өдөр

Дугаар А/35

Баянхонгор

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Чацарганат багийн Иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чацарганат багийн нутаг дэвсгэрт Мөрөн орчмын газар 950 (есөн зуун тавин) га өвлийн бэлчээрийн газрыг "Дэлгэрэнмөрөн 13" малчдын бүлэгт, Мөрөн орчмын газарт "Баруун Дэлгэрмөрөн" малчдын бүлэгт 600 га /Зургаан зуу/ өвлийн бэлчээрийг тус тус 15 (арван таван) жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

2. "Дэлгэрмөрөн 13", Баруун Дэлгэрмөрөн" нэртэй малчдын бүлэгтэй өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг Газрын даамал (Ц.Цэцэгмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Цэцэгмаа), Хөдөө аж ахуйн тасаг (Ж.Эрхбаяр), Чацарганат багийн Засаг дарга (Г.Батсүх) нарт даалгасугай.

 М.БААТАР



ХОВД АЙМАГ
МЯНГАД СУМЫН ЧАЦАРГАНАТ БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 3/04

Чацарганат

Бэлчээр гэрээгээр ашиглах хүсэлтийн тухай

Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, "Дэлгэрмөрөн 13", "Баруун Дэлгэрмөрөн" нэртэй малчдын бүлгүүдээс ирүүлсэн бэлчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1.Тус багийн нутаг дэвсгэрт Мөрөн орчимд 950 га өвлийн бэлчээрийг "Дэлгэрмөрөн 13" малчдын бүлэгт, 600 га өвлийн бэлчээрийг "Баруун Дэлгэрмөрөн" малчдын бүлэгт тус тус гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2.Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 (арван тав) жилээр тогтоохыг санал болгосугай.

3."Дэлгэрмөрөн 13", "Баруун Дэлгэрмөрөн" малчдын бүлэг, нөхөрлөлтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг дарга /М.Баатар/-д уламжилсугай.

ХУРАЛДААНЫ ДАРГА  Н.МӨНГӨНХҮҮ /





ХОВД АЙМГИЙН ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН
ХОНГИО БАГИЙН ИРГЭДИЙН
НИЙТИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/7

Хонгио

Бэлчээр гэрээгээр ашиглах хүсэлтийн тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалт, 2018 оны 01 сарын 30 ны өдрийн Хонгио багийн иргэдийн нийтийн хурлын тогтоолыг үндэслэн малчдын "Хаварзан", Зурхайч нэртэй малчдын бүлэг, нөхөрлөлөөс ирүүлсэн бэлчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Тус багийн нутаг дэвсгэрт Хаварзан орчимд нийт 2200 га өвлийн бэлчээрийг "Хаварзан" малчдын бүлэгт
2. Зурхайч орчимд нийт 4400 га өвлийн бэлчээрийг Зурхайч" малчдын бүлэгт тус тус гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.
3. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 (арван тав) жилээр тогтоохыг санал болгосугай.
4. Хаварзан, Зурхайч малчдын бүлэг, нөхөрлөлтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг дарга А.Цэрэнтогтох /-д уламжилсугай.

ДАРГАЛАГЧ



/ Б.БҮРЭНЗЭВСЭГ /



ХОВД АЙМАГ
ЦЭЦЭГ СУМЫН ХАЖИНГА БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

᠒᠐᠒᠒ оны ᠐᠑ сарын ᠒5 өдөр

Дугаар ᠐7

Хажинга

Бэлчээр гэрээгээр ашиглах
хүсэлтийн тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтын дагуу малчдын Дунд Хажинга бүлгээс ирүүлсэн бэлчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Тус багийн нутаг дэвсгэрт Дунд амнаас Худгийн ам орчимд нийт 12736 га талбай бүхий өвөл, хаврын бэлчээрийг малчдын Дунд Хажинга бүлэгт гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.
2. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 (арван тавь) жилээр тогтоохыг санал болгосугай.
3. Урд Хажинга малчдын бүлэгтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг Сумын Засаг дарга Ж.Мөнхзориогт уламжилсугай.

ДАРГАЛАГЧ



Б.ПҮРЭВХҮРЭЛ



ХОВД АЙМАГ
ЦЭЦЭГ СУМЫН ХАЖИНГА БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТВИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 06

Хяалтга

Бэлчээр гэрээгээр ашиглах
хүсэлтийн тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтын дагуу малчдын Урд Хажинга бүлгээс ирүүлсэн бэлчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Тус багийн нутаг дэвсгэрт Урд амнаас Дунд ам орчимд нийт 9262 га өвөл, хаврын бэлчээрийг малчдын Урд Хажинга бүлэгт гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.
2. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 (арван тав) жилээр тогтоохыг санал болгосугай.
3. Урд Хажинга малчдын бүлэгтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг Сумын Засаг дарга Ж.Мөнхзоригт уламжилсугай.

ДАРГАЛАГЧ



Б.ПҮРЭВХҮРЭЛ



ХОВД АЙМАГ
ЦЭЦЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/23

Цацраг нуур

Бэлчээр ашиглуулах тухай

Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Хажинга багийн Иргэдийн Нийтийн Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 06,07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИАРМЖЛАХ нь:

1. Хажинга багийн нутаг дэвсгэрт Урд Хажинга малчдын бүлэгт 9262га, Дунд Хажинга малчдын бүлэгт 12736 га Өвөл, Хаврын бэлчээрийн газрыг малчдын Урд Хажинга, Дунд Хажинга бүлэгт 15 жилийн хугацаатай гэрээгээр ашиглуулсугай.

2. Дунд Хажинга, Урд Хажинга бүлэгтэй Өмчлөлийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын Газрын даамал (А.Гандеш)-д зөвшөөрсүгэй.

3. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бэлчээр нутгаа газар нутгийн маргаан гаргалгүй зөв зохистой ашиглахыг бүлгийн гишүүд, Урд Хажинга бүлгийн ахлагч (Ч.Дүгэрсүрэн), Дунд Хажинга бүлгийн ахлагч (Т.Мөнхбаатар) нарт даалгасугай.

4. Малчдын бүлгээс гэрээт бэлчээрийг ашиглаж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Хажинга багийн Засаг дарга (Н.Батчулуун), Хүнс хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн (Д.Төмөрхуяг), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Д.Золзаяа) нарт даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Одонбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж МӨНХЗОРИГ

Zax-2022



ХОУД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН
АЛТАН АДАС БАЙ ИЙШ ИРЭЭВИЙН ПИЙГИЙН
ХУРЫН ХУРАЛДААНЫ ТОГТОУЛ

2022 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 01

Төрөл

БҮЛЭГЛЭГ ГЭРЭГЭЭР АШИГЛЭУЛАХ
ТУХАЙ

Монгол улсын өмгөөлөгч, нутаг дэвсгэрийн нэгж, түүнийг удирддаггүй түрэг хуулийн 32.5 ба 36.1.2 - хэсгээр, Төрийн түрэг дүрлэг - 52 д дэх заалтын дагуу мөрдөх "Бичиг бар" бичиг бар, нэртэй бичиг бар, нэртэй бичиг бар түрэг хуулийн хэмжээг ТОГТООХ юм.

1. Ашигласа бичиг бар нэртэй дэвсгэр (Бичиг бар, Хоёр тал, Бичиг бар, Дөрөв, Хоёр тал, Хоёр тал, Хоёр тал, Хоёр тал) үзүүлж, тэдгээрийн 4425 тн өсөөг хэсгийн бичиг барыг мөрдөх "Бичиг бар" бичиг барын өмгөөлөгчийн хөшөөг бичиг бар.
2. Ашигласа бичиг барын нэртэй дэвсгэр 15 дүр талын өмгөөлөгчийн бичиг бар.
3. "Бичиг бар" бичиг бар бүрт бичиг бар нэртэй бичиг барын бичиг барын дэвсгэр бичиг бар, бичиг барын 15 дүр талын өмгөөлөгчийн бичиг бар.



Даргаар /Хүндэтгэн/ /Хүндэтгэн/



ХӨД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН
АЛТАНГАДАС БАГИЙН ИРЭЭГИЙН ШИЙТИЙН
ХУВИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 02

Тамга

БЭЛНЭЭР ГЭРЭГТЭЭР АШИГЛАХ
ТУХАЙ

Монгол улсын зөвхөн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн 100% тусгай үндэслэлтэй 2009 оны 12.6, 2012- оны 04.12- өдөр болон үүний дараахь 2017 оны 04.27- өдөр зарласан "Алтангадаг Б-ийн-Ирээ" бусад хөрөнгийн Сангаар үйлчилгээний хувьцааг үйлдвэрлэлийн хэлтэсэд ТӨТГЭХ нь.

1. Алтангадаг багийн нутаг дэвсгэр (Хэрин, Олон өвс, Бэлгийн газарноос, Адуу үхэр шал орчимд нийт 3507.6 га) -ыг захиргаа Сангаарийн мөчлөг "Алтангадаг Б-ийн-Ирээ" багийн захиргааг хяналтлуулахыг зөвшөөрсүгэй.
2. Бэл-Аар шилжүүлэх өмчлөлийн хугацааг Төрийн захиргаагийн төлөөлөгчид.
3. Алтангадаг бусад хөрөнгийн бусад Бэл-Аар шилжүүлэх гэрээ байгуулахыг дараахь сангийн бүтэц - Эвэл дараах үйлдвэрлэлтэй тусламжлуулгай.



ДАРГА Д. АНХБААТУ



ХОВД АЙМАГ
АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/141

Ховд-Өндөр

Газар ашиглуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дэхь заалт, 23 дугаар зүйлийн 23.4.2 Алтангадаас багшын иргэдийн нийтийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтангадаас багийн нутаг дэвсгэр Шүүрэгтэй, Хар нагс, Зүүн сувээ, Ширээ, Хөх эмэгтэй, Хос дэлийн үзүүр, хэмээх газарт 4425 га өвөл, хаврын бэлчээрийн газрыг малчдын "Баянбэлчээр" бүлэгт 15 жилийн хугацаанаар гэрээгээр ашиглуулсугай.

2. "Баянбэлчээр" бүлэгтэй өмчлөчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг Газрын даамал (Б.Түмэндэмбэрэл)-д зөвшөөрсугай.

3. Тухайн малчдын бүлэгт бэлчээс ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн, хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Б.Түмэндэмбэрэл), Хөдөө аж ахуйн тасгийн бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (Д.Гэндолгор), Алтангадаас багийн Засаг дарга (Д.Цогбадрах) нарт үүрэг болгосугай.



Х.ТҮМЭНЦЭЛГЭР



ХӨВД АЙМАГ
АЛТАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/192

Хөвд-Төгрөг

Газар ашиглуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.4.2, Алтангадаас бөгийн исгэдийн нийтийн журлын 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтангадаас бөгийн нутаг дэвсгэр Гүжрэн, Олон өвс, Бишийн хаваржаа, Адууны хашаа хамрах газарт 2607 га өвөл, хаврын бэлчээрийн газрыг малчдын "Алтангадаас есан эрдэнэ" бүлэгт 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

2. "Алтангадаас есан эрдэнэ" бүлэгтэй өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг Газрын даргаан (Б.Түмэндэмбэрэл)-д зөвшөөрсүгэй.

3. Тухайн малчдын бүлэгт бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн, хяналт тавьж ажиллахыг Газрын даргаан (Б.Түмэндэмбэрэл), Хөдөө аж ахуйн тасгийн бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (Д.Гандолгор), Алтангадаас бөгийн Засаг дарга (Д.Цогбадрах) нарт үүрэг болгосугай.



Х.ТҮМЭНДЭЛГЭР



ХОВД АЙМАГ
ҮЙНЧ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар 4/04/4

Хан утгуур

Бэлчээр ашиглуулах тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалт, мөн хуулийн 23.4 дэх заалтын 2 дахь хэсэг, Цагаан түнгэ багийн иргэдийн нийтийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 03 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цагаан түнгэ багийн нутаг дэвсгэрт Урьд хөвч хэмээх газар 4375 га өвөл, хаврын бэлчээрийн газрыг "Урьд хөвч" малчдын бүлэгт 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

2. "Урьд хөвч" бүлэгтэй өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг газрын даамал (Х.Солонго)-д зөвшөөрсүгэй.

3. Тухайн малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Х.Солонго), Хөдөө аж ахуйн ус бэлчээр хариуцсан мэргэжилтэн (Л.Алимаа), багийн Засаг дарга(Э.Аззаяа) нарт даалгасугай.



Э.УРТНАСАН



ХОВД АЙМАГ БУЛГАН СУМ
БАЙТАГ БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

[Handwritten signature]

[Handwritten signature]

[Handwritten signature]

Балчээр гэрээгээр ашиглах тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтын дагуу малчдын Тэрэм хэд бүлэг, нөхөрлөлөөс ирүүлсэн балчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Тус багийн нутаг дэвсгэрт Тэрэм хэд орчимд нийт 3,4 га нөөц хаврын Балчээрийн малчдын Тэрэм хэд бүлэг, нөхөрлөлд гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй
2. Балчээр ашиглуулах гэрээний хугацааг 5 (таван) жилээр тогтоохыг санал болгосугай.
3. Тэрэм хэд малчдын бүлэг, нөхөрлөлтэй балчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг дарга /Ж.Дамдин-Базар/-т уламжилсугай

ДАРГАЛАГЧИ

[Handwritten signature]

/А.БАТМӨНХ/



ХОВДАЙМАГ
БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/169

Бүрэнхайрхан

Газар ашиглуулах тухай

Газрын тухай Монгол Улсын хуулийн 52.2 дахь заалт, мөн хуулийн 23.4, Байтаг Багийн Иргэдийн Нийтийн Хурлын 2022 оны 04 сарын 20-ны өдрийн хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байтаг багийн нутаг дэвсгэрт Тэрэм хад хэмээх газар 3,4 га өвөл, хаврын бэлчээрийн газрыг малчдын Тэрэм хад бүлэгт 5 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.
2. Тэрэм хад бүлэгтэй Өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг газрын даамал (С.Ганцоож)-д зөвшөөрсүгэй.
3. Тухайн малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хяналт тавьж ажиллахыг газрын даамал (С.Ганцоож), Хөдөө аж ахуйн мэргэжилтэн (Д.Батхуяг), багийн Засаг дарга (У.Ганбат) нарт даалгасугай.



Ж ДАМДИНБАЗАР



ХОВД АЙМАГ
МӨСТ СУМЫН ХУЖИРТ БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 03

Давст

Бэлчээр гэрээгээр ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22 дахь заалт, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Малчдын "Элстийн ам" бүлэгт ирүүлсэн бэлчээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Хужирт багийн нутаг дэвсгэр Элст, Худгын хар, Уртын сайр орчимд нийт 2607,96 га өвлийн бэлчээрийг малчдын "Элстийн ам" бүлэгт гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.
2. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 жилээр тогтоохыг санал болгосугай.
3. "Элстийн ам" бэлчээрийн бүлэгт бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг Сумын Засаг дарга /С.Баасандорж/-д уламжилсугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ  Г.Боржуу





ХОВД АЙМАГ
МӨСТ СУМЫН ЦЭЦЭГ ГОЛ БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 04

Давст

Бэлчээр гэрээгээр ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22 дахь заалт, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Малчдын "Шар булаг" бүлэгт ирүүлсэн бэлчээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ.

1. Цэцэг гол багийн нутаг дэвсгэр Шар булгийн орчимд нийт 1203.26 га өвөл, хаврын бэлчээрийг малчдын "Шар булаг" бүлэгт гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 жилээр тогтоохыг санал болгосугай.

3. "Шар булаг" бэлчээрийн бүлэгт бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг Сумын Засаг дарга /С.Баасандорж/-д уламжилсугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ Р.Тамгасүрэн Р.Бямбасүрэн





ХОВД АЙМАГ
МӨСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 2/157

Улаангоолой

Бэлчээр ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.22 дахь заалт, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хужирт багийн нутаг дэвсгэрт Элэстийн ам малчдын бүлэгт 2607,96 га, Цэцэг гол шар булаг малчдын бүлэгт 1203,26 га Өвөл, Хаврын бэлчээрийн газрыг малчдын элэстийн ам, шар булаг бүлэгт 15 жилийн хугацаатай гэрээгээр ашиглуулсугай.

2. Элэстийн ам, Шар булаг бүлэгтэй Өмчлөлийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын Газрын даамал /О.Пүрэвдаш/- д зөвшөөрсүгэй.

3. Монгол улсын хууль тогтоомжийн дагуу бэлчээр, газар нутгийн маргаан гаргалгүй зөв зохистой ашиглахыг бүлгийн гишүүд, Элэстийн ам бүлгийн ахлагч /Г.Ганмямар/, Шар булаг бүлгийн ахлагч /Б.Энх-амгалан/ нарт даалгасугай.

4. Малчдын бүлгээс гэрээт бэлчээрийг ашиглаж буй байдалд хяналт тавьж ажиллахыг Хужирт багийн засаг дарга /Г.Буяндэлгэр/, Хүнс хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн /Б.Идэрбаян/, Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Б.Алтангэрэл/, Цэцэг гол багийн засаг дарга /Д.Лхагвадорж/ нарт даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Н.Цогоо/- д үүрэн болгосугай.

ДАРГА  С.БААСАНДОРЖ





ХОВД АЙМАГ
ДАРВИ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/151

Булган

Бэлчээр ашиглуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь заалт, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянбулаг багийн нутаг дэвсгэрт Бүлтгэр улаан булаг малчдын бүлэгт 37.000 га /гучин долоон мянган /, Дэлгэр багийн нутаг Өгөөмөр ноёны хүрэн малчдын бүлэгт 55.000 га /тавин таван мянган/, Мөрөн багийн нутаг дэвсгэрт Баян хөвхөр малчдын бүлэгт 77.805.08 га /далан долоон мянга найман зуун тав зууны найм/ өвөл хаврын бэлчээрийн газрыг дээрх бүлгүүдэд 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.
2. Бүлтгэр улаан булаг, Өгөөмөр ноёны хүрэн, Баян хөвхөр бүлэгтэй өмчлөлийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг газрын даамал /Д.Ившинхорол/-д зөвшөөрсүгэй.
3. Монгол улсын хууль тогтоомжын дагуу бэлчээр газар нутгаа маргаангүй зүй зохистой ашиглахыг бүлгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.
4. Малчдын бүлгээс гэрээт бэлчээрийг зүй зохистой ашиглаж буйд байнгын хяналт тавьж ажиллахыг Баянбулаг багийн Засаг дарга /Ш.Тэгшбуян/, Дэлгэр багийн Засаг дарга /М.Орхон/, Мөрөн багийн Засаг дарга /Ш.Алтансүх/, Газрын даамал /Д.Ившинхорол/, ХАА-Н мэргэжилтэн /Л.Рэжийбуу/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.ГАНЦООЖ





ХОВД АЙМАГ
БУЯНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/134

Зургаа

Малчид бэлчээр гэрээгээр ашиглах хүсэлтийг
дэмжих тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалт, мөн хуулийн 23.4 дэх заалтын 2 дахь хэсэг, Наранхайрхан, Цагаан эрэг багуудын Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 9-р сарын 17-ны өдрийн хуралдааны 01, 02, 03 дугаар тогтоолуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Наранхайрхан багийн нутаг дэвсгэрт “Сүүлийн бэл” хэмээх газарт өвөл, хаврын бэлчээрийн газрыг малчдын “Морьт” бүлэгт 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

2. Наранхайрхан багийн нутаг дэвсгэрт “Хужрын булан” хэмээх газарт өвөл, хаврын бэлчээрийн газрыг малчдын “Наранхайран” бүлэгт 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

3. Цагаан эрэг багийн нутаг дэвсгэрт “Баян сайр” хэмээх газарт өвөл, хаврын бэлчээрийн газрыг малчдын “Баянлаг” бүлэгт 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

4. Морьт, Наранхайрхан Баянлаг бүлэгүүдтэй Өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг газрын даамал /Л.Баасанхүү/-д зөвшөөрсүгэй.

5. Тухайн малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хяналт тавьж ажиллахыг газрын даамал /Л.Баасанхүү/, ХХАА-н тасгийн мэргэжилтэн /А.Гантулга/, Наранхайрхан багийн Засаг дарга /Н.Батмөнх/, Цагаан эрэг багийн Засаг дарга /Я.Загд –Очир/ нарт даалгасугай.

ДАРГА

Б.ТҮВШИНСАЙХАН





ХОВД АЙМАГ
БУЯНТ СУМЫН
ЦАГААН ЭРЭГ БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны 09 сарын 17-нд

Дугаар 01

Захын гуу

Малчид бэлчээр гэрээгээр ашиглах
хүсэлтийг дэмжих тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтын дагуу малчдын Баянлаг нөхөрлөлөөс ирүүлсэн бэлчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Тус багийн нутаг дэвсгэрийн Баянсайр орчимд нийт газрыг өвөл, хаврын бэлчээрийг малчдын Баянлаг бүлэг нөхөрлөлд гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.
2. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 (арван тав) жилээр тогтоохыг санал болгосугай.
3. Баянлаг малчдын бүлэг, нөхөрлөлтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг багийн Засаг дарга /Я.Загд-Очир/-д үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ *М. Цогмандах* Т.ЦОГМАНДАХ





ХОВД АЙМАГ
БУЯНТ СУМЫН
НАРАНХАЙРХАН БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 17-нд

Дугаар 02

Таван хайрхан

Малчид бэлчээр гэрээгээр ашиглах
хүсэлтийг дэмжих тухай

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтын дагуу малчдын Морьт нөхөрлөлөөс ирүүлсэн бэлчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. Тус багийн нутаг дэвсгэрийн Сүүлийн бэл орчимд нийт газрыг өвөл, хаврын бэлчээрийг малчдын Морьт бүлэг нөхөрлөлд гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 (арван тав) жилээр тогтоохыг санал болгосугай.

3. Морьт малчдын бүлэг, нөхөрлөлтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг багийн Засаг дарга / Н.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Н.ГАНТУЛГА



**ХОВД АЙМАГ
БУЯНТ СУМЫН
НАРАНХАЙРХАН БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 12-нд

Дугаар 02

Таван хайрхан

**Малчид бэлчээр гэрээгээр ашиглах
хүсэлтийг дэмжих тухай**

Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтын дагуу малчдын Наранхайрхан нөхөрлөлөөс ирүүлсэн бэлчээр гэрээгээр ашиглах тухай хүсэлтийг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

1. Тус багийн нутаг дэвсгэрийн Хужрын булан орчимд нийт ~~06~~ газрыг өвөл, хаврын бэлчээрийг малчдын Наранхайрхан бүлэг нөхөрлөлд гэрээгээр ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. Бэлчээр ашиглуулах гэрээний хугацааг 15 (арван тав) жилээр тогтоохыг санал болгосугай.

3. Наранхайрхан малчдын бүлэг, нөхөрлөлтэй бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг багийн Засаг дарга / Н.Батмөнх/-д үүрэг болгосугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Н.ГАНТУЛГА



ХОВД АЙМАГ
ДУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/94

Босго

Бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах тухай

Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2, дахь заалт мөн хуулийн 23.4 дэх заалтын 2 дахь хэсэг, Шивэр багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 01,02 дугаар тогтоол, Цагаанбургас багийн Иргэдийн нийтийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шивэр багийн Баянбулагт 8081.4 га , Шар жалгад 1580.5 га , Цагаанбургас багийн Усны эх хэмээх газарт 926.3 га өвөл, хаврын бэлчээрийн газрыг малчдын бүлэгт 15 жилийн хугацаагаар гэрээгээр ашиглуулсугай.

2.Баянбулаг, Шар жалга, Усны эх бүлэгтэй өмчлөгчийг төлөөлж бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг газрыг даамал /Д.Сэргэлэн/д зөвшөөрсүгэй.

3.Тухайн малчдын бүлэг, нөхөрлөлийн бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийг жил бүр дүгнэн хяналт тавьж ажиллахыг газрын даамал /Д.Сэргэлэн/ Хөдөө аж ахуйн бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн / Ж.Занданхүү/, багийн Засаг дарга /М.Батцэнгэл, А.Бадамханд / нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ГАНЗОРИГ



ХОВД АЙМАГ
ДУУТ СУМЫН ШИВЭР БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 02

Шивэр

「УРТ ХУГАЦААНЫ ГЭРЭЭГЭЭР БЭЛЧЭЭР,
УС АШИГЛУУЛАХ ТУХАЙ

Байгаль хамгаалах тухай хуулийг 51-р зүйл, Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтыг үндэслэн “Баянбулаг” бүлэгт байгалийн бэлчээр, усыг гэрээгээр ашиглуулах тухай “Баянбулаг” бүлгийн хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. “Баянбулаг” бүлэгт тус багийн нутаг дэвсгэрт Баянбулаг орчимд 8 га газрыг өвөл, хаврын бэлчээр, усыг “Баянбулаг” бүлэгт гэрээгээр ашиглуулахыг зөшөөрсүгэй.

2. Бэлчээр ашиглалтын гэрээний хугацааг арван таван жилээр тогтоохыг санал болгосугай.

3. Малчдын “Баянбулаг” бүлэгт бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг дарга /С. Ганзориг/-д уламжилсугай.



ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ *С. Ганзориг* ЦГАНХУЯАГ



ХОВД АЙМАГ
ДУУТ СУМЫН ШИВЭР БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 01

Шивэр

Гурт хугацааны гэрээгээр бэлчээр,
ус ашиглуулах тухай

Байгаль хамгаалах тухай хуулийг 51-р зүйл, Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтыг үндэслэн “Шар жалга” бүлэгт байгалийн бэлчээр, усыг гэрээгээр ашиглуулах тухай “Шар жалга” бүлгийн хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. “Шар жалга” бүлэгт тус багийн нутаг дэвсгэрт Шар жалга орчимд 1,4 га газрыг өвөл, хаврын бэлчээр, усыг “Шар жалга” бүлэгт гэрээгээр ашиглуулахыг зөшөөрсүгэй.

2. Бэлчээр ашиглалтын гэрээний хугацааг арван таван жилээр тогтоохыг санал болгосугай.

3. Малчдын “Шар жалга” бүлэгт бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг дарга /С. Ганзориг/-д уламжилсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Ц.ГАНХУЯАГ



ХОВД АЙМАГ
ДУУТ СУМЫН ЦАГААНБУРГАС БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙГИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 03

Цагаанбургас

УРТ ХУГАЦААНЫ ГЭРЭЭГЭЭР БЭЛЧЭЭР, УС
АШИГЛУУЛАХ ТУХАЙ

Байгаль хамгаалах тухай хуулийг 51-р зүйл, Газрын тухай хуулийн 52.2 дахь заалтыг үндэслэн “Усны эх” бүлэгт байгалийн бэлчээр, усыг гэрээгээр ашиглуулах тухай “Усны эх” бүлгийн хүсэлтийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

1. “Усны эх” бүлэгт тус багийн нутаг дэвсгэрт Усны эх орчимд 1 га газрыг өвөл, хаврын бэлчээр, усыг “Шар жалга” бүлэгт гэрээгээр ашиглуулахыг зөшөөрсүгэй.
2. Бэлчээр ашиглалтын гэрээний хугацааг арван таван жилээр тогтоохыг санал болгосугай.
3. Малчдын “Усны эх” бүлэгт бэлчээр ашиглуулах гэрээ байгуулахыг дэмжих саналыг сумын Засаг дарга /С. Ганзориг/-д уламжилсугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



М.ГАНТУЛГА



ХОВД АЙМАГ
МАНХАН СУМЫН
БАЯНГОЛ БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 06

Баянгол


Г Малчдын бүлгийн 7
хүсэлтийг дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, малчдын "ДАЛАН" бүлгийн хүсэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус багийн малчдаас үүсгэн байгуулсан бүлгээс бэлчээр (өвөлжөөний, хаваржааны, өвөлжөө- хаваржааны аль нь болохыг тодруулж бичих) гэрээгээр ашиглахаар ирүүлсэн хүсэлтийг дэмжиж, сумын Засаг даргад уламжилсугай.

2. Дурдсан бүлгээс сумын Засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллахыг багийн Засаг дарга (Х.Алтангэрэл)-д даалгасугай.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ *Н. Галсүх* Н.ГАЛСҮХ





ХОВД АЙМАГ
МАНХАН СУМЫН
ТАХИЛТ БАГИЙН
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 05


Тахилт

Малчдын бүлгийн
хүсэлтийг дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, малчдын "ОНЦ ТОЛГОЙ" бүлгийн хүсэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус багийн малчдаас үүсгэн байгуулсан бүлгээс бэлчээр (өвөлжөөний, хаваржааны, өвөлжөө- хаваржааны аль нь болохыг тодруулж бичих) гэрээгээр ашиглахаар ирүүлсэн хүсэлтийг дэмжиж, сумын Засаг даргад уламжилсугай.

